

АГУУЛГА

- Ж.Занаа
Эмэгтэйчүүдийн улс төрийн эрх, оролцоог сайжруулахад тулгарч буй асуудал, бэрхшээлүүд 3
- Д.Биндэръяа
Жендэрийн хандлагыг хууль, эрх зүйн шинэчлэлд тусгаж буй төрийн бодлого 8
- М.Болормаа
Жендэрийн асуудлаархи үндэсний тогтолцоог хэрхэн бий болгох вэ? 15
- Д.Мөнхөө
Нөхөн үржихүйн эрх хүний эрхийн салшгүй хэсэг болох нь 27
- Д.Энхжаргал
“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилт 38
- Т.Амгалан
Ядуурал ба эмэгтэйчүүдийн хүний эрх 44
- С.Түмэндэлгэр
Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалт: хөдөлмөрийн зах зээл дэх гажуудал 50
- Н.Чинчулуун
Ажлын байран дахь бэлгийн дарамтлалыг зохицуулах эрх зүйн орчин шаардлагатай байна 57
- Б.Онон
Соёл уламжлал: эмэгтэйчүүдийн хүний эрх 60
- Б.Тогтохбаяр
Жендэрийн тэгш эрхийн онолын асуудал ба, Монголын соёл уламжлал хэвлэл мэдээллийн бодлогод нөлөөлж байгаа нь 72
- Н.Анараа
Амьдрах эрхгүй хүмүүс: Монголын ардчилал, хөгжлийн явц дахь лесбиан, гей, бисексуал, трансжендер (ЛГБТ) хүмүүсийн хүний эрх 80
- Шарлот Банч
Хүний эрх - хүнлэг энрэнгүй нийгмийн үндэс 99

CONTENT:

- J. Zanaa
Issues and Obstacles on the Way of Improving Women's Political Rights and Participation 3
- D. Binderya
State Policy on Mainstreaming Gender into Legal Reform 8
- M. Bolormaa
How to Create a National Mechanism on Gender Mainstreaming? 15
- D. Munkhuu
Reproductive Rights as Indivisible Part of Human Rights 27
- D. Enkhjargal
On Implementation of the Law Against Domestic Violence 38
- T. Amgalan
Poverty and Women's Human Rights 44
- S. Tumendelger
Discrimination Against Women: Distortions at Labour Market 50
- N. Chinchuluun
Mongolia Needs Legal Environment to End Sexual Harassment at Work Place 57
- B. Onon
Culture, Traditions and Women's Human Rights 60
- B. Togtokhbayar
Theory of Gender Equality and Influence of Mongolian Culture and Traditions on Media Policies 72
- N. Anaraa
Life Denied: LGBT Human Rights in the Context of Mongolia's Democratisation & Development 80
- Charlotte Bunch
Human Rights as the Foundation for a Compassionate Society
(re-printed from ed. Afkhami, Mahnaz (2002) *Toward A Compassionate Society*, Women's Learning Partnership, pp.16-20) 99

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН УЛС ТӨРИЙН ЭРХ, ОРОЛЦООГ САЙЖРУУЛАХАД ТУЛГАРЧ БУЙ АСУУДАЛ, БЭРХШЭЭЛҮҮД

*Ж.Занаа,
Иргэдийн Альянс төвийн захирал, докторант*

Үндсэн хуульд “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй” гэж заасан байдаг. Гэвч эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн улс төрийн эрхийн хэрэгжилт адил, тэгш биш байгааг хүн бүр мэдэж байна.

Монгол улс НҮБ-аас баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний ба улс төрийн эрхийн олон улсын Пактад 1968 онд нэгдэн орсон нь “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэж Үндсэн хуулийн 10-р зүйлд заасан дагуу хэрэгжих ёстойг цохон тэмдэглэх нь зүйтэй юм.

Монгол улс эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийг хуульдаа хэрхэн баталгаажуулж байсныг товч дурдъя. 1924 онд баталсан анхны Үндсэн хуульд “Тус улсын харьяат ард түмэн угсаа, шашин шүтлэг, эрэгтэй, эмэгтэй хэмээх ялгаварлалгүйгээр нэгэн адил эрхийг эдэлбэл зохино” гэж заасан байдаг ба 1925 онд эмэгтэйчүүдийг богтлох явдлыг хориглож, 1926 онд эмэгтэйчүүдийн иргэний эрхийг Шүүх цаазын баримт бичигт хуульчилж өгчээ. 1990 оноос өмнө Улсын Их, Бага хурлуудад төлөөлөгчөөр оролцуулах эмэгтэйчүүдийн тоог тогтоож, боловсрол, эрүүл мэнд, мал аж ахуй, хөдөө аж ахуйн зэрэг салбарт ажилладаг тэргүүний эмэгтэйчүүдийг томилон “сонгож” ажиллуулдаг байлаа. Эдгээр хурлуудад эмэгтэйчүүдийн төлөөлөл 20-23 хувьд хүрч байсан ба орлогч сайдаар томилогдож байсан эмэгтэйчүүд 2-оос илүүгүй байсан ба гол төлөв нийгмийн асуудал хариуцсан салбарын яам, газруудад байсан байна. Харин 1990 оноос өрнөсөн хуучин дэглэмийг ардчилсан замаар өөрчлөх явцад эмэгтэйчүүд идэвхитэй оролцож улс төрийн өлсгөлөн, суулт, цуглаан, жагсаал, ардчиллын төлөөх намуудын хурал, чуулганыг зохион байгуулах зэрэг ажлуудыг гүйцэтгэхэд оролцож оюуны ба бодит хандив, тусламжийг оруулж байсан. Эмэгтэйчүүд 1990, 1992, 1996 онд болсон олон шатны сонгуульд удаа дараа оролцож, нэрээ дэвшүүлж байсан боловч дөнгөж 10 хүртэл хувиар сонгогдож байсан нь хүн амын 50,4 хувийг эзэлж байгаа эмэгтэйчүүдийн хувьд маш чамлалтай үзүүлэлт юм.

Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн хэрэгжилт муу байгаагийн шалтгааныг төр, засгаас нэг ч удаа судалж байсангүй. Харин 1990-ээд

оноос шинээр үүсэн байгуулагдсан эмэгтэйчүүдийн ТББ-ууд өөрсдийн боломж, хуримтлуулсан мэдлэг, туршлагад түшиглэн хэдэн судалгаа хийсэн байна. Үүний нэг нь 1998 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх Газар, 9 яам тэдгээрийн харьяа байгууллагын ажилтнуудын дунд “Удирдагч эмэгтэйчүүдийн нөөц”-ийн 1-р шатны судалгааг Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны Сан явуулжээ.

“Танай яам (газар, хэлтэс) албан тушаалд дэвшүүлэн ажиллуулахдаа жендэрийн тэгш эрхийн бодлогыг баримталдаг уу?” гэсэн асуултанд 16 хувь нь “*тийм*”, 76.7 хувь нь “*үгүй*”, 7.1 хувь нь “*тодорхой мэдэхгүй*”, “эмэгтэйчүүдийг албан тушаалд дэвшүүлэхгүй байдал юутай холбоотой гэж үздэг вэ” гэсэн асуултанд 34.1 хувь нь “*эмэгтэй учраас*”, 24.3 хувь нь “*эмэгтэй хүн хүүхэд төрүүлж, бойжуулдаг учраас*”, 19.7 хувь нь *ажил хийх чадваргүй гэж үздэг учраас*, 19.5 хувь нь “*гэрийн ажлын ихэнхийг эмэгтэйчүүд гүйцэтгэдэг ба өөрийгөө хөгжүүлэх завгүй учраас*” гэж хариулжээ. Харин “*боловсрол дутуу учраас*” гэдэг асуултанд нэг ч хүн хариулаагүй байна. “Танай яамны удирдах хүмүүсийн жендэрийн тэгш эрхийн мэдлэг хангалттай гэж үздэг үү?” гэсэн асуултанд 63.7 хувь нь *хангалтгүй*, 36.2 хувь нь “*хангалттай*” гэж хариулжээ. Харин ЭЯГБХУТКК-ийн хэрэгжилтийг хянах Үндэсний Сүлжээний Төвөөс “Албан бус хөдөлмөр эрхлэлт”-ийн талаар хийсэн судалгаа нь эмэгтэйчүүдийн боловсролын байдал тэдний улс төр нийгмийн оролцоонд хэрхэн нөлөөлж байгааг судлах зорилт тавьсан ба судалгаанд хамрагдагсдын 25.3 хувь нь мэргэжлийн давтан сургалтанд өөрийн зардлаар суралцаж байгаа ба үүнээс 50.7 хувь нь эрэгтэйчүүд, 49.2 хувь нь эмэгтэйчүүд байна. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 74.6 хувь нь /үүнээс 48.3 хувь нь эрэгтэйчүүд, 51.6 хувь нь эмэгтэйчүүд/ “*мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдах боломжгүй байгаа*” ба гол шалтгаанууд нь санхүүгийн боломжгүй, хүүхэд харах хүнгүй, ар гэрийн боломжгүй, одоохондоо сурах боломжгүй гэж тодорхойлсон байна.

2000 онд Эмэгтэй удирдагч сангаас явуулсан судалгаанд “УИХ-ын сонгуульд нэрээ дэвшүүлсэн эмэгтэй нэр дэвшигчдийн тоо 1996 оныхоос 2,3 дахин өссөн боловч сонгогдсон эмэгтэйчүүдийн тоо урьдынхаасаа яагаад ахьсангүй вэ?” гэдэг асуултанд:

- “Сонгуулийн систем эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэхэд тохиромжгүй”,
- “МАХН-тай өрсөлдөгч намууд хэтэрхий олон хуваагдаж сонгогчдын саналыг хувааснаас МҮАН, МСДН болон бусад намуудаас нэр дэвшсэн УИХ-д сонгогдох магадлалтай байсан эмэгтэйчүүд сонгогдож чадаагүй”,
- “Сонгогчдын жендэрийн мэдрэмж, мэдлэг муу тул зарим эмэгтэй нэр дэвшигч санал бага авсан”,
- “Улс төрийн намууд эмэгтэйчүүдээ тодорхой бодлоготойгоор эртнээс бэлтгэж олны танил болгоогүй”,

- “Эмэгтэй нэр дэвшигчдийн санхүүгийн чадавхи сул тул сурталчилгаагаас сайн хийж чадаагүй”,
- “Төр, засаг эмэгтэйчүүдийн тоог шийдвэр гаргах түвшинд нэмэгдүүлэхэд чиглэсэн Үндэсний Хөтөлбөрийнхөө заалтуудын дагуу тодорхой алхам хийгээгүй”,
- “Орон нутгийн эмэгтэйчүүдийн байгууллагууд эмэгтэй нэр дэвшигчдийн төлөө нэг зорилго, нэгдмэл санаатай ажиллаж чадаагүй” зэргээр хариулсан байна.

Манай улс мажоритари системээр сонгуулиа явуулдаг нь гол төлөв хөрөнгө мөнгөтэй эрэгтэйчүүдийг эсвэл улс төрд олон жил болж олны танил болсон улс төрчдийн нэрийг дэвшүүлж сонгуульд ялалт байгуулахад илүү зохимжтой байна. Харин эмэгтэй нэр дэвшигчдэд төдийлөн ашиггүй болох нь дээрх судалгаанаас харагдаж байна. Мөн сонгуулийн тойргуудыг хуваарилах үед “нэр хүндтэй”, эсвэл хөрөнгө мөнгөтэй, санхүүгийн чадамж сайтай эрэгтэй улс төрчид нэрээ дэвшүүлэх тойргоо эхэлж сонгодог бөгөөд харин эмэгтэй улс төрчид ийм боломж бараг оногддоггүй юм. Жишээ нь 2000 онд МҮАН-аас нэр дэвшсэн эмэгтэй Б-д ийм асуудал тохиолдож түүний тойргийг 3 удаа сольж байсан бол МАХН-аас дэвшсэн эмэгтэй Г-г тэтгэврийн насанд хүрсэн гэдэг шалтгаанаар УИХ-д нэрийг нь дэвшүүлэхээс намын удирдлага нь татгалзаж байсан ба сонгогчид ч ийм хандлагатай байсан нь ажиглагдсан болно.

Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн хэрэгжилтийг сайжруулах, нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх тодорхой алхмууд 2004 оны сонгуулиар олонх болж байгаа МАХН, АН-ууд авч эхэлж байгаа нь сайшаалтай байна. Гэхдээ сонгуульд нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байхаар Сонгуулийн хуульд заасан заалтаасаа ухрах тухай яриаг УИХ зарим гишүүд гаргаж байна.

Ер нь хүн ам цөөнтэй, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тоо тэгш, сүүлийн 30 жилд дээд боловсрол эзэмшигчдийн 70 шахам хувь нь эмэгтэйчүүд байгаа манай орны хувьд эмэгтэйчүүдийн оролцоо УИХ-д 6.5 хувь, Засгийн газарт 0 хувь, орон нутгийн төр, захиргаанд 20 хувиас хэтрэхгүй байгаа нь Үндсэн хуульдаа “эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхтэй” хэмээн тунхагласан Монгол улсын хувьд шударга бус, тэгш эрхийн зарчим хэрэгжихгүй байгаагийн илэрхийлэл юм.

Иймээс эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн хэрэгжилт сул байгаагийн гол шалтгаануудыг төр, засгийн байгууллагууд судлан гаргаж, улмаар ямар асуудлуудыг шийдэх ёстой, ямар тодорхой ажил хийх ёстой вэ гэдгээ тодорхойлох нь нэн чухал асуудал болж байна. Харин сүүлийн 10 гаруй жил эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар ажиллаж тодорхой мэдлэг, туршлага хуримтлуулсны хувьд, эмэгтэйчүүдийн улс төрийн эрх нь хуульд заасан

дагуу хэрэгжиж байгаа бусад орны жишээг харж байгаагийн хувьд бид нилээд олон асуудлыг гаргаж тавих хэрэгтэй гэж үзэж байна. Үүнд:

1. Хүйсийн болон жендэрийн ялгаанд суурьласан ялгаварлан гадуурхах үзэл, хандлагыг арилгах талаар тодорхой арга хэмжээг авах шаардлагатай байна. Хүн бүр нас, хүйс, мэргэжил, боловсрол, үзэл бодол зэрэг олон зүйлээр ялгаатай байдаг. Гэтэл аливаа ялгааг манай нийгэмд *сайн эсвэл муу, дээр эсвэл доорд* гэж үзэж, хандаж байгаагаас шууд ба шууд бус ялгаварлан гадуурхалтыг бий болгож байна. Шууд болон шууд бусаар ялгаварлаж байгаа энэ хандлагууд нь эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн хэрэгжилтийг дээшлүүлэхэд ихээхэн нөлөөлж байна. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог шууд ба шууд бусаар бууруулж байгаа асуудлуудын нэг жишээ нь тэднийг “дорой хүйстэн”, “гэрийн хүн” гэх зэргээр үздэг уламжлалт сэтгэхүйгээр илэрч байна.

2. Улс төр, нийгмийн хүрээнд байгаа эмэгтэйчүүдийн эсрэг шууд болон шууд бус ялгаварлан гадуурхалт нь эмэгтэйчүүдийн улс төрийн эрхээ эдлэх тухайлбал, сонгогдох эрхээ эдлэх хүсэл зоригийг нь мохоож, хүчин мөхөс байдалд оруулж, өөртөө итгэх итгэлийг алдагдуулж байдаг.

3. Нийгэмд шударга бус байдал газар авч, албан тушаалын наймаа, хээл хахууль гаарч байгаатай холбоотой. Ёс суртахуунгүй улс төрчид иргэдийн нийтлэг эрх ашгийн төлөө бус хувийн болон бүлгийн эрх ашгийнхаа төлөө ажиллахаа урьтал болгодог учраас улс төрд хүний эрх, жендэрийн тэгш эрхийг ханган баталгаажуулах бодлогоо тууштай хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулахгүй байгаа, түүнийг чухал зүйл гэж үзэлгүй хойш тавьж байгаатай холбоотой. Нөгөөтэйгүүр төр, засгийн олон шатны байгууллагын албан тушаалтнууд улс төрийг өөрсдийн хувийн сонирхолд нийцүүлэн ашиглах болсонтой холбоотойгоор эрх мэдэлтэй хүмүүст хэн хээл, хахууль өгч чадаж байна, улс төрийн намуудад хэн олон сая төгрөгийн хандив өгч чадаж байгаа нь албан тушаал авах, сонгуульд нэрээ дэвшүүлэх гарцтай болдог байна. Тийм учраас улс төр, нийгэмд танигдсан, эрдэм чадалтай, шударга, ёс суртахуунтай эмэгтэйчүүд ийм бохир улс төрд орохыг хүсдэггүй байна.

4. Сонгуулийн тогтолцоо эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд саад болж байгаа бас нэг гол шалтгаан мөн. Сонгуулийн мажоритари тогтолцоо нэр дэвшигчдийн хувьд дэндүү их зардалтай тогтолцоо юм. Эмэгтэй хүний жендэрийн ялгаа нь хөрөнгө мөнгийг гэр бүл, нийгмийн амьдралдаа зөв зүйтэй, үр дүнтэй зарцуулахад анхаардаг. Тиймээс эмэгтэйчүүд бодит байдлаас хэтэрсэн эрсдэл хийхийг тэр болгон хүсдэггүй учраас улс төрийн эрхээ эдлэхээс татгалздаг байна.

5. Эмэгтэйчүүд улс төрд гарсныхаа дараа хүйсийн болон жендэрийн ялгаварлан гадуурхалтанд эрэгтэй улс төрчдийг бодвол илүү өртдөг болох нь өдөр тутмын хэвлэл, ялангуяа “шар” хэвлэлүүдэд ихээхэн гарч байгаа

нийтлэл, мэдээнээс ажиглагдаж байна. Тэдэнд улс төр, нийгмийн ажил хийж байгаа албан тушаалтан гэж хандахаасаа илүү “тэр авгай”, “энэ муу хүүхэн” гэх мэтчилэн хочилж, доорд хүйстэн гэсэн хандлагаар хандсан байдаг. Харин эмэгтэй хүн улс эх орон, нийгмийн төлөө алдаа, оноотой зүтгэснийхээ төлөө дорд үзэгдэх, доромжлуулахыг шударга бус гэж үздэг учраас улс төрийн эрхээ эдлэхээс татгалздаг бас нэг шалтгаан байна. Харин эмэгтэй улс төрчдийг доромжлон гутаах байдлаар хандаж байгаа хэвлэл мэдээллийн байгууллагуудын ажилтнуудын 90 шахам хувь нь эмэгтэйчүүд байдаг атал эмэгтэй улс төрчийг доромжлон гутаасан мэдээ, нийтлэл гарсаар байгаа нь судлах ёстой асуудлын нэг юм.

6. Дээрх шалтгаануудын зэрэгцээ Монгол улсад нийгмийн халамж, үйлчилгээний хөгжил муутай, гэр бүлийн гишүүд, ялангуяа эхнэр, нөхрийн ажлын ачаалал тэгш бус байдгаас эмэгтэйчүүд гэр бүл, нийгмийн хүрээнд ямагт давхар ачаалалтай байдгаас нилээд сайн боловсролтой, мэдлэг, чадвартай, шударга, ёс зүйтэй эмэгтэйчүүд тэр бүр улс төрийн эрхээ эдлэх асуудлаа хойш тавьсаар байна.

ЖЕНДЭРИЙН ХАНДЛАГЫГ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛД ТУСГАЖ БУЙ ТӨРИЙН БОДЛОГО

*Д.Биндэрьяа,
Хөдөлмөр, нийгэм хамгаалмын яамны ахлах мэргэжилтэн*

Монгол улс НҮБ-ын гишүүн болсон үеэс хойших хугацаанд хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой 50 гаруй конвенцид нэгдэн орсны нэг нь НҮБ-ын Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенци билээ. Конвенцийн Нэмэлт протоколыг Монгол Улсын Их Хурал 2001 оны 12 дугаар сард баталсан.

Монгол улсын Засгийн газар эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн сайн сайхны төлөө үндэсний дотоод нөөц бололцоог дайчлах замаар 20/20-ын санаачилгыг хэрэгжүүлэх бодлого барьж байна. Эдүгээ манай оронд эмэгтэйчүүдийн эрх ашиг, эрүүл мэндийг хамгаалах, боловсрол олгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэдний хөгжлийг хангахад чиглэсэн 10 гаруй төрөлжсөн хөтөлбөрийн хүрээнд олон тооны төслийг хэрэгжүүлж байна. Тухайлбал, хүүхэд, залуусын боловсролын төлөө улсын төсвийн жилийн орлогын 20-иос доошгүй хувийг зарцуулж байхаар хуульчилсан явдал маш том ололт болсон юм.

Сүүлийн 10 жилийн байдлаар улсын төсвийн зарлагын 44.4-56.0 хувьтай буюу ДНБ-ний 11.3-24.8 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг нийгмийн суурь үйлчилгээний тухайлбал, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, соёл, амралтын арга хэмжээний зардалд зарцуулсан байна.

Монгол улсын 1992 онд баталсан шинэ үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлд “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэж ялгаварлан гадуурхах явдлыг шууд хориглосон байдаг.

Мөн хуулийн Арван ёсдүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын төр ийнхүү ялгаварлан гадуурхахыг хориглосон хуульзүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх арга хэрэгслийг бүрдүүлэх үүрэг хүлээж байна гэсэн хэрэг юм.

Монгол улс Хөдөлмөрийн тухай хуулиар хөдөлмөрийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй иргэд тэгш эрхтэй оролцох эрхийг баталгаажуулсан.

Монгол улсад эрхзүйн шинэтгэл буюу шинэ үндсэн хуулийн үзэл санааны дагуу хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулах ажил эрчимтэй хийгдэж байна. Эхний үе шатанд нийгмийн гол суурь нийтлэг харилцааг зохицуулсан эрхзүйн актууд олноор батлагдаж байсан бол сүүлийн жилүүдэд нийгмийн тодорхой харилцааг зохицуулсан актууд, түүний дотор хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой хуулиуд батлагдан гарч байна. *Тухайлбал*, Олон нийтийн радио, телевизийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг нэрлэж болох байна.

Эмэгтэйчүүд, ялангуяа эхчүүд, охидын хэрэгцээ, эрх ашиг аливаа хөгжлийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл байх ёстойг өнгөрсөн жилүүдэд хуримтлуулан туршлага, авсан сургамж нотолж байна. *Тухайлбал*:

- Аливаа өөрчлөлтийг явуулахдаа эмэгтэйчүүдийн эрх ашигт тулгуурлаж байх;
- Бодлого нь нэг хэсэг буюу бүлэг эмэгтэйчүүдэд нөлөөлж байгаа хүчин зүйлийг шийдвэрлэхэд чиглэгдэх;
- Өргөн утгаар нь эмэгтэйчүүдийн эрхийг хангалттай хамгаалж, тэдний эрхийг зөрчих явдалтай үр дүнтэй тэмцэх;
- Эх, хүүхдийн хөгжилд, ялангуяа эрсдэл бүхий амьдралтай айл өрхөд нийгмийн тусламж, дэмжлэг үзүүлэх явдлыг онцгой анхаарах;
- Эмэгтэйчүүдийн тогтвортой хөгжил, иргэдийн оролцоог дэмжсэн, үр дүнд чиглэсэн удирдлага, зохицуулалтын оновчтой арга хэрэглүүрийг сонгож ажиллах зэрэг сургамж гарч байна.

Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол улсын Засгийн газрын 3, 4 дэх тайлан илтгэлийг хэлэлцээд НҮБ-ын Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахыг устгах хорооноос ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрхзүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн ажил, хүчирхийллийн хор уршгийн талаар Хүчирхийллийн эсрэг үндэсний төв зэрэг төрийн бус байгууллага олон нийтэд ухуулга, сурталчилгааны ажлыг хүчтэй зохион байгуулж, идэвхитэй ажилласнаар УИХ-аар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 2004 онд батлуулж чадсан байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгдсөн иргэн эрхээ хамгаалуулах, хүчирхийлэл гарахаас урьдчилан сэргийлэх, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэх, түүнтэй тэмцэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог хангах харилцааг зохицуулсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогчийг хамгаалах арга хэрэгслийг тогтоож өгсөн юм.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийг хэрэгжүүлэх үүднээс Монгол улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулсан Хуульзүй, дотоод хэргийн сайдын ахалсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг ажиллаж байна. Энэхүү

хөтөлбөрийг боловсруулах ажилд НҮБ-ын Эмэгтэйчүүдийн хөгжлийн сан, НҮБ-ын Хүн амын сан зэрэг олон улсын байгууллагын зүгээс мэргэжил, аргагүйн болон санхүүгийн дэмжлэг тусалцаа үзүүлж байна. Хүчирхийлэлгүй амар амгалан, айх аюулгүй амьдрах нөхцөл бололцоог хангах ажилд төр, иргэний нийгмийн болон жендэрийн чиглэлээр ажилладаг олон улсын байгууллагын хамтын ажиллагаа, харилцаа холбоо нэлээд сайжирч байна гэж хэлж болохоор байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зэрэгцээ манай улсын бусад хууль тогтоомжид хүчирхийлэлд өртсөн иргэнийг хамгаалахад чиглэсэн эрхзүйн орчныг бүрдүүлэхэд ихээхэн анхаарч ажиллаж байна. үүний дотор эмэгтэйчүүдийг хүчирхийлсэн үйлдлийг “хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг эрүүгийн гэмт хэрэг”-т тооцон эрүүгийн ял хүлээлгэх агуулга бүхий заалтууд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд орсон болно.

Жендэрээр ялгаварлан гадуурхсан хууль тогтоомжийг хянан нягтлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулж засварлах хандлага гарч байна. *Тухайлбал*, Хөдөлмөрийн тухай хуулийн 106 дугаар зүйлд Хүүхэд асрах чөлөөг зөвхөн эхэд олгож байсныг эцэгт нь мөн нэг адил олгож болох агуулгатай заалтыг 2003 онд нэмж оруулсан байна. Түүнчлэн Зар сурталчилгааны тухай хуульд “...үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нийгмийн гарал, байдал, нас, хүйс, мэргэжил боловсрол, шашин шүтлэг, үзэл бодлыг гутаан доромжилсон үг хэллэг, харьцуулалт, дүрслэл зэргийг ашигласан...” бол хууль бус сурталчилгаа гэж үзэн бүтээх, түгээхийг хориглож, түүнийг зөрчсөн бол торгох шийтгэл оногдуулахаар тусгасан байна. Гэвч манай орны зарим сонин хэвлэл, зар сурталчилгааны нийтлэлд шуугиан дэгдээх, бизнесийн ашиг олох зорилгоор хүний нэр төрийг гутаах, эмэгтэйчүүдийн дүр төрхийг сөргөөр илэрхийлэх явдал гарсаар байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй, түүнийг таслан зогсоох хөшүүрэг, арга ажиллагааг өөрчлөн сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Сүүлийн жилүүдэд охид, эмэгтэйчүүд гадаадад ажиллуулах, гадаадын иргэнтэй гэрлүүлэх, дотоодод ажлын байранд зуучлах элдэв зар сурталчилгаанд хууртагдаж гадаадад зорчих, эмзэг байдлаас шалтгаалан хүчирхийлэл, дарангуйлалд автах, бие махбодь, сэтгэл санааны хохирол үзэх зэргээр хүний эрх зөрчигдөж байгаа тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр олонтаа нийтлэгдэх болсон байна.

Монгол улсын Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасны дагуу “хүн худалдах, худалдан авах” үйлдлийг гэмт хэрэгт тооцон эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байна. Мөн зүйлд уг үйлдлийг “хүний цус, эд, эрхтэнг ашиглах зорилгоор, биеийг нь үнэлүүлэх зорилгоор, хоёр буюу түүнээс олон хүнийг, насанд хүрээгүй хүнийг, бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг этгээд үйлдсэн, эсхүл хүнийг хил

давуулан худалдсан бол хүндрүүлэх нөхцөлд тооцон үзэж, ялыг нь хүндрүүлэн оногдуулахаар тусгасан байна. Гэвч бодит амьдралд мөрдөн байцаагч, прокурор, шүүгч хэргийг мөрдөн шалгахдаа ийм төрлийн хэргийг хянан тогтоож чадахгүй байх, ялангуяа хил дамжуулан худалдагдсан хэргийг тэр бүр шалган тогтоож чадахгүй байна. Улсын хэмжээгээр 2003-2005 онд хүн худалдах, худалдан авах гэмт хэрэг нийт 7 бүртгэгдсэн байна. Жилд хэчнээн эмэгтэйг хил давуулан гаргаж, биеийг нь үнэлүүлж буй тухай бодитой тоо баримт, мэдээллийг гаргаж чадахгүй байна¹.

НҮБ-аас 2000 онд баталсан үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тухай конвенци, түүний Хүн худалдах, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийг худалдахыг зогсоох, урьдчилан сэргийлэх, шийтгэх тухай нэмэлт протоколд нэгдэн орохоор Монгол улс судалж байна. 2005 онд Засгийн газар хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг онцгойлон үзэж “Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах Үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр энэхүү хөтөлбөрийг жил гаруй хугацаанд боловсруулж, төслийг ажлын хэсгийн болон олон талын төлөөлөл бүхий уулзалт, ярилцлагаар хэлэлцүүлж, санал, зөвлөмжийг тусгасан байна. Энэхүү хөтөлбөр нь хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахын эсрэг Монгол улсын олон улсын гэрээний дагуу хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх, холбогдох эрхзүйн орчинг боловсронгуй болгох, байгууллага, иргэдийн оролцоог хангах, мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилтуудыг дэвшүүлж, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон.

Хуульзүй, дотоод хэргийн яам садар самуун явдалтай тэмцэх талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийж, Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль(1998)-д нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлээр ажиллаж байна.

Монгол улсад өнөөдөр бие даасан 380 орчим хууль үйлчилж байгаа бөгөөд зарим хуулийн хэрэгжилт хангалтгүй хэрэгжиж, улмаар зарим хуульд шууд бусаар ялгаварлан гадуурхах шинжийг агуулсан заалтууд орсон байгааг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй юм. Жишээлбэл, эмэгтэй хүмүүс эрэгтэйчүүдээс 5 жилийн өмнө эрт өндөр насны тэтгэвэрт гарахаар хуульчилсан нь **нэг талаас**, эмэгтэйчүүдийн ажиллах, улмаар өндөр цалин хөлс авах боломжийг хаагдуулж байна гэсэн шүүмжлэл сүүлийн жилүүдэд зарим иргэдийн дунд гарч байхад **нөгөө талаас**, тэтгэврийн насны эмэгтэйчүүдийн амьжиргааны гол эх үүсвэр болсон тэтгэврийн насыг болгоомжтой өөрчлөх ёстой гэсэн төрийн бус байгууллагуудын эсэргүүцэлтэй тулгарч байна.

¹ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл, 2003 он, Монгол улсын хүний эрхийн үндэсний комисс, Улаанбаатар

Хууль тогтоомжийн шинэчлэлийн зэрэгцээ жендэрийн хандлагыг үндэсний бодлого, хөтөлбөрт тусгах, улмаар эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог хөгжлийн шинэ агуулгад нийцүүлэн өөрчлөх явдал жендэрийн баримжаатай төрийн бодлогын шинэчлэлийн нэг чухал зорилт болж байна. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн болон Эмэгтэйчүүдийн байдлын тухай 1995 оны бага хурлаас баталсан Бээжингийн тунхаглал, үйл ажиллагааны хөтөлбөрийн үзэл санааг үндэсний онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх чиглэлээр Монголын эмэгтэйчүүдийн талаар төрөөс баримтлах томоохон баримт бичгийн нэг болох Эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад эмэгтэйчүүдийн эрхийг баталгаажуулах, тэдний боловсролыг дээшлүүлэх, нөхөн үржихүйн эрүүл мэндийг сайжруулах, эмэгтэйчүүдийн хөгжлийг хангах үндэсний тогтолцоог бүрдүүлэх, нийгмийн хөгжилд эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш оролцоог хангах, улмаар нийгмийн сэтгэлзүйд жендэрийн ойлголт, мэдрэмжийг төрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн² байна.

Гэхдээ орчин үеийн хөгжлийн чиг хандлага болон жендэрийн хөгжлийн бодит хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг төв, орон нутгийн төрийн ба төрийн бус, эрдэм шинжилгээ, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшил, олон улсын байгууллагын төлөөлөл, түүний дотор эмэгтэйчүүдийг өргөнөөр оролцуулан боловсруулж, Засгийн газрын 2002 оны 274 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна.

Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр нь *Гэр бүлийн харилцаан дахь жендэрийн тэгш байдал, Эдийн засгийн харилцаан дахь жендэрийн тэгш байдал, Хөдөөгийн хөгжил дэх жендэрийн тэгш байдал, Шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш байдал, үндэсний тогтолцоо ба иргэний нийгмийн оролцоо* гэсэн 5 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэж байна. Эдгээр бүрэлдэхүүн хэсэг бүрт Бээжингийн бага хурлаас баталсан үйл ажиллагааны хөтөлбөрийн анхаарал хандуулбал зохих үндсэн 12 асуудлыг багцлан тусгасан болно. Үндэсний хөтөлбөрийг 2015 он хүртэл 4 үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд үе шат бүрт хийгдсэн ажлыг үнэлэн дүгнэж, дараагийн үе шатанд зохиох ажлын чиглэлийг нарийвчлан боловсруулж, тухай бүр Засгийн газраар батлуулж байхаар журамласан байна. Хөтөлбөрийн нэгдүгээр шатны үйл ажиллагааг 2004 онд дүгнэж, хоёрдугаар шатны үйл ажиллагааны чиглэлийн төслийг хэлэлцэх Стратеги төлөвлөлтийн семинар, зөвлөлдөх уулзалтыг 2005 онд үндэсний хэмжээнд зохион байгуулав. Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн

² “Жендэр ба хөгжил” Үндэсний чуулган дээр Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ши.Батбаярын хэлсэн үгнээс...

хоёрдугаар шатны үйл ажиллагааны чиглэлийг Засгийн газраар 2006 оны 1 дүгээр сард хэлэлцүүлж батлууллаа.

Тэгш эрхийн талаарх бодлого, шийдвэрийг амжилттай хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн оролцоотой жендэрийн тэгш байдлын асуудлаарх үндэсний тогтолцоо чухал үүрэгтэй хэмээн үзэж түүнийг боловсронгуй болгоход төр, засгаас анхаарч ирлээ. Хүйсийн тэгш байдлын асуудлаарх үндэсний зөвлөлийг салбарын бодлого, хөтөлбөр, төлөвлөлтөд жендэрийн асуудлыг тусгах, Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн өргөн хүрээний үйл ажиллагааг уялдуулан зохицуулах механизм болгон зохион байгуулахаар Ерөнхий сайдаар ахлуулсан Жендэрийн тэгш байдлын Үндэсний хороог Засгийн газраас 2005 онд батлав. Үндэсний хороо нь жендэрийн тэгш байдлын хэтийн төлвөөр үндэсний хэмжээнд зөвлөлдөх байгууллага байх бөгөөд энэ чиглэлээр төрийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд нөлөөлөх, үр дүнг нь үнэлж дүгнэхэд төрийн болон иргэний нийгмийн байгууллага, иргэдийн зүгээс гаргасан үүсгэл санаачилгыг дэмжих, олон улсын байгууллага, хандивлагчидтай хамтран ажиллаж, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах үүрэгтэй байгууллага юм.

Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрөөс гадна УИХ-аас Монгол улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогыг 2003 онд, Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг 2003 онд, Монгол улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг 2004 онд, Монгол улсын мянганы хөгжлийн зорилтыг 2005 онд тус тус баталж, эдгээрт гэр бүлийн харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэй, эрэгтэйчүүдийн тэгш эрх, тэгш байдлыг хангах, хүн амын хөгжлийг хангахдаа жендэрийн тэгш байдлыг хангах зэрэг асуудлыг тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Сүүлийн жилүүдэд Монгол улсын нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагаа эрс идэвхижсэн байна. Үүний дотор хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зорилго бүхий байгууллага олноор байгуулагдаж, тэдний зүгээс Засгийн газрын бодлого, шийдвэрт нөлөөлөх, түүнийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйл явц мэдэгдхүйц нэмэгдэж байна. Иргэний нийгмийн оролцооны түгээмэл хэлбэрийн нэг нь бодлогын баримт бичиг боловсруулах буюу бодлого тодорхойлох үйл явцад оролцох, тухайн чиглэлээр мэргэшсэн судалгаа явуулах ажлын хэсэгт оролцуулах, тэдний саналыг авах явдал нийтлэг байна. Судалгаа, дүн шинжилгээ, боловсруулалтын ажилд эмэгтэйчүүдийг өргөн оролцуулснаар жендэрийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөний төсөлд тэдний санал бодлыг тусгах, улмаар хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх, хянах, үнэлж дүгнэх бололцоо илүүтэй бүрдэж байгаа юм. Гэвч нийгмийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад төрийн бус байгууллагатай харьцуулахад хувийн хэвшлийн оролцоо хангалтгүй байна. Эмэгтэйчүүд, жендэрийн хөгжлийн үйл ажиллагаанд

ойрын жилүүдэд эрчимтэй хөгжиж байгаа хувийн хэвшил, аж ахуйн нэгжийн төлөөллийг идэвхитэй оролцуулах явдал чухал зорилт болж байна. Өнөөдөр эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, хөтөлбөрт жендэрийн хандлагыг бүрэн хэмжээгээр суулгах, эрэгтэй, эмэгтэйчүүдийн онцлог хэрэгцээг тусгах, жендэрийн дүн шинжилгээ явуулах ур чадвар төрийн ба төрийн бус байгууллагад нэгэн адил сул байна.

Олон улсын хүний эрхийн гэрээ, конвенци, эмэгтэйчүүдийн асуудлаарх олон улсын бага хурлын шийдвэр, хүний эрхийн үндэсний хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг өнөөдөр олон нийтэд таниулах, сурталчлах ажил юу юунаас чухал шаардлагатай байна. Улсын Их Хурлын 2001 онд баталсан НҮБ-ын Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн Нэмэлт протокол болон 2005 онд баталсан Монголын мянганы хөгжлийн зорилтыг бүх түвшинд сурталчилж ирлээ. Тухайлбал, Засгийн газраас Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийг хэрэгжүүлэх тусгай төлөвлөгөө гарган ажиллаж байна. Энэ төлөвлөгөөний хүрээнд эмэгтэйчүүдийн эрхийн гэрээ, конвенцийн хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ өгөх, тайлагнах чиглэлээр төрийн ба төрийн бус байгууллагын ажилтан, их, дээд сургуулийн багш нарын мэдлэгийг ахиулах, тэдний мэргэшлийг дээшлүүлэх, ялангуяа Засгийн газрын ажилтан нарт зориулан “Конвенцийн тайлан бэлтгэх” сэдвээр тусгай сургалт зохион байгуулж Ази, Номхон далайн бүсийн Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийн хяналтын албаны ажилтан нарыг оролцуулсан явдал Монгол улсад Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийг хэрэгжүүлэх ажилтай олон улсын байгууллагын хүний эрх, эмэгтэйчүүдийн эрхийг хангах талаарх хүчин чармайлыг уялдуулахад чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

Түүнчлэн манай оронд Дэлхийн хүн амын өдөр, Хүчирхийллийн эсрэг аян, Олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Гэр бүлийн өдөр зэрэг тэмдэглэлт үйл явдлын үеэр олон нийтийн дунд компани ажил зохион байгуулж хэвшлээ. Монгол улс Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцид нэгдсэний 20, 25 жилийн ойн үеэр олон чухал арга хэмжээ зохион байгуулав. Үүний дотор конвенцийн хэрэгжилтийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон олон нийтийн газар сурталчлах, хэвлэмэл материал тараах, хэлэлцүүлэг, уулзалтууд зохион байгуулах, түүнчлэн залуусын сонсох дуртай сувгуудаар зар сурталчилгаа явуулах зэрэг ажлыг үндэсний ба олон улсын төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн газартай хамтран зохион байгуулж ирсний дүнд жендэр, гэр бүл, эмэгтэйчүүдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийт байгууллага, ажилтнуудын конвенцийн талаарх мэдлэг, ойлголт өсөн нэмэгдэж байна.

ЖЕНДЭРИЙН АСУУДЛААРХИ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ ХЭРХЭН БИЙ БОЛГОХ ВЭ?

*М.Болормаа,
Жендэрийн тэгш байдлын үндэсний хорооны ажлын
албаны дарга, Эмэгтэй удирдагч сангийн тэргүүн*

Хүний эрхийн үндэсний комиссоос эрхлэн гаргадаг “Хүний Эрх” сэтгүүлийн энэ дугаарт “Жендэр ба хөгжил” сэдвийг хөндөн тэр дундаа жендэрийн асуудлаарх үндэсний тогтолцооны талаар судлаачид, эрдэмтэд, мэргэжилтэнгүүдийн үзэл бодлыг нийтэлж байгаад болон Жендэрийн тэгш байдлын үндэсний Хорооны ажлын албыг бэхжүүлэх тал дээр дэмжин хамтран ажиллаж байгаад Хүний эрхийн үндэсний комисс болон түүний дэргэдэх Эмэгтэйчүүдийн чадавхыг бэхжүүлэх төслийн багийнханд чин сэтгэлийн талархлаа илэрхийлье.

Хөгжлийн асуудлын талаар ярилцан хэлэлцэхэд жендэрийн асуудлыг хөндөхгүй орхидог нэг ч улс үгүй болжээ.

НҮБ-аас эмэгтэйчүүдийн эрхийг улам бүр дэмжихийн тулд дэлхийн 4 удаагийн олон улсын Бага хурлуудыг зохион байгуулсны зэрэгцээ 2005 онд Бээжин+5 НҮБ-ын тусгай чуулганыг хуралдуулсан билээ. Үүнд: Мексик улсын Мехико хотод 1975, Дани улсын нийслэл Копенгаген 1980, Кенийн нийслэл Найроби хотод 1985, БНХАУ-ын нийслэл Бээжинд 1995 онд, АНУ-ын Нью-Йорк хотноо 2004 онд тус тус болсон юм.

Бээжин хотноо болсон олон улсын дөрөвдүгээр Бага хурлаас гаргасан үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг НҮБ-ын бүх гишүүн орнууд хүлээн зөвшөөрч гарын үсгээ зурсан. Уг баримт бичигт улс орон бүр хэрэгжүүлж буй бодлого, төрийн бүтцэд жендэрийн үр дүнтэй зорилтыг тусгаж байх үүрэг хүлээсэн байдаг. Энэ хурлаас Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийг улам эрчимтэй хэрэгжүүлэх талаар цохон тэмдэглэсэн байна.

Ийнхүү Бээжин хотноо 1995 онд болсон олон улсын эмэгтэйчүүдийн Бага хурлаас хойш “Эмэгтэйчүүд-хөгжилд” хандлага өөрчлөгдөн эмэгтэйчүүд нь зөвхөн халамж анхаарал хүртэж байхаас гадна илүүтэйгээр нийгмийн хөгжилд оролцох нь чухал байгааг тодорхойлон гаргаж ирсэн юм.

Өнөөдөр жендэрийн тэгш байдал нь хүний тогтвортой хөгжлийн үр дүн бус урьдчилсан нөхцөл болон тавигдах ёстой тогтвортой хөгжлийн асуудал болоод байна.

Иймээс жендэрийн үзэл баримтлалыг бодлогод тусгах стратеги боловсруулах нь эмэгтэйчүүд хөгжилд хандлагыг өөрчлөн жендэр хөгжилд гэсэн хандлагын тулгуур ойлголт нь болж байна.

Жендэр хөгжилд хандлага нь жендэр бол эмэгтэйчүүдийн дан ганц асуудал бус харин нийгмийн харилцааны асуудал гэж үзэж байгаа бөгөөд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд нь харилцан адилгүй тусгай хэрэгцээтэй байдаг хэмээн жендэрийн олон улсын шинжээчид үзэж байна. Жендэрийн үзэл баримтлалыг бодлогод тусгах үйл явц нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн энэхүү хэрэгцээ шаардлагыг тэгш эрх, тэгш үнэлэмжээр хангана гэсэн үг юм. Энэ нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс бүтээн бий болгосон нийгмийн нөөц, баялгаас тэгш хүртэх боломж, түүнд хяналт тавих, шийдвэр гаргахад оролцох боломжоор тус тус хангагдсан байх ёстой.

Жендэрийн тэгш байдал нь хүний амьдралын нарийн ширийнд туссан, олон талт асуудлыг багтаасан ойлголт бөгөөд түүнийг үр ашигтайгаар өөрчлөх, сонголт хийх боломжийг хүмүүст өгдөг юм.

Жендэрийн асуудлыг бодлогод тусгахад юуны өмнө шийдвэр гаргагчдын хандлагыг өөрчлөн хамтран ажиллах ёстой бөгөөд ингэснээрээ жендэрийн баримжаатай, мэдрэмжтэй төрийн бодлого боловсруулна гэсэн үг билээ.

Яагаад бид жендэрийн тэгш байдлыг нэн шаардлагатай гэж үзэж байна вэ? гэвэл өнөөдөр нийгэмд газар авсан ядуурлыг бууруулахад жендэрийн тэгш байдлыг хангах нь чухал үүрэгтэй. Учир нь эмэгтэйчүүд ядуурлын хор нөлөөг эрэгтэйчүүдээс илүү үүрч байгааг дэлхий улс орон бүрийн жишээ нотлож байна. Хоёрдугаарт эрхэд суурилсан хөгжлийн хандлагыг хөгжүүлэхэд жендэрийн тэгш байдал чухал үүрэгтэй. Олон улсын бодлогод тусгагдан хангагдаж буй хүний эрх нь дэлхий нийтэд хэрэгжих ёстой бөгөөд хүний тэгш эрх, тэгш үнэлэмжид суурилсан байдагтай салшгүй холбоотой.

ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ МЕХАНИЗМ, ТОГТОЛЦОО

Жендэрийн үзэл баримтлалыг бодлогод тусгахад юуны өмнө тухайн улс орны үндэсний Засгийн газрын оролцоо, дэмжлэг хамгаас чухал хэмээн Бээжингийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тэмдэглэсэн байдаг. Иймээс эмэгтэйчүүдийн үндэсний тогтолцоо нь өргөн утгаараа Засгийн газраас тогтоосон жендэрийн тэгш байдлыг хангах асуудлыг хариуцсан тухайн орны анхан шатны байгууллага, хүмүүс, бүтэц гэж тодорхойлдог. Энэ нь “Засгийн газраас жендэрийн өргөн хүрээний асуудлыг нийт бодлогод тусгахыг дэмжиж жендэрийн тэгш байдлын хэтийн төлвийг хангах үүрэг хүлээсэн “Засгийн газрын гол бодлогыг уялдуулан зохицуулах нэгж” юм.

Эмэгтэйчүүдийн үндэсний тогтолцоо нь Засгийн газрын салбар байгууллагаар дамжуулан жендэрийн асуудлыг бодлогод тусгах анхан шатны бодлогыг дэмжих, өөрчлөлт хийх гол хүч билээ.

Үндэсний механизм нь үр ашигтай үйлчлэхэд

- a. Засгийн газрын хамгийн өндөр түвшингийн албан тушаалтан болон кабинетын гишүүн сайдад харьяалагдсан байх
- c. Төсөв болон боловсон хүчнээр хангах үүднээс хангалттай хэмжээний нөөц баялагтай байх
- d. Засгийн газраас бүх салбарт бодлого боловсруулахад нөлөө үзүүлэх боломжтой байх ёстой юм.

Үндэсний механизм нь бодлогод дүн шинжилгээ хийх, мэдээлэл сурталчилгааны үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохих хэлхээ холбоог дэмжих, үйл ажиллагааг зохицуулах болон хэрэгжилтийг нь хянах ёстой байдаг. Жендэрийн тэгш байдлыг хангах болон эмэгтэйчүүдийн асуудлаарх Үндэсний тогтолцооны мандатын асуудал үндэсний түвшинд ч, олон улсын түвшинд ч тэр жендэрийн тэгш байдлын төлөө дэлхий дахинаа хүчтэй яригдсаар байна.

Эмэгтэйчүүдийн үндэсний тогтолцоо нь эмэгтэйчүүдэд тусгайлан зориулсан хөтөлбөрүүдийг анхан шатанд хэрэгжүүлэх байгууллага мэтээр ойлгогдож ирсэн түүхтэй. Хэдийгээр үндэсний тогтолцоо нь эмэгтэйчүүдэд зориулсан тусгайлан хөтөлбөр төслүүдийг хэрэгжүүлэх үүрэгтэй ч гэлээ хамгийн чухал нь жендэрийн асуудлыг бодлогод тусгах, тэгш байдлыг тогтоохын төлөө үр дүнтэй ажиллах ёстой байдаг.

Иймээс үндэсний тогтолцоо нь улс орон бүрт өөр өөрийн онцлогтой бөгөөд ихэнх улс орнууд эмэгтэйчүүдийн асуудал эрхэлсэн яам, газар болон эрх зүйн орчныг бүрдүүлэх хуулиудтай болсон байна.

Жендэрийн тэгш байдлын Үндэсний Хорооны ажлын албанаас эрхлэн хэвлүүлсэн “Өөрчлөлтийг түргэсгэх нь” жендэрийн асуудлыг бодлогод тусгах үзэл баримтлал гарын авлагын 2 дугаар бүлэгт Бангалдеш, Индонез, Филиппин дэх эмэгтэйчүүдийн Үндэсний тогтолцооны талаар өгүүлсэн байна. Жишээ нь: Филиппинд Эмэгтэйчүүдийн үндэсний төлөвлөгөө нь холбогдох яамдын оролцоотойгоор боловсруулагдсан байхад Филиппиний эмэгтэйчүүдийн үүрэг ролийг Үндэсний Комиссоос Засгийн газрын бусад байгууллагуудад бүхий л талаар ойлгуулах ажлыг урьдчилан хийдэг байна.

Бангладешид Эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах үндэсний бодлогыг 1997 онд боловсруулан батлаад хэрэгжүүлж байна.

Түүнчлэн БНСУ, Япон улсуудын үндэсний механизмын талаар товч танилцуулья.

Япон улсад жендэрийн тэгш байдлыг хангах төрийн механизмыг боловсронгуй болгох, цар хүрээг нь өргөтгөх зорилгоор 2001 оны нэгдүгээр сард Засгийн газрын дэргэд Жендэрийн тэгш байдлын асуудлаарх Зөвлөл түүний дор өдөр тутам үйл ажиллагааг эрхлэн явуулах ажлын алба буюу /товчоо/-г байгуулсан байна.

Жендэрийн тэгш байдлын товчоо: 1994 оны 7 дугаар сард Засгийн газрын тогтоолын дагуу Жендэрийн тэгш байдлыг дэмжих төв алба байгуулагдсан билээ. Энэхүү төв албаны ерөнхийлөгчөөр Ерөнхий сайд, дэд ерөнхийлөгчөөр нь Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга тус тус ажилладаг бөгөөд төв албаны гишүүдэд бүх яамдын сайд нар багтдаг байна.

Жендэрийн тэгш байдлын зөвлөл: Уг зөвлөлийг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга /Жендэрийн тэгш байдлыг дэмжих төв албаны дэд ерөнхийлөгч/ даргалдаг бөгөөд Ерөнхий сайдын томилсон 12 сайд ба 12 сэхээтэн гишүүнээр нь ажилладаг. Зөвлөлийн гишүүдийн 60% нь эмэгтэй ба 40% эрэгтэйчүүд байдаг. Зөвлөл нь:

- Ерөнхий хороо
- Хүчирхийллийн эсрэг асуудал эрхэлсэн хороо
- Хяналт, шалгалтын хороо
- Жендэрийн харилцааны үнэлэлт дүгнэлтийн хороо гэсэн дэд хороодтой.

Жендэрийн тэгш байдлын товчоо, ажлын алба: Уг товчоо нь Жендэрийн тэгш байдлын үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга нараас бүрддэг бөгөөд зөвлөлийн гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэг гүйцэтгэж, жендэрийн тэгш байдлыг хангах арга хэмжээг боловсруулан, зохицуулах үүрэгтэй. Түүнээс гадна жилийн тайлан эмхэтгэн гаргах, судалгаа шинжилгээ хийх, суурь хуулийг олон нийтэд сурталчлах, орон нутгийн засаг захиргаа, төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааг, уялдаа холбоог хангах үүрэгтэй.

Бүгд Найрамдах Солонгос улс Жендэр, гэр бүлийн асуудал эрхэлсэн яамтай бөгөөд дараах хэлтэс албадуудаас бүрдэнэ. Үүнд:

Алба хэлтсүүд: Хэвлэл мэдээллийн алба

Төлөвлөлт ба Удирдлагын алба

Эмэгтэйчүүдийн бодлогын асуудал эрхэлсэн хэлтэс

Хүүхдийн халамжийн бодлогын асуудал эрхэлсэн хэлтэс

Эмэгтэйчүүдийн эрхийн хамгаалах асуудал эрхэлсэн хэлтэс

Жендэрийн тэгш байдлын асуудал эрхэлсэн хэлтэс

Үйл ажиллагаа

- Жендэртэй холбоотой төлөвлөгөө зохицуулалт бодлогуудыг төлөвлөх, зохицуулах

- Бодлогын альтернатив хувилбарыг гаргах
- Хүйсээр ялгаварлан гадуурхах явдлыг олж илрүүлэх
- Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалах
- Иргэний нийгмийн байгууллагуудтай харилцан хамтран ажиллах
- Олон улсын хэмжээнд хамтран ажиллах

Жендэрийн тэгш байдлыг ханган ажиллахад дан ганц жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний бүтэц дангаараа ажиллаад амжилт олох нь бага байдаг бөгөөд хамтран ажиллах байгууллагуудыг тодорхойлох ёстой. Үүнд:

- Чиглэлийн агентлагууд болон салбарын яамдууд
- Статистикийн төв байгууллагууд
- Харьяа байгууллагууд
- Үйлдвэрчний эвлэлийн байгууллага
- Эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагууд
- Төрийн бус байгууллагууд
- Хувийн хэвшлийн байгууллагууд болно.

Харин монгол улсын хувьд жендэрийн тэгш байдлыг хангах үйл явц Бээжингийн хурлын дараагаас буюу 1996 оноос эрчтэй эхэлсэн билээ. Монгол улсын Засгийн газраас “Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах” Үндэсний хөтөлбөрийг 11 бүрэлдэхүүн хэсэгтэйгээр боловсруулан баталсан. Хэдийгээр энэ баримт бичиг нь нийгмийн бүх хүрээг хамарч чадсан ч тодорхой үр дүнд хүрч чадаагүй юм. Үүний үндсэн шалтгааныг тухайн үедээ жендэрийн шинжээчид дүгнэхдээ үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүтэц, төсөв санхүүжилтийн эх үүсвэрийг хамтатган батлаагүйгээс болсон гэж тайлбарладаг.

Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр: “Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах Үндэсний хөтөлбөрийг” 2002 онд монгол дахь НҮБ-ын Эмэгтэйчүүдийн Хөгжлийн сангийн дэмжлэгтэйгээр шинэчлэн “Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр” болгон өөрчилж Засгийн газрын 274-р тогтоолоор 4-н үе шаттайгаар хэрэгжүүлэх болон зөвлөлдөх эрхтэй орон тооны бус 11 хүний бүрэлдэхүүнтэй Зөвлөлийг байгуулсан. Зөвлөлийн даргаар Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын дэд даргыг томилж байсан.

Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр нь 2003-2004, 2005-2008, 2009-2012, 2013-2015 гэсэн үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд эхний үе шатны хэрэгжилтийг дүгнэн 2005 оны 5 дугаар сард Жендэрийн асуудлаарх стратеги төлөвлөлтийн семинарыг зохион явуулж үйл ажиллагаагаа дүгнэсэн. Хоёрдугаар шатны буюу 2006-2008 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн стратегийг 2006 оны 1 дүгээр сард Засгийн газрын 5 дугаар тогтоолоор батлагдаад үйл ажиллагаагаа

явуулж байна. Энэхүү үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ажлын албаны оролцоо туйлын хангалтгүй байгаа бөгөөд одоогоор шууд оролцох боломж, эрх зүйн орчин нь бүрдээгүй байна. Учир нь Засгийн газрын 274 дүгээр тогтоолд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг нь Нийгмийн Хамгаалал хөдөлмөрийн яаманд байгаа билээ.

Жендэрийн тэгш байдлын Үндэсний Хороо: Монгол улсын Засгийн газраас 2005 оны 3 дугаар сард Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний зөвлөлийг Жендэрийн Тэгш байдлын Үндэсний Хороо болгон өргөжүүлж, хорооны даргаар Монгол улсын Ерөнхий сайд ажиллахаар 25 дугаар тогтоол гаргасан. Түүнчлэн Хороо нь байнгын үйл ажиллагаатай ажлын албатай байхаар шийдвэрлэсэн нь жендэрийн асуудлаарх Үндэсний механизмыг бий болгох эхлэл тавигдаж нэг алхам урагшилсан.

Хэдийгээр эхлэл нь тавигдсан гэлээ өнөөдрийг хүртэл ажлын албаны чадавхыг бэхжүүлэх талаар Засгийн газраас туйлын хангалтгүй анхаарал хандуулж байгаа бөгөөд одоо хэр нь төсөв, санхүүжилтгүйгээр хүмүүсийг ажилуулан хүний эрхийг Засгийн газар нь зөрчөөд байж байна.

Үндэсний Хороог байгуулах талаар гаргасан Засгийн газрын 25 дугаар тогтоол нь өөрөө хоёр агуулгатай, асуудлыг цэгцлэн үйл ажиллагаа явуулахад зорилго болон үйл ажиллагаа эрхлэн явуулах мандат нь тодорхой бус байгаа нь ихээхэн хүндрэлтэй байна.

Цаашид Жендэрийн тэгш байдлын Үндэсний хороо нь жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн дараах үндсэн чиглэл стратегийг хэрэгжүүлэн ажиллах зорилготой байх ёстой гэж үзэж байна. Үүнд:

- Жендэрийн тэгш байдлыг хангах замаар ядуурлыг бууруулна.
- Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг болон жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсооно.
- Сайн засаглалыг хөгжүүлэх хүрээнд эмэгтэйчүүдийн тэгш оролцоог нэмэгдүүлж тогтвортой хөгжлийг хангана.

Жендэрийн тэгш байдлын Үндэсний Хороо нь жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн хөгжлийн стратегийн зорилгыг хэрэгжүүлэхэд доорхи мандатын хүрээнд үүрэг хүлээж ажиллах Үүнд:

1. Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөрийн биелэлтийг хангахад, салбарын яамд болон салбар хороодын бодлого зохицуулалтыг уялдуулах, нөлөөлөх, мэдээллээр хангах, зөвлөн туслах ба хяналт дүн шинжилгээний үйл ажиллагааг холбогдох байгууллага, багаар гүйцэтгүүлнэ. Төрийн бус байгууллагуудыг дэмжин хамтран ажиллана.

2. Жендэрийн тэгш байдлыг хангасан хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, нийгэм, үлс төр, эдийн засгийн бүх салбаруудын бодлого, төлөвлөлтийг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх, салбарын яамд мэргэжлийн байгууллагуудыг удирдлагаар хангаж ажиллана.

3. Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийг хангах, Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг Үндэсний хөтөлбөрийг хуультай уялдуулан хэрэгжүүлэх, охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсохоор талаар бүхий л байгууллагуудтай хамтран ажиллана.

4. Жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг салбарын байгууллага, орон нутагт бий болгон давтан сургах, мэргэшүүлэх, хүний нөөцийг бий болгоно.

5. Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци ялангуяа Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах конвенцийн хэрэгжилтийг ханган хүлээсэн үүргийн дагуу илтгэлийг хүргүүлж байна. Мөн НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас гаргасан Хөдөөгийн эмэгтэйчүүдийн аж байдлыг дээшлүүлэх тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллана.

6. Жендэрийн тэгш байдлын Үндэсний хорооны ажлын тайланг жил бүр УИХ болон Засгийн газарт хүргүүлж ажлаа тайлагнана гэж тодорхойлж байна.

Монгол дахь жендэрийн асуудлаарх үндэсний механизм бүрэлдэх суурь эхлэл нь тавигдсан ч гэлээ бид олсон ололт, амжилтаа баталгаажуулан Үндэсний хороо болон түүний ажлын алба түүнчлэн хамтран ажиллах бүхий л байгууллага, хүмүүсийн чадавхыг нэмэгдүүлэх, шинэлэг мэдлэг, мэдээллээр хангах шаардлагатай байна. Үндэсний тогтолцоог бэхжүүлж, бодлогод жендэрийн асуудлыг тусгахад байгууллага, хүмүүсийг чадавхжуулах, санхүүгийн нөөцийг бий болгох нь ихээхэн чухал үүрэгтэй билээ. Бээжингийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт “Засгийн газруудаас зохих өндөр түвшинд бэхжүүлэх, тод томруун тодорхойлсон мандат ба бүрэн эрхтэй байх ёстой бөгөөд нөөц баялгаар тэнцүү хангах хийгээд бодлогод нөлөөлөх, хууль тогтоомж боловсруулах, дахин хянаж үзэх зэрэг нь түүний онцгой чухал элементүүд нь болох юм” хэмээн заажээ.


БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ

Чадавхи гэдэг нь үйл ажиллагаа, үйл хэргийг явуулахад зайлшгүй шаардлагатай чадварыг хэлэх ба чадвараа байнга сайжруулна гэсэн ойлголт юм. “Чадавхи” гэдэгт нь аливаа хувь хүн буюу байгууллага шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх, өмнөө дэвшүүлсэн зорилгоо биелүүлэх, үйл ажиллагаагаа үр дүнтэй, үр ашигтай, тогтвортой явуулах чадварыг мөн хэлнэ.

Байгууллагын өөрчлөлт, хөгжил нь хүний нөөцийн хөгжилтэй салшгүй холбоотой учраас энэ хоёр асуудлыг тус тусад нь авч үзэх боломжгүй юм. Чадавхыг бэхжүүлэх асуудал нь хувь хүний болон байгууллагын хүрээг хамрахаас гадна нийт тогтолцооны асуудлыг багтаана. Байгууллагын

чадавхад хувь хүний чадавхи үндсэн элемент болохоос гадна байгууллагын ажлын ололт, дутагдал, хөгжлийн хандлага, санхүү, материаллаг бааз зэрэг нь хамаарна.

Байгууллагын чадавхыг бэхжүүлснээр жендэрийн тэгш байдлыг ханган хөгжүүлэх таатай нөхцөл бүрдэнэ. Иймээс зөвхөн нэг байгууллагын чадавхыг бэхжүүлэх асуудал бус харин бүх газрууд /төрийн болон төрийн бус байгууллага, эмэгтэйчүүдийн байгууллагууд/-д, бүх түвшинд /орон нутгийн, бүсийн болон үндэсний хэмжээнд/ чадавхыг бэхжүүлэх шаардлагатай байдаг. Түүнчлэн байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь тухайн байгууллагын бүтэц, онцлогоос ихээхэн хамаарна.



Жендэрийн асуудлыг бодлогод тусгах чадавх нь техникийн ур чадварыг дээшлүүлж хандлагыг өөрчилнө гэсэн ойлголт юм.

Жендэрийн асуудлыг бодлогоор шийдвэрлэх алхмуудын нэг бол байгууллагын чадавхыг бэхжүүлэх явдал юм. Байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд удирдлагын мэдлэг, хүсэл эрмэлзлэл, чадвар, үүрэг хариуцлагаас ихээхэн шалтгаалдаг.

Байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь:

- Үйл ажиллагаа нь бодлого, төслийн баримт бичгийн хүрээнд тусгагдах
- Өөрчлөлтийг хянах аргачлал боловсруулах
- Хүний болон хөрөнгийн нөөцөөр хангагдах

Байгууллагын чадавхыг бэхжүүлэх стратеги нь:

- Жендэрийн бодлого ба үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөтэй байх
- Жендэрийн боловсрол олгох ажилтан нарт зориулсан сургалт зохион явуулах
- Дотоод болон гадаад харилцаа, холбоог өргөжүүлэх
- Жагсаалт, заввар боловсруулсан байх
- Жендэрийн дүн шинжилгээ хийсэн байх

- Хүйсээр ангилсан судалгааны талаар мэдээлэлтэй байх
- Ажилтан нарыг гүйцэтгэж байгаа үүрэг, чиглэлд жендэрийн асуудлыг тусгах, үнэлгээ хийх
- Ажилтан нарт тэгш боломж олгох

Байгууллагын дотор жендэрийн тэгш байдлыг хөгжүүлэх нь байгууллага дотор тэгш боломжийг бүрдүүлэх өөрчлөлтийн үйл явцад болон ажилтнуудын чадавхи, жендэрийн асуудлыг бодлогод тусгах талаарх ойлголтыг хөгжүүлэх, мөн энэ үйл ажиллагаа нь урт хугацааны туршид хийгдэж байх шаардлагатай. Үүнд үүрэг, хариуцлагаа ухамсарласан тууштай нөлөөлөх чадвартай ажилтнууд байх хэрэгтэй ба нөгөө талаасаа хөрөнгө нөөц, бусад тусламж, дэмжлэг зайлшгүй чухал юм.

Үндэсний тогтолцоог бэхжүүлэхийн тулд салбарын яамдын удирдлага, төрийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлээд зогсохгүй бусад мэргэжлийн байгууллага, ялангуяа судлаачид шинжээчдийн багийг бүрдүүлэх явдал чухал байдаг. Засгийн газар нь үйл ажиллагаандаа жендэрийн асуудлын хэтийн төлвийг заавал тусгасан байх ёстой, бөгөөд үйл ажиллагаанд шаардлагатай хүний нөөц, зарцуулалтын төсвийг нь заавал хуваарилах үүрэгтэй. Энэ алхмыг хийхэд засгийн газар хөшүүн хойрго хандаж буй тохиолдолд иргэний нийгмийн болон донор байгууллагуудын шахалт тусалцаа дэмжлэг болох ёстой.

Байгууллагын үйл ажиллагааны тунхаглал болон бодлого нь жендэрийн асуудлыг бодлогод тусгах ажлыг эхлэх маш чухал цэг нь болдог. Хэрвээ жендэрийн тэгш байдлыг бодлогын баримт бичигт үр дүнтэй тусгасан байгаа тохиолдолд жендэрийн асуудлыг бодлогод тусгах тусгай баримт бичиг боловсруулах шаардлагагүй байдаг.

Байгууллагын жендэрийн талаарх чадавхыг бэхжүүлэхэд асуудал, нөхцөл байдлын дүн шинжилгээг зорилтод бүлэгт хандуулан хийж, тэгш бус байдлын ямар баримт байна вэ?, Яагаад энэ нь асуудал болж байна вэ? гэдгийг тодорхойлоод өөрийн байгууллагын зорилгод оруулах хэрэгтэй. Үүндээ хүйсээр ялгасан тоо баримт, жендэрийн дүн шинжилгээний мэдээллийг ашиглах ёстой. Цаашид байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд:

- Жендэрийн тэгш бус байдалд хандаж байсан түүхийг тэмдэглэж авах
- Хүрэх үр дүнг тооцон гаргах
- Уриатай байх
- Одоогийн хийгдэж байгаа ажил ба хариуцлагыг тодорхойлон гаргах
- Сургалт явуулах хөтөлбөртэй байх, суралцсан сургалтын болон судалсан туршлагын жагсаалт гаргах, дүгнэлт хийх
- Амжилтанд хүрэх арга замаа тодорхойлон гаргах
- Хичээнгүйлэн ажиллах зэрэг болно.

ХУВЬ ХҮНИЙ ЧАДАВХИ БА ЖЕНДЭРИЙН МЭРГЭЖИЛТЭН ГЭЖ ХЭН БЭ?

Хувь хүний чадавхыг бэхжүүлэх гэдэг нь тодорхой орчинд аливаа чиг үүргийг гүйцэтгэх хувь хүний чадварыг дээшлүүлэх явдал юм.

Хүний чадварын үндсэн элементүүд нь мэдлэг боловсрол, ажлын туршлага, ур чадвар болно

Жендэрийн хандлагын тэгш бус байдлыг арилгах хүчин зүйлүүдийг бодлогод тусгаж хэрэгжүүлэхэд хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх, тодорхой үүрэг хариуцлага хүлээсэн ажилтан үргэлж шаардлагатай байдаг. Тэдний чадавхыг дээшлүүлэх болон жендэрт анхаарал хандлуулдаг болгох нь жендэрийн тэгш байдлыг хангах үзэл баримтлалыг хэрэгжүүлэх бололцоог бүрдүүлэх “Эхлэлийн цэг” нь болж өгнө. Өнгөрсөн үеийн туршлагаас харахад жендэрийн асуудлыг хариуцаж ажиллах хүнгүй л бол жендэрийн тэгш байдал харин ч эсрэгээр бодлогоос шахагдах магадлалтай байдаг байна.

Иймээс жендэрийн асуудлыг бодлогод тусгах үйл ажиллагааг хөгжүүлэх жендэрийн асуудал хариуцсан ажилтан нь дараах үүрэгтэй ажиллана. Үүнд:

- байгууллагын хүчин чармайлтыг тодорхойлон ажиллах,
- салбарт болон орон нутгийн түвшинд нөлөөлж буй жендэрийн болон хөгжлийн бодлогын хөтөлбөр, төсөл, баримт бичгүүдийн жагсаалт гаргах
- байгууллага болон түүний үйл ажиллагаанд жендэрийг бодлогод тусгах итгэл үнэмшил төрүүлхүйц үндэслэл, тайлбар гаргаж өгөх,
- байгууллагынхаа болон харьяа газар агентлагийн чиглэлээр жендэрийн бодлого, үйл ажиллагааны талаар хийгдсэн судалгаа, мэдээлэл дээр үндэслэн үйл ажиллагааны стратеги гаргах
- хэрэгжүүлж буй бодлого, төслүүдэд жендэрийн дүн шинжилгээ хийж, үйл ажиллагаанд нь ахиц гаргах боломжийг бүрдүүлэх, үзүүлэлтийг гаргах, хянах
- жендэрийн үзэл баримтлалыг бодлогод тусгах чадварыг хөгжүүлэх, хандлагыг өөрчлөх, мэдлэг олгох, хүсэл зоригийг бий болгох талаар мэдээлэл, сурталчилгаа, сургалтыг хамт олон болон хамтран ажиллагсдын дунд зохион явуулах
- хөрөнгө нөөцийг дайчлах
- хамтрагч болон түншлэгчийг шинээр олж харилцаа холбоогоо бэхжүүлэх
- шийдвэр гаргах явцад эмэгтэйчүүдийн оролцоо, жендэрийн ялгаатай байгаа мэдээллийг цуглуулах,
- Төсвийн хэрэгжилтэд жендэр талаас нь дүн шинжилгээ хийх, нөлөөлөх, зөвлөгөө өгөх
- Жендэрийн талаарх мэдлэг, хандлага, зуршил, үүрэг шаардлага, хэрэгцээг тодорхойлж, хүйсийн судалгааны мэдээлэл боловсруулж, сан бүрдүүлэх, танилцуулах

НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн гаргасан дүгнэлтээс жендэрийн асуудлыг бодлогод тусгах туршлагадаа “бага албан тушаалтнаас гаргасан саналыг дэмждэггүй байгууллагын захиргааны шатлал болон эмэгтэйчүүдэд мэргэжлийн хамтран зүтгэгч утгаараа зөвшөөрөгдөхөд тулгарч буй тодорхой бэрхшээлүүд” зэргийг тусгайлан тэмдэглэсэн байдаг. Жендэрийн асуудал хариуцсан ажилтан, ялангуяа бүсийн яамд, төсөл хэрэгжүүлэх багт ажиллагсдын үйл ажиллагааны үр дүн маш олон тохиолдолд хангалтгүй гарсныг Олон улсын хөгжлийн газраас боловсруулан гаргасан Жендэрийн гарын авлага номонд тэмдэглэсэн байна. Учир нь тэдний хүрч болох үр дүн нь маш өндрөөр төлөвлөгдөж байсантай холбоотой байна.

Жендэрийн асуудал хариуцсан ажилтануудад тохиолдож буй бэрхшээлүүд:

- өөрсдийн үүрэг хариуцлагын талаар тодорхой мэдлэг дутмаг
- удирдлагын зүгээс дэмжлэг авч чаддаггүй
- тэдний жендэрийн ажилд нэмэлт цаг, хөрөнгө тусгайлан гаргадаггүй
- асуудалд хандах хандлагыг тооцохгүй зөвхөн эмэгтэй хүнийг томилдог
- жендэрийн асуудал хариуцсан хүмүүс залуу, албан тушаалын зэрэг дэвээр бага байдаг ба тэд ахлах, удирдах түвшинд хүрч шийдвэр гаргахад оролцох бололцоо бараг байдаггүй
- асуудалд хариуцан ажилласан цалингийн нэмэгдэл байхгүй
- асуудлыг авч ажиллахад хувь хүний болон мэргэжлийн санаачилга, шаардлага ихээхэн тулгардаг

Энд бид нэг зүйлийг анхааралдаа хандуулах ёстой. Энэ нь жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, жендэрийн асуудал хариуцсан ажилтан хоёрын ялгааг тодорхойлж.

Жендэрийн асуудлын мэргэжилтэн нь

- байгууллагад өөрчлөлт хийх төлөөлөгч
- тухайн асуудлыг бодлогод тусгахад нөлөөлөгч
- жендэрийн тэгш байдлыг хангах асуудлыг чухалчлан авч үзэн байгууллагын манлайлал, техникийн болон менежментийн олон талт үйл ажиллагаанд оролцогч

Жендэрийн асуудал хариуцсан ажилтан нь байгууллагынхаа байнгын ажилтан байж хариуцсан үүргийнхээ дагуу ажиллана.

Чадавхыг бэхжүүлж үр дүнг сайжруулах нь жендэрийн асуудал хариуцсан ажилтны ажлын эерэг хандлага, туршлага нь ажлын эрч хүчийг хангаж бодит өөрчлөлтүүдийг хөгжүүлэн дэмжлэгийн менежмент, бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөөц ба хүрээ зэргээс шууд хамаарна.

Жендэрийн асуудал хариуцсан ажилтан нар энэ хүрээнд ажиллах тодорхой шалгууртай. Үүнд:

- жендэрийн харилцааны ойлголт болон уг харилцааг өөрчилж болох арга замуудыг ойлгох,

- өөртөө итгэлтэй байх чанарыг хөгжүүлэн, өөрийн амьдралаа удирдах эрх, хүссэн өөрчлөлтөө хийх чадвартай байх
- сонголт хийх, мэтгэлзэх, ярилцах чадвар эзэмшсэн байх
- шударга нийгэм, эдийн засгийн зохион байгуулалтыг үндэсний болон олон улсын хэмжээнд бий болгохын төлөө ажилладаг байх
- нийгэмд нөлөөлөх чадвараа дээшлүүлэх зэрэг шалгуур үзүүлэлтийг хангаж чаддаг байх шаардлагатай гэж үзэж байна.

Чадавхыг бэхжүүлэх хамгийн гол арга зам бол тасралтгүй явуулах сургалт юм.

ЖЕНДЭРИЙН СУРГАЛТ ГЭЖ ЮУ ВЭ?

1980-аад оны дунд үеэс жендэрийн сургалт явагдаж эхэлсэн бөгөөд энэхүү сургалт нь хөгжлийн бодлого боловсруулагчид, төлөвлөгчид болон хэрэгжүүлэгч ажилтнуудад эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хөгжилд оруулах хувь нэмрийн интервенцүүдийг “заах” зорилготойгоор зохион байгуулагдаж эхэлсэн байна. Түүнчлэн хөгжлийн агентлагууд болон засгийн газрын хувьд байгууллагын нийт ажиллагсдыг хамруулах богино хугацааны сургалт нь маш түгээмэл болж эхэлсэн ба энэ сургалт нь мөн чухал.

Жендэрийн сургалтын “сайн туршлага” нь бүх бүтцэд хамгийн үр дүнтэй байхаар бодолцох шаардлагатай.

Сургалтын арга нь суралцагч төвтэй байх, оролцооны аргыг хэрэглэх, чадвар мэдлэг олгох, сургагч багш нь оролцогчдын үнэлгээг хүртэх, сургалтыг үргэлжлүүлэх зэрэг багтсан байх ёстой байдаг байна.

Жендэрийн сургалтыг зохион байгуулахад сургалтын бүтэц болон бүрэлдэхүүний сайн туршлагыг сайтар мэдэх, сонгож авах нь чухал бөгөөд аль болох урт хугацааны туршид түүнийг даган хэрэгжүүлэхийг баталгаажуулах хэрэгтэй. Сургалт аль болох хүчтэй, дагаж мөрдөгдөж байх бүх арга замыг тооцоолсон байх нь чухал байдгийг анхаарах ёстой.

Хэрэв та жендэрийн сургалтыг зохион байгуулах болбол жендэрийн асуудлыг бодлогод тусгах өөр арга замыг хөгжүүлэхэд хариуцлага хүлээж байна гэсэн үг юм.

Бид Жендэрийн тэгш байдлын үндэсний механизмыг бүрдүүлэхэд зөвхөн нэг талын үйл ажиллагаа бус төр, төрийн бус байгууллагууд цаашлаад хувийн хэвшлийн болон хүний эрхийн байгууллагууд, хувь хүний хамтын үйл ажиллагааны үр дүнд жендэрийн үзэл баримтлалыг бодлогод тусган жендэрийн тэгш бус байдлыг арилган хүний тэгш эрх, тэгш үнэлэмжийг бий болгож улс орондоо сайн засаглалыг бэхжүүлэх юм байна.

НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРХ ХҮНИЙ ЭРХИЙН САЛШГҮЙ ХЭСЭГ БОЛОХ НЬ

*Д.Мөнхөө,
НУБ-ын Хүн амын сангийн соёл уламжлал, жендэр, хүний
эрхийн асуудал хариуцсан ахлах зөвлөх*

ОЛОН УЛСЫН ТҮВШИН ДАХ НӨХӨН ҮРЖИХҮЙН БОЛОН БЭЛГИЙН ХАРИЛЦААНЫ ЭРХИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТУУД

Олон улсын хэмжээнд нөхөн үржихүйн эрхийн талаар хийсэн хамгийн томоохон зөвшлийн баримт бичиг бол 1994 онд Кайр хотноо хуралдсан Хүн ам ба хөгжил олон улсын бага хурлаас баталсан Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр юм. Нөхөн үржихүйн эрх нь хүний эрхийн салшгүй хэсэг бөгөөд түүнийг хангах нь нөхөн үржихүйн эрүүл мэндийг сайжруулах нэг арга зам гэж дэлхийн 179 орон, олон улсын байгууллагууд хүлээн зөвшөөрч энэхүү баримт бичигт тэмдэглэжээ.

Нөхөн үржихүйн эрх нь

1. Гэр бүлийн хосууд болон аливаа хувь хүн төрүүлэх хүүхдийн тоо, тэднийг төрүүлэх хугацааг чөлөөтэй бөгөөд хариуцлагатайгаар шийдэх, энэ шийдвэрээ гаргахад хэрэгтэй мэдээлэл авах эрхтэй.
2. Аливаа хувь хүн нөхөн үржихүйн эрүүл мэнд/НҮЭМ/-ийн хамгийн чанартай, өндөр стандартын тусламж үйлчилгээг авах, гадуурхал, албадлага, хүчирхийллээс чөлөөтэйгөөр нөхөн үржихүйн талаар шийдвэр гаргах эрхтэй¹ гэж тодорхойлсон байна.

Энэ хуралд манай засгийн газрын төлөөлөгчид оролцож санал нэгдэн энэхүү эрхийг хангах талаар улс орон бүрийн ойрын 20 жилд хийх ажлын чиглэлийг хамтран сайшаасан юм.

Нөхөн үржихүйн эрхийн салшгүй хэсэг нь бэлгийн амьдралын эрх юм.

Бэлгийн харилцааны эрх

1. Бүх хүн өөрийн бэлгийн амьдралын талаар чөлөөтэй бөгөөд хариуцлагатайгаар шийдвэрээ гаргах эрхтэй. Үүнд бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах сонирхол хэрэгцээ нь бүрэн хамаарна.
2. Бэлгийн амьдрал, түүнтэй холбогдож гаргасан шийдвэр нь аливаа хүчирхийлэл, ялгаварлан гадуурхал, доромжлолоос ангид байх эрхтэй.

¹ Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, 7.3, 1994 он, Кайр

3. Бэлгийн харилцаа нь хамтын хариуцлагатай, бүх талын хүндэтгэлтэй, харилцан бүрэн зөвшөөрөлцсөн, тэгш эрхтэй байна.² гэжээ.

Түүнчлэн гэр бүл төлөвлөлтийн практик ажиллагаанд эрэгтэйчүүд оролцох, хариуцлага хуваалцах явдлыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарал хандуулсан юм.³

1999 оны 7-р сард Нью-Йорк хотноо чуулсан Ерөнхий Ассамблейн Хорин нэгдүгээр тусгай чуулганаар Хүн ам ба хөгжил сэдэвт Олон улсын бага хурлаас баталсан Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн таван жилийн хэрэгжилтийн байдлыг хэлэлцэж, дараачийн шатны үндсэн арга хэмжээнүүдэд нөхөн үржихүйн эрхийн талаар дараах чиглэлээр хамтран ажиллахыг уриалжээ.⁴ Үүнд:

1. Нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэндийн үйлчилгээний бодлого, стратеги төлөвлөлтийг боловсруулах хэрэгжүүлэх бүх шатанд хүний эрхийг хүндэтгэн үзэх.
2. Хүн амыг мэдээлэл, үйлчилгээнд эрх тэгш хамруулж, хүний эрэлт хэрэгцээнд нийцүүлсэн сайн чанарын үйлчилгээнд хамрагдах эрхийг хүндэтгэн хэрэгжүүлэх.
3. Үйлчлүүлэгчийн хувийн нууцыг нь хадгалан, тохь тухыг нь хангаж, хүний эрхийг хүндэтгэх
4. Эрүүл мэндийн ажилтнуудад хүний эрхийг хүндэтгэн харьцах, бэлгийн хүчирхийлэл зэрэг ёс бус үйлдлийн золиос болсон үйлчлүүлэгчдэд үйлчлэх мэдлэг дадал эзэмшүүлэх баталгаатай байх гэж заажээ.

МОНГОЛ УЛС ДАХ НӨХӨН ҮРЖИХҮЙН БОЛОН БЭЛГИЙН ХАРИЛЦААНЫ ЭРХИЙН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсын Их Хурал 2004 онд “Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-ыг баталсан юм. Энэхүү бодлогод “Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенци, Хүүхдийн эрхийн тухай конвенци, Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт, ...Мянганы хөгжлийн ...Хүн ам хөгжлийн асуудлаарх Кайрын (1994), ...Эмэгтэйчүүдийн байдлын талаарх Бээжингийн (1995) бага хурлуудын шийдвэр, Үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын Үндсэн хуульүндэсний хэмжээний хүний эрх, хөгжлийн талаар тавьж буй зорилтыг хангахад чиглэгдсэн болно” гэжээ. Эл бодлогын 1.1.6-д

² Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 7.3, 1994 он, Кайр

³ Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 7.13.1994 он, Кайр

⁴ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 21 дүгээр тусгай чуулганы материал, 1999 он

“Хүн амын, ялангуяа, эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх ойлголт, мэдлэг, үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, хүний эрх болон нөхөн үржихүйн эрхийг хангах орчныг бүрдүүлнэ” гэж маш тодорхой томъёолсон байна.

2003 оны тавдугаар сард УИХ-аас “Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого”-ыг батлан гаргасан юм. Эл бодлогод гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах үндсэн зарчмын нэг нь гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийг дэмжиж, нөхөн үржихүйн эрхийг хүндэтгэх явдал гэж заасан байна.

Монгол Улсын Засгийн Газар 1997, 2001 онуудад “Нөхөн Үржихүйн Эрүүл Мэндийн Үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж 2006 оны арваннэгдүгээр сард гуравдахь хөтөлбөрийн төсөл дээр үндэсний зөвшил хийх зорилго бүхий “НҮЭМ-ийн үндэсний гуравдугаар бага хурал”-ын бэлтгэлийг хангаж байна. 2001 онд баталсан НҮЭМ-ийн шинэчилсэн хөтөлбөрт “Монгол улсын хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн байдлыг сайжруулснаар хүн амын тогтвортой өсөлт, эрүүл мэндийг дэмжих нь энэхүү хөтөлбөрийн зорилго” гэж тодорхойлсон байна. Хөтөлбөрийн зорилтын 3.2.5-д “Бүх шатны шийдвэр гаргагчид, улс төрийн удираагчид, бодлого боловсруулагчид, хэвлэл мэдээллийн болон төрийн бус байгууллагуудын удирдах ажилтнуудын дэмжлэгийг нэмэгдүүлэх зорилго бүхий хүний нөхөн үржихүйн эрх, жендэрийн тэгш байдал, эрэгтэйчүүдийн оролцооны талаарх мэдээлэл, ухуулга, сургалт сурталчилгаанд тэднийг өргөн хамруулснаар НҮЭМ-ийн байдал тогтвортой дээшлэх эрх зүй, эдийн засаг, нийгмийн таатай орчин бүрдүүлэх” гэж заасан байна.

Нөхөн үржихүйн эрхийг хангах эрх зүйн зохицуулалтанд хийгдсэн нэг томоохон алхам нь 2004 онд УИХ-аар “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хууль батлагдсан явдал юм. Ийнхүү НҮБ-ын болон Олон улсын бусад байгууллагуудын санхүү, техникийн дэмжлэгтэйгээр нөхөн үржихүйн эрхийг улс төр, эдийн засаг, нийгмийн хүрээнд хэрэгжүүлэх явдлыг хүний эрхийг хангах, хүний хөгжлийг дэмжих, сонголтыг хүндэтгэх, амьдралын чанарыг сайжруулах, сэтгэл ханамжтай сайн сайхан амьдрах нэг чухал нөхцөл болгон тавьсан эрхзүйн орчин бүрэлдэх эхний алхам тавигдаж байна.

НӨХӨН ҮРЖИХҮЙН БОЛОН БЭЛГИЙН ХАРИЛЦААНЫ ЭРХТЭЙ ХОЛБОГДСОН НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗЭГДЭЛ, ҮР ДАГАВАР

Аливаа хууль, бодлого, хөтөлбөр эрх бүхий байгууллагуудаар батлагдан гарах нь асуудал шийдэгдсэн хэрэг хараахан бус харин шийдэгдэх үйл явцын эхлэл байх нь олонтой. Ийм хувь заяа энэ асуудлыг ч тойрсонгүй. Ялангуяа нөхөн үржихүйн эрхийн асуудал соёл уламжлал, жендэрийн хэвшмэл ойлголттой ихээхэн холбоотой. Зарим талаар мянга

мянган жил үеэс үе дамжин ирсэн өв уламжлал, соёл, шашин, итгэл үнэмшилтэй холбогдох нь их учраас хууль бодлогын нэг заалтаар шийддэгдэнэ гэж найдвал гэнэн хэрэг болж ч мэдэх юм. Гэтэл энэ асуудлыг зөв тавьж, үр дүнтэй шийдвэрлэж шийдвэр гаргагчид, гэр бүл иргэд, эрэгтэй эмэгтэй бүх хүний дэмжлэг авч чадвал Мянганы хөгжлийн зорилтыг шийдвэрлэх хамгийн таатай, тогтвортой орчинг бүрдүүлэхэд их хувь нэмэр оруулж чадах билээ.

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн болон бэлгийн амьдралын асуудлыг хувь хүний асуудал гэж хандах явдал түгээмэл байдаг. Бид олон зүйлийг өөрчилж бас өөрчлөхийг оролдож байгаа боловч энэ асуудлыг төдий л их анхаарахгүй байх шиг. Хүний эрхийн тухай маш их ярьж, бичдэг ч өөрчлөлтийн их салхи шуурч байсан 90-ээд онд “эмэгтэй хүн эх болох эсэхээ өөрсдөө шийдэх эрхтэй” гэж Эрүүл мэндийн хуулинд орсон заалттай одоо ч олон хүн санал нэгдэхгүй байгаа нь нууц биш. Энэ байр сууриа хүн амын төрөлт багасч, өсөлт буурч байгаагийн гол шалтгаан нь үр хөндөлтийг чөлөөтэй болгосон явдал гэж зөвтгөдөг. Тэд үр хөндөлтийг хуулиар хориглож байсан үед хууль бус аргыг сонгож олон арван эмэгтэй эрүүл мэндээ бүр амь насаа алдаж байсан эмгэнэлтэй түүхийг мэдэхгүй л болов уу. Үр хөндөлтийг чөлөөтэй болгосны дараа өссөн дүн түүнээс өмнө үр аяндаа зулбасан гэсэн тоотой бараг дүйж байсан үнэнийг энд дурьдахад л хангалттай нотолгоо болно байх. Өөр нэг үнэн нь хүсээгүй жирэмслэлтээ хотын, боловсролтой, ажил амьдралтай нэгэн нь таслан зогсоож чадаад алслагдсан газар, ядуу амьдралтай, мэдээлэл хомс нэгэн нь үргэлжлүүлэхээс өөр аргагүй байдаг явдал юм.

Нөхөн үржихүйн эрхийн салшгүй хэсэг бол хүний амьд явах эрх байдаг. Үр хүүхдээ тээн төрүүлэх гэж байгаад амь насаа алдаж байгааг хэрхэн тайлбарлах вэ? Сүүлийн жилүүдэд төрөхөөс болж эндсэн 312 эхийн өвчний түүхэнд судалгаа хийсэн Олон улсын байгууллагуудын зөвлөх, Английн профессор В.Хакманн эдгээр эхчүүдийн 74 хувийг аварч болох байжээ гэсэн дүгнэлт хийжээ. Үүнийг сонсоод эмч нарыг буруутгахыг урьтал болгодог нь бидний баримталж ирсэн арга. Гэтэл тэдний хэд нь нөхөн үржихүйн эрхийг хангаагүйтэй холбоотой байсныг хэн ч сонирхохгүй. Эсэн мэнд амаржих нөхцөл тэр хүнд бүрдсэн байсан уу? Тэдний 30.8 хувь суурь буюу бусад эрхтэн тогтолцооны архаг өвчин эмгэгтэй байснаас жирэмсэн, төрөх, төрсний дараа үед уг өвчин нь сэдэрч хүндрэн нас барсан байна. 45.2 хувь нь малчин, 30.8 хувь нь гэрийн ажилтай байжээ. Тэдний цаана бэлбэсэрсэн эр нөхөр, өнчирсөн хүүхэд, нийгмийн халамж үйлчилгээ шаардлагатай хүний тооны өсөлт гээд олон асуудлууд урган гарна. Харин бид юугаар ч төрүүлсэн эхийн хайр халамж, үрээ гэсэн сэтгэлийг орлуулж чадахгүй учир монголын тэр шинэ иргэнийг юу хүлээж байгааг таахад бэрх. Нөхөн үржихүйн эрхийг хангах асуудлын нарийн ширийн нь цааш нь маш олон асуудлыг хөндөж байдаг ч байж

магадгүй. Нөгөө талаас эхийн нөхөн үржихүйн эрүүл мэнд дорой бол хүүхдийнх нь эрүүл мэнд, сайн сайхан амьдрах боломж түүнийг дагаад багасна. Ээжгүй нярай хүүхдийн эндэх магадлал ээж нь эсэн мэнд нярай хүүхдийнхээс 3-10 дахин илүү байдаг. Дэлхийд жил бүр 2 сая хүүхэд ээжгүй болдог.⁵ Энэ бүхнээс харахад МХЗ-ийн эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг сайжруулж, эхийн эндэгдлийг бууруулах, энэ чиглэлээр үзүүлэх төрийн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилт нь нийгмийн олон тулгамдсан асуудлыг шийдвэрлэх суурь болж байгаа юм. Эмэгтэйчүүд гэр бүлийн сайн менежер, харамгүй хөрөнгө оруулагч, тэд дэлхийн хэмжээгээр нэг жилд үйлдвэрлэдэг бүтээгдэхүүн, үйлчилгээний тэн хагасыг хөлсгүй хөдөлмөрөөрөө бүтээж байдгийг дурьдвал энэ асуудлын ач холбогдол хичнээн өндөр болохыг ойлгоход нэн төвөггүй билээ. Эндээс харахад эх эндэхгүй байх бүх нөхцөлийг бүрдүүлэх нь нөхөн үржихүйн эрхийг хангаж байгаа хэрэг юм.

Үр хөндөлтийн тухай бид их ярих дуртай бөгөөд эмэгтэйчүүдийг ихэнхдээ буруутгадаг. Бүр зарим хүн үр хөндүүлэх гэдэг гарт орсон өргөс авахаас хялбар юм шиг ойлгодог. Үр хөндөлтийг чөлөөтэй болгосноос л хамаг юм боллоо гэж улс төр хийх нь ч бий. Үр хөндүүлэхээр нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар шийдвэр гаргана гэдэг эмэгтэй хүний сүүлчийн гарц. 2005 оны байдлаар манайд мянган амьд төрөлтөнд 200 үр хөндөлт ногдож байна.⁶ Энэ бол их тоо. Бас бүрэн мэдээлэгдээгүй ялангуяа хувийн эмнэлгүүдэд хийгдэж байгаа үр хөндөлтийн мэдээг бүрэн авч чадахгүй байгаа юм. 1998 оны НҮЭМ-ийн түүвэр судалгаагаар 5 эмэгтэйн нь нэг нь буюу 19% нь хүсээгүй жирэмсэлж байв.

Хүүхэд тээж төрүүлэх таатай нөхцөл тэр хүнд байхгүй байгаагаас ийм шийдвэр гаргаж байгаа хэрэг. Гэтэл жирэмслэлтээс хамгаалах эм хэрэгслэлийг НҮБ-ын Хүн Амын Сан сүүлийн жилүүдэд эмэгтэйчүүдийг сонголт хийхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор үнэ төлбөргүй орон даяар тараасан. Ийм байхад яагаад үр хөндөлт өндөр байна вэ? гэсэн асуулт зүй ёсоор гардаг. Үр хөндүүлсэн шалтгаанаа ихэвчлэн хүүхэд төрүүлэх бодолгүй, амьдралын бололцоо муу, эрүүл мэндийн байдлаас гэх буюу суралцахаа үргэлжлүүлэх гэх мэтээр ихэнх судалгаанд хариулсан байх юм. Харин 1996 онд Эх нялхсын эрдэм шинжилгээний төв, нийслэлийн гуравдугаар амаржих газар үр хөндүүлсэн 400 гаруй эмэгтэйчүүдийн 40 орчим хувь яагаад үр хөндүүлж байгаагаа хариулахаас татгалзсан байна. Бэлгийн хүчирхийлэлд өртөх, төрүүлэх хүүхдийн тоо, хугацааны хувьд болон жирэмслэлтээс хамгаалах эм хэрэгслэлийг хэрэглэх талаар нөхөр, хадам, төрхөмтэйгөө санал нийлэхгүй байх, гэр бүлийн сөргөлдөөнт байдал гээд эмэгтэйчүүдийг үр хөндүүлэхэд түлхэж байгаа олон шалтгааныг бид

⁵ Дэлхийн хүн амын илтгэл, 2006 он, НҮБХАС

⁶ Эрүүл мэндийн үзүүлэлт, 2005 он, ЭМХҮТ

тодруулж чадахгүй байгаа бөгөөд судалгааны арга барилыг ч суралцах хэрэгтэй байгаа юм. 2003 онд орон даяар явуулсан НҮЭМ-ийн түүвэр судалгаанд хамрагдсан үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн 36.8 хувь шийдвэрээ ганцаараа гаргасан гэж хариулсан нь анхаарал татаж байна. Бид үр хөндөлт их байгаад эмэгтэйчүүдийг буруутгадаг. Гэтэл үр тогтоно гэдэг байгалийн үзэгдэл эрэгтэй, эмэгтэй хоёр хүний оролцооны үр дүнд буй болдог. Судалгаанд оролцсон нөхрүүдийн 51 хувь үр хөндүүлэхийг хуулиар зөвшөөрснийг буруу гэж үзжээ.⁷ Зарим оронд эмэгтэй хүнийг үр хөндөхөд хүргэсэн эрчүүд үр хөндөлтийн үнийг төлөх, өндөр торгууль төлөх гээд механизмууд байдаг. Манайд эрэгтэйчүүдтэй хариуцлага хуваалцах зарчмыг хэрэгжүүлэх ямар ч хуулийн зохицуулалт байдаггүй. Гэр бүл салсны дараа эхчүүдийн 83 хувь хүүхдэдээ байнгын анхаарал тавьдаг бол эшгүүдийн 37 хувь л анхаардаг байна.⁸ Нөхөн үржихүйн эрхийг хангахад эрэгтэйчүүдийн мэдлэг, хандлагыг өөрчлөх их ажил шаардагдаж байна.

Нөхөн үржихүйн эрхтэй холбоотой өөр нэг асуудал бол өсвөр үеийнхнийг, хөвгүүд, охидыг эрхийн ухамсар, соёл, мэдлэг, зан үйлтэй болгон төлөвшүүлэх асуудал юм. Охидын жирэмслэлт манайд харьцангуй их байна. Сүүлийн жилүүдэд амаржсан эхчүүдийн 7-8 хувь, 2005 онд 6 хувь өсвөр насныхан байв⁹.

Охид үр хөндүүлэх явдал ч нэмэгдсээр байна. 1999 онд 15-19 насны охидын үр хөндөлт нийт үр хөндөлтийн 5.7 хувь байсан бол 2003 онд 8.3 хувь болтлоо өссөн байна. Хүн амын 24 хувийг эзлэж, ойрын ирээдүйд монгол улсыг авч явах түүхэн үүрэгтэй өсвөр үеийнхэндээ ямар мэдлэг, зан үйл төлөвшүүлж байгааг эргэж харах цаг болсон. Өсвөр үеийнхэнд зориулсан тэдэнд ээлтэй үйлчилгээг бид зөвхөн олон улсын байгууллагын хөрөнгөөр алаг цоог энд тэнд байгуулж сургаж бэлтгэсэн хүний нөөцийг нь тогтвортой ажиллуулж чадахгүй байгаа нь нууц биш.

Өсвөр үеийг бэлгийн харилцаанд хүчээр оруулах явдлыг бэлгийн харилцааны эрхийг ноцтой зөрчиж байгаа хэрэг гэж ойлгохгүй байх хэвшмэл ойлголт, хандлага нилээд тархмал байдаг. Нэгэн тохиолдлыг энд дурдъя. 90-ээд оны эхээр Монголын шинэ Үндсэн хуулийг тэр үеийн Ардын Их Хурлын чуулганаар хэлэлцэх явцад хүчингийн хэрэг үйлдсэн гэх нэгэн олны танил хэрэгтэнг суллах тухай асуудал тавигдаж халуун маргаан болж байсан юм. Тэр үед Монголын нэртэй зохиолч, АИХ-ын депутат эрэгтэй тэр хүндтэй индрээс “малын билчээрт өдөр бүр болж байдаг зүйл шүү дээ” гэж хэлсэн нь эмэгтэй депутатуудын дургүйцлийг хүргэж байсан юм. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн охины ярианаас иш татахад”...Эргээд бодоход тэр өдөр малд яваагүй байсан бол тэр ах намайг хүчиндэхгүй,

⁷ НҮЭМ-ийн түүвэр судалгаа, 2003 он, НҮБХАС

⁸ Монголын гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал судалгааны тайлан, 2004 он

⁹ Эрүүл мэндийн үзүүлэлт, 2005 он, ЭМХҮТ

би жирэмсэлж хүүхэд гаргахгүй байсан. Уг нь тэр өдөр манай эмээгийн хонины ээлж байсан ч, даралт нь ихэссэн болохоор би явсан. Тэр өдөр эмээгийн даралт ихсээгүй байсан болоосой гэж бодох юм. Намайг хонинд явсныг манай айлын залуу хэлж өгсөн байх гэж санадаг..." гэж 16 настай эх өгүүлжээ¹⁰

Өсвөр үеийнхний нас, сэтгэхүйн онцлогийг харгалзсан тэдэнд ээлтэй үйлчилгээ, мэдээлэл өгөх арга барил дутагдаж байгаа нь тэдний нөхөн үржихүйн эрх, бэлгийн харилцааны эрхийг хамгаалахад томоохон саад болж байна. Нууцыг нь хадгалах хамгийн ээлтэй орчин, үйлчилгээ байх ёстой. Хүн бүр л өсвөр насыг дайрч ирсэн боловч ээлтэй хандах үйлчилгээнд байнга алдаа гаргаж байна. Охид, хөвгүүд минь айж эмээхгүйгээр очоод үйлчилгээ, зөвлөлгөө авчих газар хаана байна вэ? Бид үр хүүхэдтэйгээ нөхөн үржихүйн эрүүл мэнд бэлгийн амьдралын талаар илэн далангүй ярилцаж зөвлөж чаддаггүй уламжлалтай ард түмний үр сад. Энэ байдлаар байгаад байвал юу болох вэ? Охид хөвгүүд минь нөхөн үржихүйн болон бэлгийн харилцааны эрхийн талаар боловсролтой, зөв зан үйлтэй хүмүүс болон төлөвшөл хичнээн аюулаас бид зайлсхийж чадах вэ? Энэ бол өсвөр үеийн охид, хөвгүүд бүрийн, гэр бүлийн, нийгмийн өмнө тавигдаж байгаа нэн хурц асуудал яах аргагүй мөн билээ.

Бэлгийн харилцааны эрхийг зөрчих нэг хэлбэр бол хүчингийн гэмт хэрэг юм. Монгол Улсын цагдаагийн байгууллагуудын хэмжээнд 1998-2000 онд нийтдээ 1146 хүчингийн гэмт хэрэг бүртгэгдсэний 493 нь Улаанбаатар хотод гарчээ. Гэтэл энэ хугацаанд Нийслэлд байрладаг Халдварт Өвчин судлалын төвд хүчиндүүлсэний улмаас бэлгийн замаар дамжих халдвар авсан эсэхээ шинжлүүлэхээр 734 охид, эмэгтэйчүүд хандсан байна. Харин шүүхээр 191 хэрэг шийдвэрлэгдсэн байна.¹¹ Энэ тоо мэдээллийн цаана хохирогчийг буруутгадаг нийгэмд тогтсон хэвшмэл ойлголт, хуулийн олон шатны ажилтнуудын мэрэгшээгүй байдал, хэргийн өвөрмөц байдалд тохирсон хуулийн оновчтой зохицуулалт дутмаг, хохирогчийг дэмжсэн нийгмийн ажлын үйлчилгээ хөгжөөгүй зэрэг тогтолцооны гажуудлаас шалтгаалан чимээгүй шаналж яваа хүн хичнээн байгааг таахад нэн бэрх.

Бэлгийн мөлжлөгийн хэлбэрүүд түүний дотор биеэ үнэлэх, үнэлүүлэх, хүн худалдаалах гэмт хэргүүд гарах явдал нэмэгдсээр байгаа тухай хэвлэл мэдээллийн хэрэгслэл болон Төрийн Бус байгууллагуудын судалгаа, тайланд дурьдагдсаар байгаа боловч хууль тогтоогчид энэ талаар эрх зүйн зохицуулалт хийхийг яарахгүй байгаа бололтой. Биеэ үнэлдэг эмэгтэйчүүдийн тоо нэмэгдэж, насанд хүрээгүй охид олноор биеэ үнэлдэг болж байна. Эмэгтэйчүүд гадаад орнуудад олноор зорчин биеэ үнэлэх, худалдагдах явдал нэмэгдэх хандлагатай болж байна.

¹⁰ Өсвөр насныхны жирэмсэн болон төрөлтийн талаарх чанарын судалгаа, 2003 он, НҮБХАС

¹¹ Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлийн талаарх тоо баримт, 2001 он, ХЭҮТ

Хот хөдөөгүй зочид буудал хаягтай олон зуун оромжууд буй болж бизнес хийж байгаа тухай ярьж байгаа ч хөшигний цаана юу болж байгааг мэдсээр, бас сануулсаар байхад мэдээгүй юм шиг явцгааж байна. Энэ бол бэлгийн мөлжлөг, бэлгийн харилцааны эрхийн зөрчлийг даамжруулж байгаа хамгийн ноштой асуудал юм. Цагдаагийн байгууллагын мэдээгээр хүн худалдах гэмт хэрэг 21 бүртгэгдсэн боловч шүүхээр 1 л хэрэг шийдвэрлэгдсэн байна.¹²

Нөхөн үржихүйн эрхийн зөрчил тод илэрч байгаа нэг талбар бол ХДХВ/ДОХ-оор өвчлөгсдөд хандаж байгаа хандлага, эмэгтэйчүүдийн өртөмтгий байдлын даамжралт юм. Бэлгийн замаар дамжих халдварын тархалт анхаарал татаж нийт халдварт өвчний дотор 42 хувь эзлэх болж өвчлөгсдийн 70 орчим хувь 25 хүртэлх насныхан эзлэх боллоо.

Охид эмэгтэйчүүд нь зөвхөн биологийн нөхцөл байдлын хувьд төдийгүй эдийн засаг, нийгмийн хувьд эрх тэгш бус байгаа явдал, түүнчлэн эмэгтэйчүүдийг ялангуяа бэлгийн харилцаанд эрчүүдийн үгийг дагах ёстойд тооцох хэвшмэл үзэл хандлагууд, ядуурал, хүчирхийлэл, эмэгтэйчүүдийг доорд үзэх үзэл зэргээс шалтгаалан эмэгтэйчүүдийн ХДХВ-ээр халдварлах эрсдэл өндөр байна. Биеэ үнэлэх, биеэ үнэлэгчдийг авах нь ХДХВ/ДОХ/БЗДХ тархах томоохон эрсдэлт хүчин зүйл болж байна

ДОХ-ын халдвар тархаж байсан эхний жилүүдэд эрэгтэйчүүд зонхилон өртөж байсан бол одоо халдвар авсан 40 сая хүний тэн хагас нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд түүний дөрөвний гурав нь эрэгтэй эмэгтэйчүүдийн хооронд дамжиж байгаагийн багагүй хэсэг нь нөхрөөс эхнэрт нь дамжиж байна. Гэр бүлтэй ХДХВ-ын халдвар авсан эмэгтэйчүүдийн 70 орчим хувь нь нөхрөөсөө халдвар авсан байгаа аж. ХДХВ/ДОХ-ын халдвар тээгчдийн тоо нэмэгдэж байгаа манай орны хувьд эмэгтэйчүүд, охид биеэ үнэлэх үзэгдэл газар авч байгаа нөхцөлд маш анхааралтай хандах хэрэгцээ буй боллоо.

Жендэрийн тэгш эрхийг хангах нь нөхөн үржихүйн болон бэлгийн харилцааны эрхийг хэрэгжүүлэх нэг гол нөхцөл болдог. Жендэр хэмээх үг нилээд танил болж амьдралын бүх хүрээнд хүйсийн тэгш байдлыг хангах явдал хүн төрөлхтний өмнө тулгарч байгаа хүний эрх, хөгжлийг хангах, ядууралтай дэлхий нийтээр тэмцэх арга зам, зангилаа асуудлын нэг болон хүчээ авч түүнд эрх мэдлийг хэрэгжүүлэгчид, манлайлагчид, салбарын мэргэжилтнүүд, жирийн хүмүүс итгэл үнэмшилтэй хандах боллоо.

Жендэр судлалын үндэсний чадавхи султай манай орны хувьд 1996 оноос хойш ихэнхдээ НҮБ-ын болон олон улсын донор байгууллагуудын санхүүгийн дэмжлэгтэйгээр жендэрийн асуудлаар 30 шахам судалгаа хийгдэж нийтийн хүртээл болсон байна.

¹² Хүний эрх хөгжил төв ТББ-ийн илтгэлээс, 2006 он

Тухайлбал НҮБХАС-гийн дэмжлэгээр “Нөхөн үржихүйн эрүүл мэнд, жендер ба эрх “2000 онд, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн Хөгжлийн Сангийн дэмжлэгтэйгээр “Монголын эмэгтэйчүүд шилжилтийн үеийн дэвшлийг зураглахуй” 2001 онд, “Монголын хөдөө дахь жендерийн дүр зураг” гэх мэт. Харин НҮЭМ-ийн асуудлыг жендерийн байр сууринаас судалсан цогц судалгаа хараахан хийгдээгүй байна.

2005 онд Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банк хамтран “Монголын жендерийн байдал” гэсэн үнэлгээний тайлан хэвлүүлсэн байна. Энэ судалгаанд Өөрчлөлт шинэчлэлтийн энэ үед Монголын эдийн засаг, нийгмийн хөгжлийн олон салбарт жендерийн шинэ, шинэ зөрүү бий болж байна.

Жендерийн сэдэлтэй бүх төрлийн хүчирхийлэл тэр дундаа гэр бүлийн хүчирхийлэл, ажлын байран дахь болон олон нийтийн газар дахь бэлгийн дарамт, мөн эмэгтэйчүүдийг хил дамжуулан худалдаалах зэрэг шилжилтийн нэмэлт үр дагавар газар авч байна гэж дүгнэжээ.

Жирэмслэлтээс хамгаалах хэрэгслэл, арга нь хэт эмэгтэйчүүд хэрэглэхэд чиглэсэн байгаа нь эрэгтэйчүүд үүнд тоомсоргүй хандах нэг шалтгаан болж байгаа бөгөөд энэ ч жендерийн тэгш бус байдал байгаагийн нэг нотолгоо юм. Цаашид эрэгтэйчүүд хэрэглэдэг ЖХЭХ-ийг олшруулах чиглэлээр эрэл хайгуулыг өргөтгөх шаардлагатайг харуулж байна.

Ялангуяа эмэгтэйчүүд толгойлсон өрх сүүлийн жилүүдэд өсч нийт өрхийн 16 орчим хувийг эзлэж байгаа бөгөөд тэдний 43.8 хувь ядууралд өртсөн нь эрэгтэй тэргүүлэгчтэй өрхтэй харьцуулахад 9 хувиар өндөр байна. 2003 оны судалгаагаар Орлого багатай эмэгтэйчүүдийн төрөлт их байгааг мэдээлсэн байна.

Огт орлогогүйгээс сард 8500 төгрөгийн орлоготой эмэгтэйчүүдийн Төрөлтийн Нийлбэр Коэффициент /насан туршдаа төрүүлсэн хүүхдийн тоо/ нь 2.70 байгаа нь сард 42500-гаас их орлоготой эмэгтэйчүүдийнхээс 0.49-өөр их байна. Орлого багатай эхчүүдийн болон тэдний тээж төрүүлж байгаа хүүхдийн эрүүл мэнд, эрхийг хамгаалах үүднээс төрөөс үзүүлэх хүнс тэжээл, эрүүл мэнд, нийгмийн халамж, хамгааллын сайтар боловсруулсан урт удаан хугацааны дэмжлэгийн стратеги хэрэгжүүлэх хэрэгцээ нэмэгдэж байгааг энэхүү үзүүлэлт харуулж байгаа.

**НӨХӨН ҮРЖИХҮЙН БОЛОН БЭЛГИЙН ХАРИЛЦААНЫ ЭРХИЙГ
ХАНГАХАД ЧИГЛЭСЭН ХУУЛИУДЫН ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛЖ
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗОРИЛТ ТАВИГДАЖ БАЙНА**

Ядуурлыг бууруулж, МХЗ-ыг үр дүнд хүргэх нь аливаа улс орны шинэ мянганд хийх гол ажил. Өнөөдөр хөгжиж байгаа дэлхийн орнуудад бэлгийн болон НҮЭМ доогуур байгаа нь нас баралт, хөдөлмөрийн чадвар алдалтын гол шалтгаан болж байна. Энэ байдал нь дундач наслалтыг

богиносгож, боловсрол олох боломжийг хязгаарлаж, хувь хүний чадавхжиж, үр бүтээлтэй амьдрахад саад учруулснаар эдийн засгийн өсөлт, ядуурал бууруулахад сөрөг нөлөө үзүүлж байна. Жил бүр хагас сая эмэгтэйчүүд төрөлтөөс болж амь насаа алдаж, 3 сая хүн ДОХ-оор нас барж минут бүр 10 хүн ХДХВ-гийн халдвар шинээр авч байна. Ядуу хүмүүс боловсрол, эрүүл мэндийн түүний дотор нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ, мэдээлэл хүртэх нь хязгаарлагдаж үе дамжсан ядуурлын гинж үүсгэж байна. Дэлхийн банк төрөлтийн болон яаралтай тусламжийг өндөр үр чадвартай үзүүлж чадвал эхийн эндэгдлийг 74 хувь бууруулж болно гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Мексик улсад хийсэн судалгаагаар 1972-1984 онд НҮЭМ-эд зарцуулсан 1 песо нь үр хөндөлтийн хүндрэлийг эмчлэх, эх, хүүхдийн тусламжинд зарцуулж байсан 8 песог хэмнэжээ. Тайландад гэр бүл төлөвлөлтөнд зарцуулсан 1 доллар дээрх чиглэлээр зарцуулж байсан 16 доллар хэмнэх боломж олгожээ.

Нөхөн үржихүйн эрхийг хангах асуудал зөвхөн эрүүл мэндийн асуудал бус нийгэм, эдийн засгийн байдалд нөлөөлдөг болохыг дээрх баримтууд харуулж байна.

Иймээс энэ чиглэлээр гарсан хууль, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байгаад анхаарал хандуулж, хэрэгжилтийг хангуулахад чиглэсэн дэс дараатай арга хэмжээ авах шаардлагатай байна. Тухайлбал: Жирэмслэлт төрөлттэй холбоотой бүх зардлыг төр хариуцна гэсэн хуулийн заалт бүрэн хэрэгжихгүй байна. Шатлалын тусламж гэж эмнэлгийн хэлээр ярьдаг сумаас аймагт, аймгаас нийслэлд нарийн болон өндөр нарийн мэргэжлийн тусламжинд очиж амаржих шаардлагатай нь эмнэлгийн байгууллагаар тогтоогдсон эх мөнгө, зардал байхгүйгээс явж чадахгүй амь насаа алдах явдал гарсаар байна. Судлаачид “хожимдол” гэсэн нэр өгч судалгааны нэг судлагдахуун болтлоо бид дасаж байна. Аймгуудын төрөх тасагт амаржиж байгаа эхчүүдийн тэн хагас нь хөдөө сумаас эмнэлгийн заалтаар болон сайн эмч бараадан ирсэн үйлчлүүлэгч эзлэж ачаалал нь ихээхэн нэмэгдээд байна. Үүнтэй холбогдуулан авах арга хэмжээ удааширсаар байна. Нийслэлд ч ачаалал ихэссэнтэй холбогдон нярайн халдвар гарлаа гэх шуугиан шар хэвлэлүүдийг мэдээлэлээр хангаж, эмч эмнэлгийн ажилчдыг буруутгахаас хэтрэхгүй байна.

Нөхөн үржихүйн эрхийн хангагдахгүй байгаа баримтыг хаанаас ч олж болох бөгөөд энэ нь эрхтэй ямар холбоотой, эрхэд суурилсан бодлого, хууль, хөтөлбөр, арга барил дутагдсаны үр дагавар юу болохыг гаргаж тавих түүний дагуу төр нь ч, иргэн нь ч анхаардаг, арга барил, хандлагаа өөрчилдөг болох нь бидний хийх ёстой гол ажил юм шиг санагдаж байна.

Шашин соёл уламжлалд байгаа хэвшмэл ойлголт, дэвшилт бус хандлага, хүний танин мэдэхүй хомс байсан үед тогтсон үзэл баримтлалыг эргэн харж хандлагаа өөрчлөх энэ талаар хүмүүст зөвлөх, итгэн үнэмшүүлэх арга барилаа сайжруулах хэрэгтэй байна.

Садар самуунтай тэмцэх хуулийг эргэн харж хууль цагдаагийн байгууллага нь биеэ үнэлэгчдийг илрүүлэхэд бус харин үүний ард нуугдаж байгаа хүн худалдаалах, эмэгтэйчүүд хүүхдийг бэлгийн мөлжлөгийн золиос болгож байгаатай тэмцэж тэдний нөхөн үржихүйн болон бэлгийн харилцааны эрхийг хангахад туслах чиглэлээр ажиллах хэрэгтэй байна. Энэ бол хүний эрхийг хамгаалахад чиглэсэн цоо шинэ хандлага байх болно. Түүнчлэн биеэ үнэлүүлэгчээр үйлчлүүлж байгаа хүмүүст хариуцлага тооцох зохицуулалт хийх хэрэгтэй. Биеэ үнэлэхээс өөр аргаар орлого олох нөхцөл боломжийг нэмэгдүүлэх эдийн засаг нийгмийн арга хэмжээ авах.

Хохирогчид өөрсдийн эрх нь зөрчигдсөн талаар мэдээлэхийг хөгжүүлэн дэмжих нөхцөл, журам горимыг хүнд ээлтэй болгон боловсронгуй болгох хэрэгтэй байна. Энэ асуудлын талаар хууль гаргах, байгаа хуулиа улам тодорхой болгох бөгөөд хүчтэй болгох хэрэгтэй.

2004 онд Страсбургт парламентын гишүүд хуран чуулж нөхөн үржихүйн эрх болон эрүүл мэндийг дэмжсэн уриалга гаргаж орон бүрийн парламентад нөхөн үржихүйн эрхийг хангахад чиглэсэн хууль тогтоомжийг боловсруулан батлах, түүний хэрэгжилтэнд тавих хяналтаа улам дээшлүүлэхийг уриалсан нь тохиолдлын хэрэг биш билээ. Энэ асуудалд дэлхий нийтийн анхаарал хандуулсан юм.

Эрүүгийн ба Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг эргэн харж хохирогчийг хамгаалах дэмжих, хохирлыг арилгах талаас нь бодож шинэ зохицуулалт хиймээр байна.

Улсын Дээд Шүүх, Шүүхийн судалгааны төвөөс Хүн худалдах гэмт хэргийн талаар хуулийн тайлбар гаргах хэрэгцээ амьдралд буй болжээ.

Элчин сайдын яамд, консулын газрууд иргэнээ хамгаалах, дэмжлэг үзүүлэх, гэмт хэргийн золиос болсон иргэдээ дэмжих талаар тодорхой үүрэг хүлээж ажиллахаар бодох цаг аль хэдийнэ болжээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн хэрэгжилт нэн хангалтгүй байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийн хэргийг шийдвэрлэхдээ эрүүгийн болон захиргааны хариуцлагын хуулийг хэрэглэж шинэ хуулийг бараг хэрэглэхгүй байна. Хуулийн ажилтнуудыг сургаж бэлтгэх, хөрөнгө нөөцийг хуваарилах, хэрэгжүүлэх механизмыг буй болгох ажил удааширсантай холбоотой. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийг хэрэгжүүлэхийн тулд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг боловсруулан батлах ажлыг яаравчлах, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулан гаргах ёстой заавар, журам, хөтөлбөрүүдийг яаралтай батлан гаргамаар байна.

Нөхөн үржихүйн болон бэлгийн харилцааны эрхийн асуудлаар зарим нэг зүйлийг хөндөн өгүүлэхэд ийм байна.

“ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ” ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Д.Энхжаргал
ХЭҮТ-ийн захирал

Хүн бүр эрх чөлөөтэй, аюулгүй байх, хувийн болон нийгмийн амьдралын хүрээнд бүхий л хэлбэрийн хүчирхийлэл, дарамтаас ангид амьдрах эрхтэй.

Бие даасан хуулийн ач холбогдол:

2004 оны 05 сарын 13-нд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хууль батлагдаж, хувийн орчиндоо айдас түгшүүргүйгээр амьдрах жам ёсны эрхийг баталгаажуулсан. Ингэснээр ойр дотны хүмүүсээ дарамтлах нь хувийн хэрэг, гэр бүлийн дотоод асуудал биш нийгмийн зүгээс анхаарвал зохих хүний эрхийн ноцтой зөрчил болохыг хүлээн зөвшөөрч, төрийн оролцоог хуульчилж өгснөөрөө чухал дэвшлийн үүдийг нээсэн билээ.

Хууль батлагдсан явдал нь дан ганц эрхзүйн тогтолцоонд бус нийгмийн дунд олон зуун жил оршин тогтнож буй хэвшмэл үзэл хандлагад ч давхар томоохон өөрчлөлтийг бий болгох үр нөлөөг авчирч байгаа. Энэхүү хууль батлагдсанаар гэр бүл дэх хүчирхийлэл бүрэн устахгүй ч “гэр бүлийн гишүүддээ хүчирхийлэл үйлдвэл хуулийн хариуцлага хүлээх юм байна, төр хөндлөнгөөс иргэнээ хамгаалах гэж оролцдог юм байна” гэдгийг ойлгуулахад гол үүрэг гүйцэтгэсээр байх болно.

Гэр бүл дэх хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах явдал нь аюулгүй байдал, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамж, хамгаалал гэх мэт олон салбарын цогц шийдлийг шаарддаг онцлогтой. Энэ онцлогийг тус хуулинд маш сайн харгалзаж, салбар хоорондын зохицуулалтыг хуульчилж өгсөн. Ингэснээр гэр бүл дэх хүчирхийлэлтэй тэмцэх асуудал зөвхөн санаа тавьсан ганц нэг ТББ-дын сайн дурын үндсэн дээр хийгддэг ажил биш төрийн өөрийнх нь үүрэг хариуцлага болж өөрчлөгдсөн юм.

Энэ мэтчилэн тооцоод байвал энэ хуулийн ач холбогдол үнэхээр их. Гэхдээ хичнээн сайн хууль байлаа ч хэрэгжихгүй бол цаас л болж хувирна гэдгийг энэ хуулийн хэрэгжилт батлан харуулж байна.

Хэрэгжилтийн явц:

“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хууль батлагдаад 2 жил 4 сар, хэрэгжиж эхлээд 1 жил 9 сар болж байгаа ч хуулийн хэрэгжилт туйлын хангалтгүй байсаар байна.

2005 онд гарсан хүний амь нас хохирсон гэмт хэргийн 49,4%, бусдын бие махбодид гэмтэл учруулсан гэмт хэргийн 35,9%, танхайрах гэмт хэргийн 35% нь зөвхөн гэр, орон сууцанд буюу ахуйн хүрээнд үйлдэгдсэн, улсын хэмжээнд бүртгэгдсэн 4 гэмт хэрэг тутмын 1 нь гэр, орон сууцанд гарчээ.

Цагдаагийн байгууллагын мэдээнээс

Дээрх тоо баримт нь нөхцөл байдал ямар байгааг төвөггүй ойлгуулна гэж найдъя. Харамсалтай нь өнөөг хүртэл гэр бүлийн хүчирхийллийн тохиолдлыг бүртгэх тусгайлан асуулга гэмт хэрэг, зөрчлийг бүртгэх дүн бүртгэлд тусгагдаагүйгээс нэг бүрчлэн гаргаж ирэх боломж алга. Гэсэн хэдий ч цагдаагийн байгууллагад ирж байгаа дуудлагын 60-70 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн дуудлага байдаг гэдгийг засаг захиргааны анхан шатны нэгж дээр ажиллаж байгаа цагдаагийн ажилтнууд батлан хэлдэг. Өдөр тутмын сонинуудад мэдээлэгдэж байгаа хүн амины ноцтой хэргүүд ихэвчлэн гэр бүлийнхээ гишүүдийг толгой дараалан, маш харгис хэрцгийгээр тамлан зовоож, хүйс тэмтэрсэн хэргүүд байна. Эндээс үзэхэд энэ хуулийн хэрэгцээ асар их байгаа нь ойлгомжтой.

Гэвч хууль батлагдсанаас хойшхи хугацаанд улсын хэмжээгээр үндсэндээ **зургаахан** хэрэгт л шүүхийн шийдвэр гарсан байна. Манай төвийн оролцоо, шахалтаар шүү. Бүхэл бүтэн 2 жилийн хугацаанд гарын арван хуруунд багтах төдий хэрэг шүүхээр шийдвэрлэгдэж хохирогчийг хамгаалалтанд авах, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцох эхний алхам хийгдсэнийг дээрх тоо баримтуудтай харьцуулахад газар тэнгэр шиг зөрөө гарч байгааг та бүхэн анзаарч байгаа байх. Ийм цөөхөн хохирогч л хуулийн хамгаалалтыг авч чадсан байна. Бусад хохирогчдын хувьд хуулийн хамгаалалт гэдэг нь хүрэхэд хол шидэт алим хэвээр байсаар байна.

Зарим тохиолдолд ийм хууль гарсныг ч сонсоогүй, гараараа тэмтэрч ч үзээгүй шүүгчид байна. Аргаа барахдаа хуулийг барьж очиж шийдүүлж байсан тохиолдол бидэнд бий.

Гэр бүлийн хүчирхийллийн хэргийг шүүхэд аваачихад цагдаагийн байгууллага гол үүрэгтэй. Учир нь **энэ хуулиар хохирогч цагдаагийн байгууллагад харьяалал харгалзахгүй хандах эрхтэй**. Тухайлбал Сонгинохайрхан дүүргийн иргэн Сүхбаатар дүүргийн цагдаагийн байгууллагад хандах боломжтой гэсэн үг. Энэ зохицуулалт нь хохирогчийн аюулгүй байдлыг шуурхай хамгаалах баталгаа болж хуульчлагдсан. Гэвч

дүүрэг алгасан үйлчлэх бүү хэл өөрийн хариуцсан хорооны үйлчлүүлэгчийнхээ аюулгүй байдалд хэрхэн хандаж байгааг доорх жишээ харуулна гэж бодож байна. Эндээс та бүхэн засаг захиргаа болон хуулийн байгууллагууд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлж, иргэний аюулгүй байдлыг хамгаалахад анхаарлаа хандуулах бус асуудал нэгэнт болоод өнгөрсөн хойно нь гал унтраах маягаар л ажиллаж, зөвхөн хэн нэгнийг шийтгэхийн тулд оролцдог хуучин арга барилаар ажилласаар байгааг харж болно. Мөн төр асуудлыг зохицуулахдаа мэдрэмжгүй, хохирогчдын хэрэгцээг харгалзан үзэхгүйгээр хөндлөнгөөс оролцвол ямар уршигт үр дагаврыг бий болгож болохыг үзэх болно.

10 настай хүү амиа хорлосонд төр буруутай

2005 оны 5-р сард хойд эцгийн дарамт хүчирхийллийн улмаас 10 настай хүү амиа егүүтгэсэн ноцтой хэрэг гарсан билээ. Хорооны удирдлагууд, цагдаагийн болон нийгмийн ажилтан нар сонгуулийн ажлаар айлуудаар явж байгаад хойд эцэг нь хүүг зодож байх үйлдэл дээр нь орчихжээ. Тэд бүгд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах үүрэг хүлээсэн мэргэжилтнүүд. Гэвч тэд хойд эцгийг нь Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу баривчлах арга хэмжээ аваад л мартчихаж. Эцэг нь баривчлагдаад явахдаа “гайгүй ээ, чамайг гарч ирээд...” хэмээн заналхийлжээ. Суллагдаж гарах өдөр нь бяцхан хүү амиа хорложээ.

Энэ хүү өөрийг нь хамгаалах хууль батлагдаад жил гаруй болж байхад алтан амиа алдсан юм. Цагаан цаасан дээр хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалахын тулд хэн, юу хийхийг тов тодорхой заачихсан байхад харамсалтай нь тэдэнд энэ хуулийг хэрэглэх хүсэл зориг байгаагүй юм. Энэ бол гэр бүлийн хүчирхийллийн нэг л түүх. Хохирсон дээр улам нэрмэж хохироодог нь амьдрал дээр хэд хэдэн хүний амиар нэгэнт батлагдчихсан хуучин зохицуулалтыг хэрэглээд л нүдэн балай, чихэн дүлий орхиж байгаа баримт ганц энэ түүхээр хязгаарлагдахгүй.

Өдрөөс өдөрт гэр бүлийн гишүүд, ойр дотно хүмүүсийнхээ гарт амиа алдсан түгшүүрт мэдээ шил дараалан урссаар байвч төр, засаг цочроо авах хэмжээнд арай л хүрээгүй бололтой. Ахин хэдэн хүний амь, амьдрал, гашуун нулимсанд дэвтэж байж ухаарахыг хэн ч хэлж, таамаглаж чадахгүй нь харамсалтай.

Хэрэгжилт сул байгаагийн шалтгаан:

Хууль хэрэгжүүлэх талаар төрийн хүсэл зориг сул байгаа бөгөөд хуулиа батлаад л орхичихсон. Хуулийг хэлэлцэх явцад “хуульд энэ бүгдийг тусгах боломжгүй”, “цаг нь болоогүй” гэх мэт үндэслэлээр хуулийг хэрэгжүүлэх бүтэц, санхүүжилтийн асуудал болон олон чухал зохицуулалтууд хасагдсан. Энэ бүгдээс шалтгаалан хуулийн түүний хэрэгжилтийг хангах урьдчилсан нөхцөл бүрдэж чадаагүй байна.

Тухайлбал:

- хэрэгжүүлэх механизм байхгүй
- хуулийг дагалдан бусад хуульд орох өөрчлөлт батлагдаагүйн улмаас эрхзүйн цогц зохицуулалт болж чадаагүй
- хуулийг сурталчлах, таниулах ажил хийгдээгүй
- холбогдох мэргэжилтнүүдийг бэлтгээгүй /цагдаагийн ажилтан, шүүгч, нийгмийн ажилтан, орон нутгийн засаг захиргааны ажилтнууд/
- хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой тусгай бодлого, төлөвлөгөө байхгүй, хөрөнгө, нөөц нь төсөвт суугаагүй гэх мэт

Гэр бүлийн хүрээнд гарсан хэргийг зөвхөн Эрүүгийн болон Захиргааны хариуцлагын тухай хуулиар л хариуцлага хүлээлгэж байгаагаас биш Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэглэхгүй байна.


Хуулийг хэрэгжүүлэх хүчин чармайлт:

Хууль батлагдсан тэр агшин, тэр мөчөөс эхлэн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч болон түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг баталгаажуулах, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага хүлээлгэх, хүчирхийлэлтэй зан үйлээ өөрчлөхөд нь дэмжлэг үзүүлэх явдал **төрийн үүрэг хариуцлага болон хувирсан**. Гэсэн хэдий ч төр энэхүү үүргээ иргэний нийгмийн байгууллагуудад тохдог хандлага нь хэвээр байсаар байна. Энэ бүхнээс шалтгаалан тус хуулийг хэрэгжүүлэх ажлыг төр бус **иргэний нийгмийн байгууллагууд нуруундаа үүрсээр** байна гэхэд хийсдэхгүй.

2005.07.08-нд бид дээрх 10 настай хүүгийн түүхийг МУ-ын Ерөнхий сайдад хүргүүлээд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт удаашралтай, төрийн байгууллагуудын анхаарал, санаачилга, мэдлэг муу байгаад анхаарч ажиллах тухай хүсэлт тавьсан юм. Үүний үр дүнд:

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай Засгийн газрын Үндэсний хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг Ерөнхий сайдын захирамжаар 2005 оны 12 сард байгуулагдан ажиллаж байна.
2. Ерөнхий сайдын захирамжийн дагуу ХЗДХЯ-аас хуулийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх ажлыг эхэлсэн боловч одоог хүртэл эцсийн дүгнэлт гараагүй байна. Огт төлөвлөгөөгүй цаг зуурын шинжтэй ажилласан, ТББ-уудын санаачилга, хүч хөдөлмөрөөр хийгдсэн ажлуудыг өөрийн болгож тайлагнасан, цөөн хэдэн ажлын хүрээг хамарсан, үндэслэл муутай мэдээ, тайланд үндэслэсэн хяналт, шинжилгээний ажлын дүгнэлт нь **“хуулийн хэрэгжилт 50%-иас дээш үнэлгээтэй байна”** хэмээн гарах төлөвтэй байгаа сурагтай.

Хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгэх журам нь өөрөө бодит амьдралаас тасархай төдийгүй орон нутгаас ирж буй мэдээлэл нь ёс төдий, оромдох хандлагатай тул үүнийг **“Ёслолын ажиллагаа”** гэж нэрлэсэн ч



болохоор санагдаж байна. Учир нь аймаг, сум, орон нутгийн удирдлагуудаас хуулийн хэрэгжилтийн явцыг уг хуулийн зүйл заалт тус бүрээр нь “амжилттай” хэрэгжүүлж байгаа тухай тайлагнасан мэдээ ирүүлсэн байхыг бид олж хараад гайхсанаа нуух юун.

Дүгнэлт:

Хүчирхийлэлд өртсөн хохирогчийн амьд үлдэх-үхэх сонголт хүчирхийлэл үйлдэгчийн гарт байна. Харин хүчирхийлэл үйлдэгчийг шударга ёсны шүүхэд дуудах, хариуцлага тооцох эсэх нь төрийн хүсэл зоригоос хамаарна. Хэрэв засгийн газар энэ талаар шийдвэртэй арга хэмжээ аваагүй цагт хүчирхийлэл үйлдэгчийн хамсаатан болох нь. Учир нь Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай” конвенцид “Засгийн газар нь хүчирхийллийг арилгах талаар тууштай арга хэмжээ авахгүй тохиолдолд шууд бус ялгаварлан гадуурхалт бий болгож, хүчирхийллийг өөгшүүлэн дэмжиж байгаа гэсэн үг” хэмээн заасан. Иймээс хуулийг хэрэгжүүлэх төрийн хүсэл зориг бүхнээс илүү чухал байна.

Эцсийн дүндээ төр иргэнийхээ аюулгүй байдлыг хамгаална хэмээн биднээс татвар авдаг. Тэр татвараар нь иргэддээ үйлчилнэ хэмээн төрийн байгууллагын ажилтнууд цалинждаггүй гэж үг?

Хэрвээ бид хүчирхийллээс ангид хүний ертөнцийг байгуулж чадвал дэлхийн хүн амын тал хувийнх нь эсрэг үйлдэгдэж байгаа нийтийг хамарсан шийтгэгдээгүй гэмт хэргийг зогсоож чадлаа гэж бидний ирээдүй хэлэх болно.

НҮБ-ын Эмэгтэйчүүдийн хөгжлийн сангийн гүйцэтгэх захирал Ноелин Хейзер

Хуулийн цаасан дээр бус бодит амьдрал дээр амьдрах чадварыг бүрдүүлэхийн тулд юу хийвэл зохих вэ?

- Хууль баталсантай холбогдуулан бусад хууль тогтоомжид өөрчлөлт оруулах асуудлыг УИХ-ын энэ намрын чуулганы хэлэлцэх асуудалд багтаан шийдвэрлэх шаардлагатай.
- Хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор 24 цагийн дотор эрх хязгаарлах шийдвэрийг шүүхээс гаргах боломжийг бүрдүүлэхийн тулд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрт нь нэмэлт өөрчлөлт оруулах болон жижүүрийн шүүгчээр хангах арга хэмжээ авах хэрэгцээ гарч ирж байна.
- “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” бие даасан хуульд бүрэн агуулгаараа тусгагдаагүй болон огт тусгагдаж чадаагүй асуудлуудыг Засгийн Газраас батлагдан гарах “Үндэсний Хөтөлбөр”-өөр тодруулж өгөх шаардлагатай байна. Мөн салбар хоорондын уялдаа холбоог хангах нь чухал.
- Хөтөлбөр батлагдан гарч хэрэгжиж эхлэхийг хүлээхгүйгээр хуулийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг холбогдох яамдын зүгээс тодорхой төлөвлөгөө, төсөв бий болгон үндэсний хэмжээнд зохион байгуулах шаардлагатай.
- Хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацааны шүүхийн практикийг үндэсний хэмжээнд нэгтгэн хуулийн албан ёсны тайлбар болох УДШ-ийн тайлбарыг 2007 оны эхний улиралд багтаан гаргах хэрэгтэй байна.

ЯДУУРАЛ БА ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХҮНИЙ ЭРХ

*Т.Амгалан,
Зохистой Хөгжлийн Жендэр
Төвийн гүйцэтгэх захирал*

2005 оны байдлаар Монгол улсын нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ 514 ам.доллар байна¹. Энэ үзүүлэлтээрээ Монгол улс дэлхийд бага орлоготой гэсэн орнуудын ангилалд багтдаг.

Өнөөгийн байдлаар Монголд амьжиргааны түвшний доод шугамыг үндэслэн ядуурлын хамралтын хүрээг тодорхойлоход нийт хүн амын 36.1 хувь буюу 900.0 мянга орчим хүн ядуу байна.² Ядуурлын талаарх тоо баримтууд Монголын нийгэмд баян, хоосны зааг бий болж, тэдгээрийн хоорондох орлогын ялгаа улам гүнзгийрч, тэгш бус байдал даамжирч буйг харуулдаг.

1998 оны статистик мэдээнээс үзвэл, Улаанбаатар хотын нийт эмэгтэйчүүдэд ядуу эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин (44 хувь) нийт эрэгтэйчүүдэд эзлэх хувийн жингээс (21.0 хувь) хоёр дахин өндөр байж, сумын нийт эмэгтэйчүүдийн 52 хувь нь ядуу зүдүү байдалд аж төрж байжээ. Зах зээлийн эдийн засгийн шилжилтийн өрсөлдөөн дунд амьдрах нөхцөл боломж муутай, энгийн иргэд нийгмээс тусгаарлагдсан байдалд амьдарсаар байна. Тэд ядуу амьдрахаас гадна өвчинд нэрвэгдэж туйлын хүнд нөхцөлд амьдарч байгааг хэн хүнгүй мэдэж байгаа. 1998 оны тоо өнөөг хүртэл буурсангүй, харин ч ядуурал нь улам бүр гүнзгийрэх хандлагатай байна. *Ядуу өрхийн гишүүд урт удаан хугацаанд ядуу орчинд амьдарч байгаагаас өв залгамжилсан ядууралд хүргэж байна.*

Дэлхийн олон улс орнууд Мянганы хөгжлийн зорилтуудад хүрэхийн төлөө ажиллаж байна. 2000 онд улс орон, Засгийн газрын тэргүүнүүд “ядуурлыг түүх болгон үлдээх, жендэрээр ялгаварлан гадуурхахыг дуусгавар болгох” амлалт авсан билээ.

Өнөөгийн Засгийн газрын бодлогын чухал асуудал болох “ядуурлыг бууруулах төлөвлөгөө” нь улс орны хөгжлийн гол стратегийн баримт бичгүүдэд нэгдэн, “ажлын байрыг нэмэгдүүлэх” агуулгатай уялдуулан

¹ Дэлхийн банкнаас гаргасан мэдээлэл

² УСГ-ын Өрхийн орлого, зарлаг, амьжиргааны түвшний түүвэр судалгаа, 2002-2003 он. Энэ судалгаа нь олон нийтэд зарлагдсан ядуурал, өрх, иргэдийн амьжирганы талаар гарсан хамгийн шинэ мэдээлэл юм. 1998 онд хийгдсэн амьжиргааны түвшний судалгаагаар орлогын ядуурлын талаарх хамгийн сүүлийн үеийн албан ёсны тоо мэдээлэл байдаг. Уг судалгаагаар хүн амын 35.6 хувь нь ядуурлын шугамаас доогуур түвшинд амьдарч байсан.

хийгдсэн байдалтай байдаг. Гэвч дээрх амлалт, бодлогууд нь амьдрал дээр хэрэгжихгүй байгаагаас нийгмийн ихэнх бүлэг, олон тооны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд нэн ядуурч, амьдралын баталгаа алдагдаж, тэгш бус байдал газар авсаар байна³.

ЗОХИЦУУЛАЛТ АЛДАГДСАН БАЙДАЛ БА ЖЕНДЭРТ СУУРИЛСАН □ДУУРАЛ

Өнгөц харахад Монгол улсын жендэрийн асуудал нь гайгүй түвшинд байгаа мэт дүр зураг ажиглагддаг. Гэхдээ Монгол улсад өрнөсөн өөрчлөлт, шинэчлэлт нь монголын эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүдийн амьжиргаа, сайн сайхан амьдралд янз бүрээр нөлөөлж, ялгаатайгаар тусаж буйг сүүлийн жилүүдэд хийгдсэн жендэрийн дүн шинжилгээнүүдээс бодитойгоор харах боломжтой юм.

Шилжилтийн гэгдэх он жилүүдэд урьд өмнө баталгаатай байсан ажил үгүй болж, олон гэр бүл ядууралд нирвэгдсэн. Нийгмийн үйлчилгээ эрс хумигдаж ажилгүйдлийн үр нөлөөг сааруулах тогтолцоо бараг үгүй болсон. Хүүхдийн боловсрол, эрүүл мэнд зэрэг төрийн үйлчилгээ багассанаас эмэгтэйчүүд өрх гэр дотроо нэмэлт ачаалал үүрэх нь улам нэмэгдсэн. Шинээр бүрэлдэж буй хөдөлмөрийн зах зээл нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг эрэгтэйчүүдийнхтэй харьцуулахад илүүтэй хязгаарлаж, эмэгтэйчүүд орлого олох өөр арга замыг эрэлхийлэхдээ ихэвчлэн хөдөлмөрийн өртөгтэй нь харьцуулахад ашиг багатай салбарууд руу түлхүү орж эхэлсэн.

Нийгмийн амьдралд гарч буй эдийн засаг, оюун санааны ба сэтгэл зүйн гүнзгий өөрчлөлтүүд өрхийн түвшинд өвөрмөц байдлаар ажиглагдаж байна. Өрхийн бүтэц бүрэлдэхүүн, хэв маягт, өрхийн орлогын хэмжээ, эх үүсвэр, орлогын зарцуулалт, хуваарилалтанд өөрчлөлт гарч байна. Өрхийн гишүүдийн өөр хоорондын харилцааны зарчмууд, үйл хөдлөлийн сэдлүүд өөрчлөгдөн хувирч байна. Өрх, гэр бүлийн харилцаа уламжлалт хэв маягаас орчин үеийнхэд, өрхийн гишүүдийн амьдрал, өөр хоорондын харилцаа нь улам бүр өмчийн харилцаагаар тодорхойлогдох боллоо.

Үгээгүй ядуучууд улам олон болж монгол хүний сэтгэл зүйд гүн өөрчлөлт зөрчил үүсч, ялгаран хуваагдсаар байна. Нийгмийн эдгээр өөрчлөлт эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн амьдралд ямар нөлөө үзүүлсэнг харуулсан дэс дараатай судалгаа шинжилгээний ажил хомс хийгдэж байгаагийн зэрэгцээ эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн талаар нийгэмд тийм ч таатай биш хэм хэмжээ үлдсээр байна.

Шилжилтийн жилүүдэд хийгдсэн өмч хувьчлалтай зэрэгцэн өрх гэрийн түвшинд жендэрийн харилцаа илүү өргөн утга агуулгатай болж ирлээ.

³ НҮБЭХС, “Монголын эмэгтэйчүүд шилжилтийн үеийн дэвшлийг зураглахуй”, тайлан

Өрх гэр зөвхөн нийгмийн нэгж байхаа болж, уламжлалт нүүдлийн мал аж ахуйд байдаг шиг эдийн засгийн нэгж болов. Урьд нь өрхүүд газраа өмчлөх нь тийм ч чухал зүйл байгаагүй бөгөөд газар өмчлөх тухай шинэ хуулиуд гарснаар энэ нь чухал асуудлын нэг боллоо. Одоогийн хуулиар Монголд газрыг эзэмших нь өрхийн тэргүүн эрэгтэйчүүдийн эрх бөгөөд эмэгтэйчүүд зөвхөн эцгийн охин, эсвэл эхнэрийн хувьд газрыг эзэмших эрхтэй болж байна⁴.

Зах зээлийн харилцаанд шилжсэнээр өмчийн олон хэлбэр бүрдэж, хувийн өмчид тулгуурласан хөдөлмөрийн шинэ зах зээл-хувийн хэвшил үүссэн билээ. Гэвч эмэгтэйчүүдэд эмэгтэй хүнийх нь хувьд бизнес эрхлэхэд маш олон саад, бэрхшээл тулгарч байна. Энэ нь хувьчлал болон худалдааны либерлизацын үр дүнд бий болсон эдийн засгийн боломжийг тэгш ашиглах мэдээлэл, эрх зүй, менежментийн орчин боловсронгуй бус, ил тод бус, сонирхлын зөрчилдөөн, авилгал газар авсантай холбоотой.

Хувийн хэвшил дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэг талаас хөдөлмөрийн зах зээл нөгөө талаас өмч эзэмшилтэй холбон авч үзэх шаардлагатай болдог. Өнөөдөр Монголын эмэгтэйчүүд албан бус салбарт илүүтэй ажиллаж байна. Хөдөлмөрлөх энэхүү хэлбэр нь өөрөө өөртөө ажлын байр бий болгох, орлогын эх үүсвэрийг бүрдүүлдэг ба ихэнхдээ бүртгэлгүй, орлогын хэмжээ тогтмол бус, тогтвортой бус ажил байдаг. Албан бус хөдөлмөр эрхлэлт нь нэг талаас хөдөлмөрийн зах зээлээс шахагдсанаас нөгөө талаас орлогын ахиу эх үүсвэр хайсантай уялдан дэлгэрсэн билээ. Ийм л байдлаар эмэгтэйчүүд хувийн хэвшилд хөл тавьж, өмч эзэмшиж байна.

Бүтцийн өөрчлөлтийн олон хөтөлбөрийг дутуу дулимаг боловсруулан хангалтгүй хэрэгжүүлж ирсэн нь нийгмийн хөгжилд сөргөөр нөлөөлж, нийгмийн тэгш бус байдал ба ялгаварлалыг гүнзгийрүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Эдийн засгийн бодлого, төлөвлөлтөд жендэрийн нөхцөл байдлыг зохих ёсоор харгалзан үзэж чадаагүй, ядуурлын бүтцийн шалтгааныг судлан арилгах чадваргүй байгаа зэрэг нь ядуурлыг хөөрөгдөх хүчин зүйлийн нэг болж байна.

БОЛОВСРОЛГҮЙДЭЛ БА □ДУУРАЛ

Нийт ядуучуудын 90 орчим хувь нь боловсролгүй болон бага, дунд боловсролтой өрхөд амьдарч байна⁵. Ядуу гэр бүлд амьдарч буй эмэгтэйчүүдийн хувьд боловсролын түвшин доогуур, дээд боловсрол

⁴ Монгол улс 2002 оны байдлаар жендэрийн хөгжлийн индексээр дэлхийн улс орнуудын дотор 95 дугаарт байна. Энэ нь Монгол улс хүний хөгжил дэх жендэрийн ялгаатай байдлаар дэлхийд “дунд зэрэг” хөгжилтэй орны тоонд багтаж байна.

⁵ ҮСГ, ӨОЗАТС, 2002/2003

эзэмших, цааш тасралтгүй үргэлжлүүлэн суралцах боломж хомс байгаа нь Монголын дундаж давхаргын өнөөгийн эмэгтэйчүүдийн эрхэлж буй ажил ба боловсролын түвшингээс ялгаатай юм. Тиймээс ядуу, хүнд нөхцөлд амьдарч буй охид ба эмэгтэйчүүдийн боловсролын түвшинг дундаж давхаргын эмэгтэйчүүдийн боловсролын түвшинтэй адилтган авч үзэж болохгүй бөгөөд харин ч ядуу эмзэг бүлгийн охид эмэгтэйчүүдийн боловсролд анхаарал хандуулах нь зүйтэй болжээ.

Сүүлийн жилүүдэд боловсрол дахь жендэрийн ялгаатай байдлыг ихээхэн хөндөн ярих болсон. Энэхүү ялгаатай байдал нь нийгмийн аль давхарга, бүлгүүдийн хүрээлэлд бий болоод байгаад дүн шинжилгээ хийгээгүйгээс эмэгтэйчүүдийн боловсролын талаарх алдаатай ойлголт нийгэмд газар авч байна. Энэ нь эргээд ядууралд өртсөн эмэгтэйчүүдийн эрхийн асуудалтай шууд холбоотой.

Төрөлт ба □ДУУРАЛ

Эхчүүдийн хамгаалах тухай 1952 оны 103 дугаар Конвенцид Монгол улс 1969 онд нэгдэн орсон. Конвенцийн 3-6 дугаар зүйлд заасны дагуу жирэмсний болон амаржсаны амралт эдлэх, тэтгэвэр тэтгэмж авах, ажил завсарлах эрх эдлэх, жирэмсэн болон хүүхэд төрүүлсэн эхчүүдийг ажлаас халахыг хориглох тухай асуудлуудыг Монгол улсын холбогдох хуулиудад баталгаажуулан мөрдөж байна. Гэвч энэхүү хуулиудын заалт нь зөвхөн хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг эхчүүдэд хамаардаг. Өнөөгийн ажил олгогчид хуулийн цоорхойтой байдлыг ашиглан, ихэнх тохиолдолд ажиллагчидтайгаа хөдөлмөрийн гэрээ байгуулахгүй байгаа нөхцөлд төрөлтэй холбоотой эмэгтэйчүүдийн эрх зөрчигдсөөр байх болно.

Ядуу бөгөөд хүнд нөхцөлд амьдарч буй эхчүүдийн хувьд дээрх асуудал улам бүрхэг байна. Тэдэнд мэдээлэл байхгүй, ажил арай гэж олддог, дээр нь нэмээд ариун цэвэр, хувцас хунар муугаасаа зовон эрүүл мэндийн суурь үйлчилгээг ч авч чадахгүйд хүрч байна. Эндээс хамгийн харамсалтай нь ядуу эмэгтэйчүүд төрөлтийн улмаас эндэх, хүүхэд нь төрөлхийн сульдаатай гарах нь наад захын асуудал болж байгаад хэн ч анхаарал хандуулахгүй, ямар ч арга хэмжээ авахгүй зөвхөн л ярьж байгаа билээ.

Монголд 5 хүртэлх насны 3 хүүхэд тутмын 1 нь рахит өвчтэй, 42.2 хувь нь цус багадалт өвчтэй, жил бүр нэг мянга орчим хүүхэд тэжээлийн дутагдалд орж, 5 хүртэлх насны тэжээлийн дутагдалд орсон хүүхдүүдийн 48.2 хувь нь төрөхдөө бага жинтэй байгаа нь сэтгэл эмзэглүүлж байна⁶.

⁶ Имаока Риоко, Т.Буланзаяа “ Хүүхдийн өвчлөл, ядуурал, дотоодын шилжилт” судалгааны тайлан, 2006 он

Хэдийгээр төрөлтэй холбоотой үүсэж буй бүх зардлыг улсын төсвөөс гаргадаг гэх боловч байдал газар дээрээ өөр байгаа юм. Энэ талаар хүмүүс зөвхөн өөр хоорондоо ярьж, эрүүл мэндийн салбарын хувьд хаалттай асуудал байсаар байна. Төрж буй эхчүүдийн дийлэнх нь ядуу, хүнд нөхцөлд амьдарч буй эмэгтэйчүүд байгаа талаарх нийгмийн халамжийн талаарх шинэ хуулийг батлах үед ихээхэн яригдсан. Энэ нь хүртэл эмэгтэйчүүдийн эрхийг асуудлыг ихээхэн хөндөж буй асуудал юм.

ЯДУУРЛЫН ЭМЗЭГ БАЙДАЛ БА ШИЛЖИГЧ ЭМЭГТЭЙЧҮҮД

Ядуурлын эмзэг байдал нь өөрөө ядуурлын олон шинэ асуудлуудыг төрүүлж байна. Улам газар авч буй ядуурлаас зайлсхийх оролдлогын нэг нь л шилжих хөдөлгөөн болж байна. Жил ирэх тутам олон мянган эмэгтэйчүүд хөдөө, орон нутгаас төв суурин газар, төв суурин газраас гадаадад гарах урсгалын эргэлтэнд орсоор байна. Эмэгтэйчүүд тэдний гэр бүлийг шилжих хөдөлгөөнд хүчлэн оруулж буй гол хүчин зүйл нь төрөлх нутагт нь байгаа тэгш бус байдал, хязгаарлагдмал боломжууд юм. Тэд өөрийн амьдарч байсан “мэддэг” орчноосоо салж, олон хүнд бэрхийг нуруундаа үүрч, тэдний эрх зөрчигдөж байна.

Шилжигчдийн дундаас эмэгтэй шилжигчдийн хүний эрх хамгийн их зөрчигддөг гэж үздэг. Энэ нь нэг талаас шилжих хөдөлгөөнд оролцогчийнх нь хувьд, нөгөө талаас эмэгтэй хүнийхээ хувьд юм. Шилжигч эмэгтэйчүүд нь ажилгүйдэл, ялгаварлан гадуурхалд илүүтэй амархан өртдөг учраас тэдний олонх нь энэ үедээ ямар ч төрлийн ажил хийхээс өөр аргагүйд хүрдэг байна.

Шилжин ирэгчид ихэнхдээ хот, суурин газрын захад амьдардаг. Энэхүү “цөлөгдсөн” байдал нь тэднийг амьдралын наад захын мэдээлэл, үйлчилгээг хүлээн авах боломжийг нь давхар хязгаарласан байдалд оруулдаг байна.

... Байрнаасаа хөдөлсөн чулуу гурван жил зовдог гэж ярьдаг. Тэрэн шиг үнэн үг алга. Хотод орж ирээд амьдрал дээрдсэнгүй. Нөхөртэйгээ хоёулаа байнга ажил хайдаг. Олдохгүй байна. Хөдөө бол гаднаасаа түлээгээ авч түлчихээд, хэдэн малаа шувтраад ямар ч байсан өлсөхгүй болоод л байдаг. Хотод бол ямар ч арга алга.

(Риоко ИМАОКА, Т.Булганзаяа “Хүүхдийн өвчлөл, ядуурал, дотоодын шилжих хөдөлгөөн” судалгааны тайлан, 2005 он)

Хөдөө орон нутгаас шилжин ирэгсдийн байдлаас илүүтэй гадаад орон руу явж буй эмэгтэйчүүдийн асуудал мөн л хурцадмал байна.

Манай орны хувьд гадаад ажиллах, сурах зорилготой иргэдийн урсгал, хөдөлгөөн зонхилдог байна. 2005 оны байдлаар Гадаад хэргийн яамнаас мэдээлснээр 113 мянга гаруй иргэд гадаад орнуудад оршин сууж байна. Эдгээрээс 2006 оны байдлаар 13 мянга гаруй иргэд хөдөлмөрийн гэрээгээр болон үйлдвэрлэлийн дадлагажигчаар албан ёсны зөвшөөрөлтэйгөөр ажиллаж, 700 гаруй оюутан засгийн газар хоорондын болон хувийн зардлаар суралцаж байна. **30 гаруй мянган иргэд гадаад орнуудад хараар ажиллаж, амьдарч байна. Үүний дийлэнх нь эмэгтэйчүүд байна.**

Тэд тухайн улсдаа хүнд нөхцөлд ажиллахаас гадна хүнийг хил дамнан худалдаалах орчин цагийн боолчлолоос өгсүүлээд гэрийн үйлчлэгчийн хөдөлмөрийн мөлжлөгт хүртэл өртөж, олон эмэгтэйчүүд аюул, занал, айдас хүйдэстэй тулгарч байгаа нь шилжих хөдөлгөөнд тэд хуулийн дагуу, аюулгүй оролцох боломж бага байгааг нотлон харуулж байна.

Ядуурлын эмзэг байдал нь эмэгтэйчүүдийн хүний эрхийн нэг томоохон зөрчил болох хууль бус гэрлэлтийн асуудлыг сэргээж байна. Манай улсын хувьд энэ нь 1921 оны ардын хувьсгалтай хамт устсан гэж үзэж ирсэн. Харин өнөөдөр эмэгтэйчүүдийн өмнө “хил дамнасан гэр бүл”-ийн асуудал гарч ирж байна. Энэ нь ядуурлаас үүдсэн амьдралаасаа гарах гэсэн олон, олон хариу үйлдлийн нэг юм. Монгол залуу охид, ирээдүйн нөхөр болох хүнээ нэг ч харалгүйгээр гэрлэж, гадаад оронд боол мэтээр хууртагдан амьдарч байна.

Шилжин ирэгч насанд хүрээгүй олон хүүхэдтэй, аль эсвэл эмэгтэйчүүд тэргүүлсэн өрх гэр бүлийн дунд ядуу, нэн ядуу байдал давамгайлж байна. Бүх өрхийн бараг тавны нэг нь эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байна⁷. Энэ тоо жил ирэх тутам нэмэгдэж байна. Эмэгтэй өрхийн тэргүүлэгчид нь насны хувьд ихэнхдээ ахимаг настай, олон хүүхэдтэй эмэгтэйчүүд байна. (44.2 хувь нь 50 ба түүнээс дээш насных, 6-гаас дээш хүүхэдтэй)

Хөдөлмөрийн бүтээмж, ажлын чанар, ажлын хөлсний хооронд жинхэнэ зах зээлийн эдийн засгийн хууль үйлчилж чадахгүй байгаа өнөөгийн нөхцөл нэн ядуу, аль эсвэл эмэгтэй тэргүүнтэй, олон хүүхэдтэй гэр бүл, өрхүүдийн гишүүд, тэр дундаа эмэгтэй гишүүдийг нь эрсдэлтэй алхам хийлгэхэд хүргэж байна.

⁷ УСГ, Монгол дахь хүйсийн ялгаатай байдал, 2000 оны тооллого дээр үндэслэсэн судалгаа, 2002 он

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ҮЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ: ХөДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ГАЖУУДАЛ

*С.Түмэндэлгэр,
МУБИС-ийн Нийгмийн ухааны
тэнхмийн багш, докторант*

Нийгэм дэх жендэрийн харилцааны мөн чанарыг тайлбарлахад феминист онолуудын нэг болох Эцгийн эрхэт ёсны онол чухал үүрэгтэй. Ихэнх эрчүүдийн дунд “Бид байгалиасаа эмэгтэйчүүдээс илүү, өөрсдийн амьдралаа авч явах чадвар бидэнд илүү бий” гэдэгт хатуу итгэсэн, эмэгтэйчүүд ч энэ баримтлалд эвлэрэнгүй хандах нь эцгийн эрхэт ёсны онолын үзэл санааны гол цөм нь болдог.

Өөрчлөгдсөн өнөөгийн орчин үеийн нийгмийн нөхцөлд дээрх онолын төлөөлөгч болох С.Волби патриархаль харилцаа дараах 6 бүтцэд хадгалагдаж байна гэж өөрийн судалгаагаар нотлохыг зорьсон юм (Walby, S. 1986). Үүнд:

1. Үйлдвэрлэлийн тогтолцоо патриархаль загвартай байна.
2. Цалинтай хөдөлмөр дэх патриархаль харилцаа
3. Төр дэх патриархаль харилцаа
4. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл
5. Бэлгийн харилцааны баримтлал дахь патриархаль харилцаа
6. Соёлын институт дэх патриархаль харилцаа

Цалинтай хөдөлмөрт эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин бага, авч буй цалингийн хэмжээ бага, бүтэн цагийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин доогуур байгааг илтгэх эмпирик баримтууд нь патриархаль бүтэц оршин байгаа гол нотолгоо болдог байна. Иймээс нийгэмд эмэгтэйчүүдийн эрхийг зөрчсөн ялгаварлан гадуурхах харилцаа, хандлага байгаа эсэхийг тодорхойлоход хөдөлмөр эрхлэлт дэх жендэрийн ялгааг авч үзэх нь ихээхэн ач холбогдолтой юм. Уг асуудлыг эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо, хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн ялгарал, гадаадад хөдөлмөр эрхлэлтийн байдал ба эмэгтэйчүүд, ажлын байран дахь бэлгийн дарамт, цаашид яах вэ гэсэн сэдвүүдийн хүрээнд авч үзэхийг зорилоо.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ БАЙДАЛ.

Бүрэн ажил эрхлэлтийг дэмжиж байсан төрийн бодлого тасарснаар 1980-ад оны сүүл 1990-эд оны эхэн үеэс эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин, ажил эрхлэлтийн түвшин буурч ажилгүйдлийн түвшин өссөн билээ. Үүнд үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудын дампуурал, өмч хувьчлал, нийгмийн халамжийн бодлогын өөрчлөлт нэлээд хэмжээгээр нөлөөлсөн билээ. Харин 1990-эд оны дунд үеэс нийт хүн амын ажил эрхлэлтийн байдал нэмэгдэж, түүн дотроо эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн түвшин ч ахисан. Энэ нь эмэгтэйчүүдийн гэгдэх салбарууд дахь хөрөнгө оруулалт нэмэгдэж ажлын байр өссөнөөр тайлбарлагдана (Түмэндэлгэр С. 2005). Гэвч ажиллах хүчний оролцооны түвшний хувьд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс доогуур, ажилгүйдлийн түвшингээрээ өндөр байх явдал хэвээр байна. Ажиллах хүчний түүвэр судалгаагаар (ҮСГ, 2004:33) ажиллах хүчний 52.1 нь эрэгтэйчүүд, 47.9 хувь нь эмэгтэйчүүд байна. Эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 69.7 байхад эмэгтэйчүүдийнх 61.1 байна. Эдийн засгийн идэвхгүй хүн амын дунд эмэгтэйчүүд өндөр байгаа нь тэтгэврийн насны эмэгтэйчүүд их байдаг, тэд илүү урт хугацаагаар суралцдаг, нөхөн үржихүйн үүрэгтэй холбоотой аж. Харин 35-39 насны эмэгтэйчүүдийн ажиллах оролцооны түвшин бусад насныхнаас хамгийн өндөр байгаа нь тэд залуу насандаа илүүтэй суралцдаг, хүүхэд төрүүлж, асардагтай нь холбоотой хэмээн тайлбарласан байдаг (ҮСГ, 2004:36). Гэвч 30-аас дээш насны эмэгтэйчүүд, царай зүс, бие бялдрын тодорхой шаардлагыг биелүүлж чадахгүй эмэгтэйчүүдийн хувьд ажилд орох, ажлаа солих боломжийг хязгаарлаж байгаа нь нэлээд тооны судалгаануудаас харагдаж байна (ДБ, АХБ, 2004). Харин тэдний хувьд ажил хөдөлмөр эрхлэх арга замаа өөрсдөө тодорхойлж харьцангуй нээлттэй, уян хатан шинжтэй албан бус секторыг сонгож байна. 2004 оны судалгаагаар албан бус секторт ажиллагсдын 54 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байна /МУЗГ, НҮБХХ: 42/. Албан бус салбар нь орлогын хувьд харьцангуй өндөр, нийгмийн хамгаалалд сайн дураар хамрагдах зэрэг эрх чөлөөг эзлэх боломжтой ч ирээдүй дэх болзошгүй эрсдэл, хөдөлмөр хамгааллын стандартыг үл биелүүлэх нөхцөлд ажиллах нь хөдөлмөрийн таатай төрөл биш болохыг харуулах юм. Гэхдээ аль ч салбарт эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэхэд хамгийн ихээр саад болж буй зүйл бол хүүхэд асаргааны байгууллагуудын дутагдал юм. Ер нь эмэгтэйчүүдийн эдийн засгийн идэвхгүй байгаа нь суралцах болон нөхөн үржихүйн үүрэг хариуцлагаас нь шалтгаалж байна. Судалгаанаас /ҮСГ, 2004: 34/ 7 хоногт эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхлэхэд эрэгтэйчүүд 17,5 цаг, эмэгтэйчүүд 31,8 цаг зарцуулдаг нь тогтоогдсон бөгөөд энэ нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс бараг 2 дахин илүү гэрийн хөдөлмөрийн ачаалалтай болохыг харуулж байна.

Мөн тэтгэвэр тэтгэмж авагсдын дийлэнх хувь эмэгтэйчүүд зонхилдог нь нэг талаас эмэгтэйчүүдийн наслалт эрэгтэйчүүдийнхээс өндөр байгаатай холбогдож байгаа ч, 1990-ээд оны эхэн үед явагдсан тэтгэврийн шинэ бодлогын нөлөөгөөр тэтгэврийн насанд хүрээгүй ч, олон жил ажилласан, олон хүүхэд гаргасан гэх шалтгаанаар тэтгэвэрт хувь тэнцүүлсэн гэгчид хамрагдсан хүмүүсийн дийлэнх нь эмэгтэйчүүд байсантай холбогдож байгаа юм. Ер нь тэтгэвэрт гарах нас эрэгтэйчүүдийнхээс 5-10 жилээр богино байгаатай холбоотойгоор эдийн засгийн идэвхгүйг хүн амын дунд эмэгтэйчүүдийн хувийн жин өндөр байна.

Эмэгтэйчүүд илүү ажилгүйдэлд өртөж байгаа нь эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдийнхээс өндөр байгаагаар нотлогдоно¹. Ингэхээр эмэгтэйчүүд эдийн засгийн идэвхтэй байлаа ч ажилгүйдэлд илүү өртөмхий байна гэсэн үг. Ажилгүйдэлд боловсрол өндөртэй хүмүүс өртөх нь илүү, түүн дотроо боловсрол өндөртэй эмэгтэйчүүд өртөмхий байгааг сүүлийн үеийн судалгаанууд (УСГ, 2004) харуулж байгаа нь боловсролын түвшин тэдгээрийн хөдөлмөр эрхлэлтэд сайнаар нөлөөлөхгүй байгаа, нийгмээс эмэгтэйчүүдийн өндөр боловсролыг үнэлэхгүй байгааг илтгэх болов уу.

Түүнчлэн хөлстэй хөдөлмөр дэх эмэгтэйчүүдийн оролцооны түвшин бусад азийн орнуудтай харьцуулбал харьцангуй өндөр ч эмэгтэйчүүд хөлстэй хөдөлмөрийн ачаалал ихтэй хэвээр байгаагаараа онцлог (Түмэндэлгэр С, 2005). Төрсний өмнөх болон дараах цалинтай хугацаа хэт богино, асаргааны тэтгэмж хэт бага байдаг нь хүүхэд төрүүлэх, хүүхэд асрах хөдөлмөрийг үнэгүйд тооцсон хэвээр байгааг нотлохын зэрэгцээ ажилдаа түргэн эргэж ороход хүргэж, давхар ачаалал бүхий эмэгтэйчүүдийг бий болгож байна. Хэдийгээр хөдөлмөрийн гэрээнд ил тодоор тусгадаггүй ч, жирэмслэхгүй, хүүхэд төрүүлбэл ажлаас чөлөөлөгдөнө гэсэн ажил олгогчийн зүгээс тавьдаг шаардлагууд нь эмэгтэйчүүдийг нөхөн үржихүйн эрхээ эдлэх боломжийг нь хааж, нөхөн үржихүйн үүргээр нь ягаварлаж “эрэгтэй” ажилтны адилаар байхыг шаардаж байна. Энэ нь эмэгтэйчүүдэд эрэгтэйших эсвэл гэрийн эзэгтэй байх гэсэн 2 сонголтыг тулгаж байгааг илтгэх бөгөөд боловсролын түвшин өндөртэй эмэгтэйчүүдтэй монголчуудын хувьд 1 дэх хувилбарыг түлхүү сонгосноор хүн амын өсөлтийг сааруулахад хүргэж байна гэж үзэж болох юм.

ХөДөЛМөРийН ЗаХ ЗЭЭЛ ДЭХ ЖЕНДЭРийН □ЛГАРАЛ

Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн эрхэлж буй ажлын төрлийн ялгааг судлах нь хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн харилцааны мөн чанарыг тодорхойлоход чухал үүрэгтэй. Ажиллагсдын эрхэлдэг ажил хүйсээр хэр

¹ УСГ-ын 2005 оны мэдээгээр эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 3,6 байхад эрэгтэйчүүдийнх 3,0 байна.

ялгагдаж байгааг авч үзэхэд 2000 оны хүн амын тооллогоос (ҮСГ, 2001) хууль тогтоогч төрийн болон төрийн бус байгууллагын албан тушаал, менежерийн албан тушаалын ажил эрхэлдэг хүмүүсийн 70 хувь нь зөвхөн эрэгтэйчүүд байна. 2002 онд хийгдсэн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн ажилтнуудын түүвэр судалгаанаас нийт удирдах албан тушаалтнуудын 63.9 хувь нь эрэгтэйчүүд байна (ҮСГ, 2002). Эдгээр ажлууд нь эрх, цалин хөлс, хангамжийн хувьд харьцангуй өндөр. Гэтэл эрх мэдэл, цалин хөлс, хангамжийн хувьд харьцангуй доогуур ажлууд болох гүйцэтгэх ажилтнуудын 60.9 хувь, туслах ажилтан нарын 53.8 хувь, үйлчилгээний ажилтнуудын 54.6 хувь нь эмэгтэйчүүд байна. Эндээс эрх мэдэл, цалин хөлс, хангамж нь жендэрийн хувьд ялгаатайгаар хуваарилагдаж байгаа нь харагдаж байна. Дээд боловсролтой хүмүүсийн 70 орчим хувь нь эмэгтэйчүүд байгаа атлаа албан тушаалын зэрэглэл ахих тусам эмэгтэйчүүдийн хувийн жин буурч байгаа нь хүний капиталын хүчин зүйлсээс хамаараагүй хуваарилалт хийгдэж байна гэж үзэж болохуйц байна.

Дээрх ажлын төрлүүд нь цалин хөлсний хувьд харилцан адилгүй байна. 2004 оны эхний улирлын байдлаар удирдах ажилтнуудын дундаж цалин 128 мянга байхад гүйцэтгэх ажилтнуудынх 93.9, туслах ажилтнуудынх 74.7, үйлчилгээний ажилтнуудын цалин 70.9 мянга байна.

Уул уурхай, эрчим хүч, дэд бүтцийн барилга байгууламж зэрэг эдийн засгийн хурдацтай өсөлттэй салбаруудад эрэгтэйчүүд зонхилон ажиллаж байхад худалдаа үйлчилгээ, нийгмийн үйлчилгээ зэрэг эдийн засгийн өсөлтийн хувьд зогсонги шинжтэй салбаруудад эмэгтэйчүүд зонхилон ажилладаг. Эрэгтэйчүүдийн гэгдэх уул уурхай, олборлох аж үйлдвэрийн дундаж цалин 2002 оны 4-р улирлын байдлаар 81.4 мянга, барилгын үйлдвэрийнх 103.0 мянган төгрөгийн цалинтай байхад эмэгтэйчүүдийн гэгдэх бөөний болон жижиглэнгийн худалдаа -59.2 мянга, боловсрол -69.3, эрүүл мэндийн салбарын дундаж цалин -53.9 мянган төгрөг байжээ. Мөн түүнчлэн 2004 оны эхний улирлын байдлаар эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн цалингийн зөрөө 12300 төгрөг байжээ. /ҮСГ, 2004/.

Эндээс дүгнэн хэлэхэд албан тушаалын зэрэглэлийн хувьд дунд болон дундаас доогуур түвшний, эдийн засгийн өсөлтийн хувьд зогсонги салбаруудад эмэгтэйчүүд илүүтэй төвлөрсөн, цалин хөлсний хувьд хамгийн наад тал 12.3 мянган төгрөгөөс доогуур цалин хөлстэй ажлуудыг эмэгтэйчүүд эрхэлж байна гэж үзэх бүрэн үндэслэл байна.

ГАДААДАД ХөДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ БА ЭМЭГТЭЙЧҮҮД

Нийгмийн хамгаалал, Хөдөлмөрийн яамны мэдээлснээр 2006 оны байдлаар 13000 гаруй иргэд хөдөлмөрийн гэрээгээр болон үйлдвэрлэлийн дадлагажигчаар, 30 гаруй мянган иргэд гадаад орнуудад хараар ажиллаж

амьдарч байгаа аж. 2006 оны эхний хагас жилийн байдлаар 59.4 сая ам.долларыг эх орон луугаа гуйвуулжээ. Энэ талаар хүйсээр ялгасан мэдээлэл хангалттай олдсонгүй. Гэвч НҮБХАС-ийн захиалгаар ХАССТ-өөс явуулсан судалгаанаас үзэхэд гадаадад ажиллаж буй эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 1.3-2 дахин бага цалин хөлс авдаг байна. Гадаадад ажиллаж буй хүмүүс нь ар гэрийнхнийхээ амьдралын нөхцөлийг сайжруулах зэрэг эерэг нөлөөтэй хэдий ч хүний эрхийг зохих ёсоор хамгаалсан тогтолцоо, хууль ёсоор аюул осолгүй гадаад орнууд руу шилжих боломж байхгүй байгаа нь хил дамнуулан худалдаалагдахад хүргэж болзошгүй байна. Түүнчлэн гэр бүлийн гишүүд хосоороо гадаадад хөдөлмөрлөж чадахгүй байгаа нь гэр бүл салалтад хүргэж, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тооны өсөлтөд нөлөөлж байна.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН АЖЛЫН БАЙРАН ДАХЬ БЭЛГИЙН ДАРАМТ

Эмэгтэйчүүдийн эрхэд ноцтойгоор халдаж ялгаварлан гадуурхаж байгаагийн хамгийн тод илрэлийн нэг бол ажлын байран дахь бэлгийн дарамтлал билээ. Гэтэл нэр төрийг нь гутаах, эмэгтэйчүүдийг л буруутгадаг нийгмийн хандлага, ажлын байр, амьжиргааны эх үүсвэрээ алдахаас айх зэргээс болоод ихэвчлэн далд нууц байдлаар явагддаг аж. Мөн түүнчлэн эрчүүдийн зүгээс гаргаж буй янз бүрийн сексийн дарамтлалын шинжтэй үйлдлүүдийг байж болох, хэвийн зүйл гэж үздэг нийгмийн хандлага, ойлголт оршин байгаа нь энэ үзэгдэлд таатай нөхцөлийг бүрдүүлж байна. Эдгээр нийгмийн хандлага, дүрэм журам нь эцгийн эрхэт ёсны эр хүнийг дээдэлсэн, эмэгтэй хүнийг бэлгийн харилцааны объект гэж үздэг, эр хүний ямар ч үйлдлийг зөвтгөдөг нийгмийн соёлоор тодорхойлогдож байгаа юм. Хүчирхийллийн эсрэг төв зэрэг байгууллагуудын хийсэн судалгаанаас судалгаанд хамрагдагсдын олонх нь бэлгийн дарамтыг гэмт үйлдэл, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхаж буй үйлдэл гэж хүлээн зөвшөөрсөн боловч “амьдралд байдаг хэвийн зүйл”, “2 хүний хувийн асуудал” гэж үзэх хандлага өндөр байгааг тогтоожээ. Түүнчлэн энэ үйлдэлд эмэгтэйчүүдийг буруутгах, эмэгтэйчүүдийн хувцаслалт, биеэ авч явж байдал, яриа хөөрөө зэргээр нь буруутгах, эрэгтэй эмэгтэй хүмүүс цуг ажиллаж байгаа тохиолдолд зайлшгүй гарах зүйл гэж судалгаанд хамрагдагсдын нэлээдгүй нь үзэж байсан ба ер нь энэ талын мэдлэг ойлголт тааруу байгаа нь судалгаанаас харагджээ (ХЭҮТ бусад, 2002:38-39).

ЦААШИД □ АХ ВЭ?

1. Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшинг нэмэгдүүлэхийн тулд хүүхэд асаргааны байгууллагуудын тоог нэмэгдүүлэх, үйлчилгээний төрөл, чанарыг сайжруулахад анхаарах,

2. Дээд боловсролтой эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээл дэх өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, давхар мэргэжил-мэргэшил эзэмшүүлэхэд анхаарч бэлтгэх,

3. Хуулиар тогтоосон Эмэгтэйчүүдийн тэтгэврийн насыг эргэн харах,

4. Ажилд авах, ажлаа солиход нас, гадаад байдал, хүйсээр ялгаварлан гадуурхах, эмэгтэйчүүдийг нөхөн үржихүйн үүргээсээ татгалзахыг шаардах явдлыг таслан зогсоох талаар анхаарч, ялангуяа хяналтын тогтолцоог боловсронгуй болгох,

5. Эхчүүдийн /эцэгт мөн адил хамаатай/ хүүхэд төрүүлсний дараах цалинтай хугацааг сунгах /одоо зөвхөн 2 сар цалингаа авдаг/, хүүхэд асаргааны тэтгэмжийг өсгөх, хүүхэд асрах үед байгууллагаас нийгмийн даатгалыг төлдөг хугацааг нэмэгдүүлэх зэргээр холбогдох нийгмийн халамжийн бодлогыг эргэн харах.

6. Ээж-эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс цагийн хөдөлмөрийн ажлын байрыг нэмэгдүүлэх, нэг ажлын байранд хувааж ажиллах, гэрээр ажиллах г.м хэлбэрүүдийг нэвтрүүлэх,

7. Эмэгтэйчүүдийг эдийн засгийн өндөр хурдацтай салбаруудад ажиллах боломжийг нэмэгдүүлэх үүднээс энэ чиглэлээр мэргэжил эзэмших, төгсөөд ажиллах боломжийг нэмэгдүүлэх, давхар мэргэжил эзэмших боломжийг нээх,

8. Эмэгтэйчүүдийн гэгдэх салбарууд дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, дундаж цалинг нэмэгдүүлэх,

9. Гадаадад аюул осолгүйгээр гарч хууль ёсоор ажиллах амьдрах хууль эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, хил дамнуулах худалдаалагдах эрсдэлийг бууруулах, мэдээлэл сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх,

10. Ажлын байран дахь бэлгийн дарамтлалын эсрэг хууль эрх зүйн зохицуулалтыг бий болгох. Олон нийтийн ойлголт хандлагыг өөрчлөхөд чиглэсэн арга хэмжээнүүдийг эрчимжүүлэх,

11. Эмэгтэйчүүдийн ялгаварлан гадуурхах явдлыг устгах талаар боловсролын салбартай хамтран ажиллаж, боловсролын хөтөлбөрийг жендэрийн мэдрэмжтэй болгоход анхаарах.

12. Хүйсээр ялгасан статистик мэдээллийг бүрдүүлэхэд анхаарах.

13. Хөдөлмөр эрхлэлт дэх Жендэрийн тэгш байдлыг тогтоохын тулд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан бүхий л хэлбэрүүдийг халахад чиглэн бие даасан хуулийг санаачлан, батлуулах.

Ном зүй:

1. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Л.Одончимэдийн хэлсэн үг (2006) *Дэлхийн хүн амын байдал-2006 илтгэлийн танилцуулах семинар*
2. НҮБЭС, ХЭХТ, ХЭҮТ, ЭЯГБХУТКХХ Үндэсний сүлжээний төв (2002) Монгол улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба хууль эрх зүйн орчин. УБ.,
3. НҮБХАС-ийн суурин төлөөлөгч Д.Барселонагийн хэлсэн үг (2006) *Дэлхийн хүн амын байдал-2006 илтгэлийн танилцуулах семинар*
4. С.Түмэндэлгэр (2005) *Монгол дахь хөдөлмөрийн зах зээл ба жендэр* Шинэ толь сэтгүүл 51. УБ.,
5. ҮСГ. (2001) Хүн ам, орон сууцны 2000 оны тооллого: Үндсэн үр дүн. УБ.,
6. ҮСГ. (2000, 2001, 2002, 2004) Байгууллага аж ахуйн нэгжүүдийн ажилтнуудын түүвэр судалгаа, (хэвлэгдээгүй)
7. ҮСГ (2004) Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан. УБ.,
8. Walby, S. (1986), *Patriarchy at Work*, (Polity).

АЖЛЫН БАЙРАН ДАХЬ БЭЛГИЙН ДАРАМТЛАЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН ШААРДЛАГАТАЙ БАЙНА

*Н.Чинчулуун,
Монголын Эмэгтэйчүүдийн
сангийн захирал, хуульч*

Бэлгийн дарамтлал нь ажлын байр, олон нийтийн газар бусдыг хүсээгүй байхад бэлгийн сэдэлтэйгээр хэл амаар доромжлон тохуурхахаас эхлээд шахалт дарамт үзүүлэх замаар бэлгийн харьцаанд оруулах хүртэл үйлдэгддэг гэмт хэрэг юм.

Ажлын байран дахь бэлгийн дарамтлал (sexual harassment)-д өртөж хохирсон хохирогчид нь сэтгэл зүйн болон бие махбодийн хүнд дарамтанд ордог. Хохирогчид нэр хүнд үнэлэмжээ алдахаас сэргийлж уг асуудлыг гаргаж тавихаас эмээдэг бөгөөд бэлгийн дарамтлалд өртөж хохирсон хохирогчийн эрхийг сэргээх үр дүнтэй механизм бүрэлдэж тогтоогүй нийгэмд энэ нь далд, нуугдмал байдаг хүний эрхийн ноцтой зөрчлийн нэг юм.

2003 онд ХЭҮК-оос хийсэн судалгаагаар хөдөлмөр эрхэлж байгаа 2 эмэгтэй тутмын нэг нь ажлын байран дахь бэлгийн дарамтлал (АББД)-д өртдөг гэжээ. Хохирогчдын ихэнх нь эмэгтэйчүүд, охид байдаг хэдий ч эрчүүд ч бас үүнд тодорхой хэмжээгээр өртдөг.

Хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарч байгаа бэлгийн дарамт байнга давтагдаж улам бүр хурцдаж, лавширч байдгаас хохирогчийн өөрийгөө үнэлэх үнэлэмж болоод бусад хүмүүсийн зүгээс тухайн хүнд хандах хандлагад сөргөөр нөлөөлж улмаар хохирогчийн хөдөлмөрийн бүтээмжийг бууруулаад зогсохгүй ажлаа орхих, үндэслэлгүйгээр халагдах, эсвэл тухайн саналыг хүлээн авахаас өөр аргагүй байдалд хүрэх зэргээр үүдэн гарч буй үр дагаврууд нь маш ноцтой байдаг.

Иймд АББД-ын илрэх хэлбэрийг дараах байдлаар та бүхэнд танилцуулахыг хүсэж байна.

- 1. Аман** хэлбэрээр үйлдэгддэг. Жишээ нь: “тэрний хөх нь тийм, энэний өгзөг нь тийм, тэр лав бэлгийн ажилдаа тийм байгаа”, “Чи миний хэлснээр бэлгийн таашаал үзүүлэхгүй бол би чамайг ажлаас хална, цалинг чинь хасна эсвэл өгөхгүй” гэх мэтээр заналхийлэх, айлгах, сүрдүүлэх нь аман хэлбэрийн бэлгийн дарамтлал болно.

Мөн ажил олгогч нь ажилтныхаа бие галбирыг ил гаргаж үзүүлэхийг шаардах, биеийг нь шинжих, илт садар самуунд уруу татсан зурагт хуудас үзүүлэх, дур хүслийг нь өдөөх дуу хэллэг ашиглах, шөнийн цэнгээний газар

явах, бэлгийн харьцаанд орохыг шахаж шаардах нь уриалах дарамт буюу аман хэлбэрийн дарамтанд орно.

Австралийн Хүйсээр ялгаварлан гадуурхахын эсрэг Хуульд:

“ажлын байранд бэлгийн шинжтэй хүлээж авашгүй зан авирыг амаар болон бичгээр гаргахыг АББД гэж хэлнэ” гэж хуульчилжээ.

2. Үйл хөдлөл, бие махбодийн хэлбэрээр үйлдэгддэг дарамт бий.

Өлөн нүдээр ширтэх, бэлгийн шинжтэй дохио зангаа өгөх, биеийн эмзэг хэсгүүдэд хүрэх, базах, үнсэх, тэврэх, биеэр довтлох, хувцас эд зүйлсийг үрж гэмтээх, хүчиндэх нь энэ төрлийн хүчирхийлэлд орно. Хүчээр бэлгийн харьцаанд оруулснаас үүдэж эмэгтэй жирэмслэх тохиолдол их байдаг.

ОХУ-ын Эрүүгийн хуульд: Бэлгийн шинжтэй үйлдлүүдэд хохирогчийг айлган сүрдүүлэх, албадан тулгах, эд зүйлийг гэмтээх, сүрдүүлбэл гэмт хэрэг үйлдсэнд тооцож хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 200-300 дахин нэмэгдүүлж торгох, түүнтэй тэнцэх хэмжээний хөдөлмөр хийлгэх, эсвэл 2 жил ЗХА хийлгэнэ гэж заасан байна.

Мөн зайлшгүй хамаарах дараах 2 асуудал байна.

1. Бэлгийн дарамтлал “үйдэгчид” гэж хэн бэ? Энэ нь ажил олгогчид, менежер, инженер техникийн ажилтнууд, дунд тушаалын албаны дарга нар, багш, дасгалжуулагчид гээд ер нь эрх мэдэл, нөлөө бүхий хүмүүс байж болзошгүй байдаг.
2. “Ажлын байр” гэж зөвхөн хөдөлмөр эрхэлдэг орон зайн тухай биш, ажлын байранд хамаарах орчин, хүмүүсийн харилцааг авч үздэг. Боловсрол, мэргэжил олгох салбар, бараагаар хангах үйлчилгээ үзүүлэх газар, олон нийтийн газар, нийтийн тээвэр, барилга байгууламж, орон байр, орон сууц, тариалангийн талбай, малын бэлчээрийн газар ч хамаарахаар заасан байдгийг олон орны эрх зүйн баримт бичгүүдээс харж болно.

Улс орнуудад АББД-ыг янз бүрийн механизмаар зохицуулдаг ч эцсийн шийдвэр нь адилхан байдаг. Жишээ нь:

1. Хохирогчийн гомдлыг хүлээн авах, шалгах, хариуцлага тооцох асуудлыг Австрали, Канад улсуудад Хүний эрхийн Комисс, АНУ-д Хөдөлмөрийн тэгш бололцооны комисс шийдвэрлэдэг байна.

Ихэнх тохиолдолд эвлэрүүлэх арга хэмжээ авдаг. Үүний үр дүнд уучлалт гуйлгах, материаллаг хохирол төлүүлэх, ажилд нь эргүүлэн тогтоох, шилжүүлэх, байгууллагын дотоод дүрэм журманд өөрчлөлт оруулах, амлалт авахуулах, сургалтанд хамруулах зэрэг арга хэмжээ авдаг.

2. ӨАБНУ болон Малайзад “АББД-ын эсрэг дагаж мөрдөх ёс зүйн журам” (Меморандум) хэлбэрээр шийдвэрлэдэг бол ихэнх нь Хүний эрхийн хуулиар зохицуулдаг. Сүүлийн жилүүдэд улс орнуудад (Филлиппин, Малайз гэх мэт) бие даасан хууль гаргаж байгаа бөгөөд энэ нь ихээхэн үр дүнтэй байна гэж судлаачид үзэж байна.

Манай улсын хувьд энэ зөрчлийг таслан зогсоох эрх зүйн зохицуулалт боловсронгуй биш, уг зөрчлийг үр дүнтэйгээр шийдвэрлэх практик тогтоогүй, энэ асуудлаарх олон нийтийн мэдлэг боловсрол хангалтгүй байдаг зэрэг бусад олон сөрөг хүчин зүйлүүд байсаар байна.

Манай улсын тухайд АББД-ын хэлбэрийг тодорхойлоогүй, ажлын байранд бэлгийн дарамтлал үйлдэхийг хориглоогүй, АББД үйлдэгдсэн тохиолдолд ямар хариуцлага хүлээх, хэрхэн урьдчилан сэргийлэх талаар тодорхой заасан заалт байхгүй. Тиймээс энэ асуудлыг шийдвэрлэх эрх зүйн орчинг бий болгох олон талт ажил зайлшгүй шаардлагатай.

Юуны түрүүнд:

1. Бие даасан хууль гаргах боломжийг судлах. Аль болох бие даасан хуультай болох,
2. Одоо мөрдөгдөж байгаа холбогдох хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд оруулах,
3. Дээрх 2 заалт цаг хугацаа шаардагдана гэж үзвэл дор хаяж “АББД-ын эсрэг дагаж мөрдөх журам”-ыг зайлшгүй гаргах шаардлагатай байна.

Эдгээр эрх зүйн орчинг сайжруулсны үр дүнд:

1. Ажлын байранд хамаарах орчинд бэлгийн дарамтлал үйлдэх нь “хууль бус” болох нь тодорхой болно.
2. Албан тушаалтан болон хамтран ажиллагсдын зүгээс албаны эрхээ хувийн ёс зүйгүй байдалаа илэрхийлэх зэвсэг болгож байгаа байдал таслан зогсоогдоно.
3. Үйлдвэрчний Эвлэл болон Оюутны зөвлөлийн гүйцэтгэх үүрэг функц сайжирч олон улсын жишигт нийцсэн хөдөлмөрийн дотоод журам үйлчилнэ. Ажил олгогч, ажилтнууд, багш сурагчдын мэдлэг дээшилж ажлын аюулгүй болон сэтгэл санааны хохирлоос чөлөөтэй ажлын орчин бүрдэнэ. Ажилтнуудаар дамжуулан нийгмийн ухамсар дээшилнэ.
4. Зөвлөгөө, туслалцаа үзүүлэх албад ажиллах боломж нээгдэнэ. (өмгөөллийн товчоод, эрүүл мэнд, бэлгийн халдлагад өртөгсдөд зөвлөгөө өгөх газрууд гэж ойлгож болно.)
5. Гомдол барагдуулах механизм тодорхой болно. Хохирогчдын дунд хийсэн судалгаагаар байгууллагын дотор байдаг Хөдөлмөрийн маргаан таслах комисс болон Шүүхээр шийдвэрлүүлэхийг хүсдэггүй. Харин Хүний эрхийн Комиссоор шийдвэрлүүлэхийг илүүд үздэг байна.

Хөдөлмөрлөж, сурч байгаа хэн ч ямар нэгэн айдас түгшүүргүй орчинд сурлага, хөдөлмөрөө тэгш, шударгаар үнэлүүлэх ёстойг НҮБ-аас баталж гаргасан Хүний эрхийн Конвенциуд, Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын дүрэм журмуудад тодорхой заасан байдаг.

СОЁЛ УЛАМЖЛАЛ: ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХҮНИЙ ЭРХ

**Б.Онон,
Зохистой Хөгжлийн Жендэр
Төвийн мэдээллийн ажилтан**

Өнөөдрийн манай нийгмийн хөгжлийг хойш татаж, яаралтай шийдвэрлэхгүй бол улам ужигран архагших хандлагатай байгаа хүний эрхийн зөрчил, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхлын уг шалтгааныг соёл уламжлалаас хайх, түүний хүрээнд шийдвэрлэх арга замыг хайх алхмууд хийгдэж эхэлсний тод жишээ нь 2006 оны 9-р сарын 13-нд Улаанбаатар хотод “Соёл уламжлал ба эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл” нэрийн дор болж өнгөрсөн НҮБ-ын тусгай илтгэгчтэй зөвлөлдөх уулзалт байв.

Эмэгтэйчүүдийн байгууллагын төлөөлөгчид, зах хязгаар нутгийн эмэгтэйчүүд хуран чуулж уламжлалт зан заншлын цөөнгүй ёс жаяг, хэвшмэл сэтгэлгээ монголын эмэгтэйчүүдийн хүн ёсоор аж төрөх, хүний эрхээ хамгаалахад хэрхэн саад бэрхшээл учруулж байгаа талаар анх удаа нээлттэй хэлэлцсэн нь энэ байлаа. Хүний эрхийг хамгаалах, хөгжих дэвшихэд саад болж буй соёлын сөрөг элементүүдийг илрүүлэн олох, улмаар хязгаарлан арилгах хүртэл арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх үйл явцыг оюуны болон эдийн соёлын эрхэм нандин өв уламжлалаа хадгалах үндэсний эрх ашигтай нийцүүлэх шаардлага нийгэм соёлын шилжилтийн энэ үед тулгарч байгааг дээрх зөвлөлдөх уулзалт бас харууллаа.

Хүний, ялангуяа эмэгтэйчүүдийн хүний эрх зөрчигдөхөд уламжлалт соёлын өгөх нөлөөг хөгжлийн тухай, түүний дундаас хөгжлийн суурь хүчин зүйлүүдийн нэг хэмээн дэлхий дахинд зүй ёсоор хүлээн зөвшөөрөгдөж буй жендэрийн тэгш байдлын тухай ойлголтоос ангид авч үзэх боломжгүй юм.

Хөгжил ба Жендэрийн Тэгш Байдал, Түүнд Соёлын өгөх Нөлөө

“Хөгжил бол хүний суурь эрх төдийгүй үндсэн хэрэгцээ бөгөөд хувь хүн болоод амьдарч буй нийгмийнхээ гишүүний хувьд хүрэх боломжтой хамгийн их эрх чөлөө, эрхэм чанарт хүрэх бүх нийтийн хүсэл эрмэлзлээр биелнэ” хэмээн НҮБ-ын “Хөгжих эрхийн хэрэгжилт” 1991 баримт бичигт тодорхойлжээ. Нийгмийн бүх гишүүдийг хөгжлийн үйл явцад идэвхтэй, чөлөөт, бүтээлчээр хамруулах, мөн хөгжлийн үр дүнд бүтээгдсэн ашгийг эрх тэгш хуваарилах замаар тэдний амьжиргааг байнга дээшлүүлэх зорилго бүхий эдийн засаг, нийгэм, соёл, улс төрийн цогц хөдөлгөөнийг хөгжил хэмээн тайлбарладаг.

Гэтэл тэгш бус нөхцөлд тэгш хандахыг оролдох нь асуудлыг шийдэхгүйгээр үл барам ялгавартай байдлыг улам нэмэгдүүлдэг ажээ. Эдийн засаг, улс төрийн хүрээний арга хэмжээнд хүйсийн тэгш эрхийн тухай ярьж, тэгш бус байдлыг арилгах арга хэмжээг авч ирсэн боловч цаг хугацаанд хувьсан өөрчлөгдөхөөс гадна соёл бүрт харилцан адилгүй байдаг эрэгтэй эмэгтэй хүмүүсийн нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүргийг харгалзан үзэх шаардлагаас үүдэн жендэрийн тэгш байдлын тухай ойлголт гарч ирсэн билээ. Жендэр гэдэг нь эмэгтэй эрэгтэй хүмүүсийн эдийн засаг, нийгэм, улс төр ба соёлын амьдралын онцлог шинж чанар, боломж бололцоог тодорхойлдог нэр томъёо бөгөөд эмэгтэй ба эрэгтэй хүмүүсийн биологийн ялгаа, нийгмийн үүргийг салгаж ойлгох арга зам юм.

Жендэрийн тэгш байдал */gender equality/* нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийг хүйсээр үл ялгаварлан тэгш шударга хандах жендэрийн тэгш эрхийн тухай бус, тэдний эдлэх бололцоо, амьдралд хүртэх боломж нь тэгш байх тухай асуудал юм. Жендэрийн шударга ёсыг тогтоохын тулд ялгавартай байдлыг тогтвортой хадгалахад нөлөөлж буй нийгмийн харилцаанд болон байгууллагуудын үйл ажиллагаанд өөрчлөлт хийх хэрэгтэй байдаг. Жендэрийн асуудлыг бодлогод тусгах нь хөгжлийн зорилт, нийгэм-соёлын үнэлэмжийг эргэн харах урт хугацааны шилжилтийн үйл явц мөн. үр ашгийн хүртээмж, тэгш эрхийн тэнцвэржилт нь тодорхой хугацаанд бүрэлдэн тогтдог бөгөөд янз бүрийн соёл, улс төр, нийгмийн нөхцөл байдлаас ихээхэн хамаардаг байна */өөрчлөлтийг түргэсгэх нь. Жендэрийн асуудлыг бодлогод тусгах үзэл баримтлал/*.

Соёл нь нийгэм дэх хэв маяг, үнэлэмжийг тогтоож өгдөг тул жендэрийн харьцааны үндэс суурь болдог. Соёл нь эдийн засаг, улс төрийн нөхцөл байдлаас илүү тогтвортой бөгөөд ухамсрын бүх түвшинд үеэс үед дамжих итгэл үнэмшил, үнэлэмжийг тогтоодог учир нийгмийн гишүүдийн хоорондын, түүний дотор жендэрийн харьцаанд гүйцэтгэх үүрэг нь асар өндөр. Янз бүрийн соёлууд нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурийн тухайд харилцан адилгүй хэм хэмжээг тогтоож өгдөг бөгөөд соёл бүрт өөр өөрийн “төгс эмэгтэй” болон “төгс эрэгтэй”-н дүр төрх бүтээгдэж нийгмийн сэтгэхүйд төлөвшсөн байдаг. Үл хүлээн зөвшөөрөх, үл тэвчих үзэл бүхэн нь аливаа хүчирхийллийн үндэс болдгийг түүх гэрчилнэ. Жендэрийн тухайд хатуу тогтсон хэвшмэл сэтгэлгээ нь дээрх “төгс” дүр төрхөд нийцэхгүй байхыг, мөн эр хүнд байх эмэгтэйлэг, эмэгтэй хүнд байх эрэгтэйлэг шинжийг үл хүлээн зөвшөөрөх буюу тодорхой хэмжээгээр буруу, зохисгүй зүйл гэж үзэх хандлагыг төрүүлэх хүчин зүйл болдог ажээ.

Харамсалтай нь өнөөдрийн манай нийгмийн хөгжлийг хойш татаж, яаралтай шийдвэрлэхгүй бол улам ужигран архагших хандлагатай байгаа хүний эрхийн зөрчил, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхал, авилга,

архидалт зэрэг сөрөг үзэгдлүүдийн уг шалтгааныг улс төр, эдийн засгийн хүчин зүйлтэй холбон тайлбарлах хандлага нийгэмд зонхилж ирлээ. Улс төрийн тогтворгүй байдал, эдийн засгийн уналт, түүнээс үүдсэн ядуурал нь дээрх сөрөг үзэгдлүүдийн суурь шалтгаан хараахан биш, өдөөгч, сэдээгч хүчин зүйлүүд байдаг бөгөөд жинхэнэ шалтгаан нь бидний оюун сэтгэхүйд гүн суусан үнэлэмж, итгэл үнэмшил байдгийг ойлгохын тулд соёл хэмээх ойлголтыг бидний өдөр тутам хэрэглэж дадсанаас илүү өргөн хүрээнд авч үзэх нь чухал юм.

СОЁЛЫН ТУХАЙ

Соёл нь үндэстний оршхуйн төрх, үзэл санааг тээн хадгалах, дамжуулах, нийгмийн гишүүдийн нэгдлийг хангах үүрэг гүйцэтгэдгээрээ улс орны хөгжлийн суурь чадавхыг тодорхойлдог байна. Соёл гэдэг нь тухайн нийгмийг тодорхойлхуйц нийтлэг үзэл санаа, үнэт зүйлс, зорилго, зан үйлийг буй болгож байдаг, хүний нийгмийн хөгжлийнхөө явцад бүтээсэн утгын ертөнц юм. Ард түмний өөрийгөө илэрхийлэх, мэдлэгээ үеэс үед дамжуулах /өвлүүлэх/ чадварыг тодорхойлдог оюун санааны болоод биет үнэт зүйлсийн цогцыг ерөнхийд нь соёл хэмээн ойлгож байна. Энэхүү өөрийгөө илэрхийлэх, мэдлэг туршлагаа дамжуулж өвлүүлэх үйл явцад гол үүрэг гүйцэтгэгч хэл нь соёлын амин сүнс хэмээн зүй ёсоор тооцогддог байна. Хэл яриа нь сэтгэхүйн царааны хэмжүүр байдгийг мэдэхгүй хүн үгүй. уг устан алга болох нь түүний илэрхийлдэг утга мөн бидний сэтгэхүйгээс үгүй болж байгааг харуулдаг. Мөн түүхийн явцад үг, хэллэгийн утга өөрчлөгдөж, шилжиж тэр хэмжээгээр бидний сэтгэхүй хэвшин бүрэлдэж байдгийг ажиглахад хялбар бөгөөд энэ нь соёл тогтонги өөрчлөлтгүй зүйл биш, байнга өөрчлөгдөн хувьсаж, нийгмийн хэвшмэл сэтгэлгээг шинээр бүрэлдүүлэн төлөвшүүлж байдгийн тодхон жишээ юм. Хэл ярианы тухайд бидний авч үзэж буй сэдэвт ч мөн холбогдох нэгэн жишээг авъя: Англи хэл дээрх *Culture* хэмээх үг нь бидний одоогийн ойлголтоор *соёл иргэншил*, *соёл хэмээх асар өргөн утга илэрхийлдэг*. Харин бид соёл хэмээх үгийг өдөр тутмын амьдралдаа нилээд явцуу утгаар хэрэглэж төлөвшсөн. Нөгөө талаас *Civilization* буюу иргэншил хэмээх үгийг бид орос хэлээр дамжуулан орчуулахдаа *соёл иргэншил* хэмээн буулгаснаас иргэншлийг, тэр тусмаа суурин иргэншлийг соёл хэмээн ойлгох хандлага төлөвшсөн. үүнээс үүдээд монголын уламжлалт нүүдлийн соёлоо соёл иргэншил мөн, биш гэх зэргээр маргалдах, аргаа барахдаа нүүдлийн аж ахуй гэх зэргээр нэрлэхийг оролдох болжээ.

Соёлын үндсэн үүрэг нь нийгмийн гишүүдийн эв нэгдэл, тэдний хоорондын хүмүүнлэг зохист харьцааг бүрдүүлэх, улмаар “нийгмийн туршлагыг” хуримтлуулж, дамжуулахад оршино. Мөн “нийгмийн туршлагыг” нөхөн сэргээх, нөхөн үйлдвэрлэхэд соёл чухал үүргүүдийг

өөртөө хүлээдэг. Соёлын системийг эдийн соёл буюу биежсэн сэтгэлгээ, түүний цаана орших үнэлэмж, итгэл үнэмшил, энэ бүгдийн цөм болсон үзэл санаа хэмээн гурван давхаргат загвараар авч үзье. Энэ загварыг удирдхуйн шинжлэх ухаанд ашигласан байдаг. Удирдхуйн шинжлэх ухаан анх байгууллагын хөдөлмөр зохион байгуулалт, ажлын нөхцөл бүтээмжид хэрхэн нөлөөлж байгааг судлан гараагаа эхэлснээ байгууллагын соёл хэмээх ойлголт руу орж, үүнийхээ цөмөөс үзэл санаа буюу байгууллагын эрхэм зорилгыг гарган авсан байдаг.



Соёлын системийн дээрх давхаргууд нь урт удаан түүхэн хугацаанд бүрэлдэн тогтох ба гол цөм болох үзэл санаа нь нийгмийн гишүүдийн итгэл үнэмшил, үнэлэмжийн системээрээ хамгаалагдаж, харин үнэлэмж, үнэт зүйлс нь оюуны болон эдийн соёлоор дамжин илэрч, түүний нөлөөн дор бүрэлдэн төлөвшдөг байна. Ахуйн хэрэглээний эд юмсын үр хийцээс эхлээд барилга архитектур, урлаг, утга зохиол, ёс заншил, боловсрол, шинжлэх ухаан, шашин бүгд бидний зургаан мэдрэхүйгээр дамжин үнэлэмж итгэл үнэмшлийг бүрэлдүүлэх ба нөгөө талаар бидний ертөнцийг үзэх үзэл, итгэл үнэмшлийн илэрхийлэл болж байдаг. Иймээс ч бид аливаа улс орны соёлын үнэт зүйлсийг харж бишрэхдээ түүгээр дамжуулан тэр ард түмний таашаал мэдрэмж, үнэлэмжийг, бүр цаашилбал үзэл санааг мэдэрч байдаг билээ.

Монголын соёл нь дэлхийн том соёл иргэншлүүдийн дунд өөрийн өвөрмөц өнгө төрхөө хадгалан хөгжиж ирсэн бөгөөд уламжлалт нүүдлийн соёл иргэншлийн хөгжлийн оргил нь сонгодог утгаараа монгол улс байгуулагдаж эзэнт гүрэн болон тэлсэн XIII зуун байсан бөгөөд манж чин улсын хараат болсон үеэс уналтад орсон гэж түүхчид үздэг.

20-р зууны эхэн үеийн үндэсний чөлөөлөх хөдөлгөөн, ардын хувьсгал, мөн 1990-ээд оны социалист системийн задрал, ардчиллын ялалт нь нэг

талаас үндэсний ухамсрыг сэргээж уламжлалт соёл, заншлын илрэлүүдийг хүчтэй болгохын зэрэгцээ барууны соёлын нөлөөг нээлттэй болгож монголчуудын оюун санаа, амьдрах хэв маягт нөлөөлж ертөнцийг үзэх үзэл, үнэлэмжийг хөгжүүлж ирсэн. Дээрх нийгэм соёлын шилжилтүүдийн аль аль нь нэг талаас дэвшилтэт, шинэлэг байдлаар бодож сэтгэх, амьдрах эрх, нөгөө талаас уламжлалт соёлынхоо дагуу амьдрах эрх гэсэн соёлын эрх чөлөө хэмээх ойлголтын хоёр утгыг давхар агуулж иржээ.

Соёлын хөгжил нь нийгмийнхээ хөгжлийн үйл явцаас хоцорвол хойш татаж эхэлдэг ба гадны соёлыг суулгах замаар хэсэг хугацаанд тэнцвэржүүлж болдог ч алсдаа сөрөг үр дагавартай. Манай оронд 1920-иод онд энэ явдал тохиолдсон бөгөөд одоо дахин тохиолдож байна гэж соёл судлаачид үзэж байна.

Монголчуудын уламжлалт нүүдлийн сэтгэлгээний соёл, үнэт зүйлсийн систем бүрэлдэн тогтоход Буддын шашин, коммунист үзэл хоёр маш чухал нөлөө үзүүлснийг бид мэднэ. Аливаа шашин нь хүний дотоод мөн чанарт хүрэх арга зам байдаг ёсоор Буддын шашин нь дотоод ертөнцийг үлэмж ихээр өргөжүүлэн тэлсэн. Ингэхдээ монголчуудын уламжлалт бөөгийн шашин, мөнх тэнгэрийн шүтлэгийн зарим үнэт зүйлсийг өөртөө шингээн хадгалж үлдсэн нь монголын өнөөгийн соёлын өвөрмөц шинж чанарын нэгэн тал билээ. Коммунизмын үзэл суурин соёл иргэншилд шилжих шилжилтийн эхэнтэй давхцан орж ирсэн нь уламжлалт үнэт зүйлс, үнэлэмжийн систем нилээд ихээр эвдэрч сүйдэх нөхцөлийг бүрдүүлсэн байж болох юм.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт, коммунизмаас ардчилсан нийгэмд шилжих шилжилт нь бас нүүдлийн соёл иргэншлээс суурин соёл иргэншилд шилжих их давлагааг дагуулсан нь үнэт зүйлс, үнэлэмжийн системийг дахин сууриар нь доргиож, хотожсон хүн амын 2-3 дахь үе төрснөөр соёлын ялгаа хэт ихэссэнээс гадна сэтгэлгээний соёлын систем хямарч ангал, “вакуум” үүсчээ. Энэ ангальд бидний олонх төөрч, соёлынхоо гол цөм болох үзэл санаагаа алдаж буюу олж харахаа больж орхисон бололтой.

Манай улс дахь жендэрийн харьцааг нийгэм соёлын өөрчлөлттэй холбон хийсэн судалгаа харамсалтай нь бараг байхгүй. Харин монголын эмэгтэйчүүдийн асуудлыг судалдаг Осака гадаад судлалын их сургуулийн профессор Имаока Риоко ийнхүү бичжээ: өнөөгийн байдлаас аваад үзэхэд үүнийг шийдэх зав бололцоогүй байж магадгүй ч шууд олж харж чадаагүй асуудлууд байсаар байна. Хуучны социалист нийгэм сайхан байсан. Зах зээлд шилжээд муу болчихлоо” гэх асуудал юм. Үнэхээр социалист нийгэмд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн үзэл бодол хязгаартай, нийгэм дэх эмэгтэйчүүдийн байр суурийн өсөлт баталгаажсан байсан хэдий ч зах зээлд шилжсэнээс хойш, эмэгтэйчүүд гэр бүлийн хүчирхийлэлд өртөн, ажилд ороход хэцүү болж, биеэ үнэлэх явдлыг амьдралынхаа эх сурвалж

болгон, хүний худалдаа, наймаа эрхлэгчдийн урхи занганд орж хохирсон нь эдийн засагтай зайлшгүй холбоотой. Харин социалист нийгмийн үед хориотой байсан уламжлалт үзэл бодол, зан заншил нь ардчилал дахин сэргэсэнээр урьд нь нуугдмал шинжтэй байсан хүйсийн ялгаварлан гадуурхах үзэл дахин ил гарч ирсэн болов уу гэж бодогдож байна. Нөхрийнх нь мал аж ахуйгаа хөтлөх арга барил, гэр бүлийн доторх хүчирхийлэл, дахин сэргэсэн ламын шашин зэрэг нь хүйсийн тал дээр сайн талыг нь дэмжиж, биеэ үнэлэх асуудлыг ч засаж залруулах шаардлагатай байна. /Имаока Риоко: *Монгол улс дахь эмэгтэйчүүдийн талаарх судалгааны чиг хандлага ба судалгааны танилцуулга, 2005/*

СОЁЛЫН ЭРХ ЧӨЛӨӨ БОЛОН ДААРАШЛЫН ТУХАЙ

Даяаршлын энэ эрин үед нэг талаас нийгмийн хөгжил дэвшлийг хойш татаж буй хэвшмэл сэтгэлгээгээ өөрчлөн хүн төрөлхтний нийтлэг, дэвшилтэт үнэт зүйлсийг нийгмийн сэтгэхүйд төлөвшүүлэх, нөгөө талаас даяарчлалын таагүй үр дагавруудаас хамгаалахын тулд уламжлалт соёлын өв, үнэлэмжийн системээ хадгалан хөгжүүлэх нь монголд төдийгүй эдийн засгийн хөгжил дорой, шилжилтийн үеийг туулж буй бусад орнуудын хувьд ч амин чухал, эмзэг асуудал болж байна.

Хүний хөгжил гэдэг нь хүмүүсийн хэн байх, юу хийхээ үнэт зүйлс, итгэл үнэмшлийнхээ дагуу сонгох боломжийг нь өргөтгөх үйл явц юм. ...Шалгуур тогтоох, зүгээр нэг тодорхойлоход ч хэцүү хүний хөгжлийн бас нэгэн чухал “бүрэлдэхүүн хэсэг” бол соёлын эрх чөлөө юм. Соёлын эрх чөлөө нь хүмүүсийн хүсэл сонирхлынхоо дагуу амьдрах чадвараа дээшлүүлэхэд нь тэргүүн зэргийн ач холбогдолтой. Соёлын эрх чөлөөний хөгжил дэвшил нь хүний хөгжлийн төв элемент байх ёстой бөгөөд үүний тулд хөгжлийн ийм эрх чөлөөг олгодоггүй нийгэм, улс төр, эдийн засгийн хүрээний хязгаараас гарах хэрэгтэй. Соёлын эрх чөлөө гэдэг нь хүмүүсийн амьдралынхаа (сурч боловсрох, эмнэлгийн үйлчилгээ авах, ажил эрхлэх зэрэг) бусад чухал хүрээнд хийх сонголтоо хязгаарлахгүйгээр оршуйн төрхөө сонгож, хүссэн хэв маягаараа амьдрах боломж юм. /НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр. *Хүний хөгжлийн илтгэл, 2004./*

Соёлын эрх чөлөө хэмээх ойлголт нь нэг талаас уламжлалт хуучинсаг зан заншлын хүрээнээс гарч хүн төрөлхтний нийтлэг дэвшилтэт үнэт зүйлс, үнэлэмжийг сонгон амьдрах, нөгөө талаас улс үндэстнүүд /түүний дотор ястнууд, үндэстний цөөнх, хэсэг бүлэг хүмүүс болон хувь хүн/ өөр өөрсдийн өвөрмөц төрх, уламжлалт соёлоо хадгалан амьдрах гэсэн хоёр чиг хандлагын аль алийг багтаан авч үздэг. Сүүлийнхийг нь хамгаалах, хөгжүүлэх бодлогыг соёлын олон төрөл зүйлийн бодлого ч гэж нэрлэдэг.

Энэ талаар НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс эрхлэн гаргадаг Хүний хөгжлийн илтгэл 2004-д хэрхэн тусгасныг үзье: Эрх чөлөөний чухал байдал

нь түүнд эрмэлзэх явцад шударга ёс, тэгш байдлыг хангах шаардлагатай нягт холбоотой. “Соёлын олон төрөл зүйл нь эмэгтэйчүүдэд хортой юу?” гэсэн асуулт гарч ирнэ. ...Энэ асуудлыг судлахад соёлын эрх чөлөөг өргөн утгаар авч үзэх нь нэн чухал. Хэвшсэн зан заншлыг хамгаалахдаа тийм соёлын хэм хэмжээг эмэгтэйчүүд өөрсдөө голцуу эсэргүүцэлгүй хүлээж авдаг хэмээн нотолгоо болгох нь тохиолддог... Энд зан заншлыг эрхэмлэх гүйцэд судлагдаагүй үзлийг соёлын эрх чөлөөтэй андуурч төөрөлдөхгүй байх нь нэн чухал ажээ.

Соёлын эрх чөлөө нэг талаас хөгжил дэвшлийн, ардчиллын шалгуур үзүүлэлт бөгөөд соёлын эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх, нийгмийн гишүүдийн соёлын эрх чөлөөгөө эдлэх эрхийг хангах нь үзэл санааны дэвшил юм. Гэвч нөгөө талаас соёлын эрх чөлөөгөө эдлэх нэрийн дор хувь хүний эрх чөлөөг боогдуулж, жендэрийн тэгш байдлыг хангахад саад болсон зан заншил, хэвшмэл сэтгэлгээ халхлагдан үлдэх тохиолдол байдаг. Иймд соёлын эрх чөлөөний тухай ярих бүрт энэ нь эмэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлж байгааг анхаарах хэрэгтэй.

Соёлын эрх чөлөөний эерэг ба сөрөг утга нь монголын эмэгтэйчүүдийн хувьд ямар байдлаар илэрч байгааг жишээлэн авч үзье.

Соёлын эрх чөлөөний эерэг үр дүн нь нийгмийн гишүүдийн сонголт хийх боломж, хийсэн сонголтондоо сэтгэл ханамжтай амьдрах нийгмийн сэтгэлгээ, түүнийг бүрдүүлэх үнэлэмжийн систем байдаг.

Гэтэл монголын өнөөгийн нийгэм соёлын ээдрээт байдал нь хувь хүнд, ялангуяа эмэгтэй хүнд сонголт хийх маш түвэгтэй нөхцөлийг бий болгож байна. Хүрээгээ улам тэлж буй суурин амьдралын хэв маяг, нийгэм соёлын шилжилтийн үед түрэн орж буй барууны хэмээн тооцогддог сэтгэлгээний хэв загвар нь монголын эмэгтэйчүүдэд боловсрол мэдлэгийнхээ цаараар ажил хөдөлмөр эрхлэх, амжилтанд хүрэх тэмүүллийг бий болгож байгаа ч тэд уламжлалт соёлын дагуу гэр бүлийн хүрээнд хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн хэвээр байгаа нь давхар ачааг үүрүүлж байна. Аль нэг ачаагаа багасгах сонголт хийлээ ч түүндээ сэтгэл ханамжтай байх үнэлэмж, сэтгэхүй төлөвшөөгүй байна.

Өнөөдөр ядуурлыг, хүний эрхийн зөрчлийг тогтоохдоо биологи, эрүүл ахуйн зайлшгүй шаардлагатай зүйлс, хоол хүнсний илчлэг тэжээлээс гадна ахуйн болон соёл, оюуны наад захын хэрэгцээгээ хангаж чадаж байна уу гэдгийг тооцдоггүй. Нийгэм, эдийн засаг хямрах бүх л тохиолдолд эмэгтэйчүүдийн нуруун дээр ахуй амьдралын хамаг ачаа бууж, түүндээ түүртэн оюун санаа, сэтгэхүйн амьдрал нь хумигдах хандлагатай байдаг нь ажиглагддаг. Үүний үр дагаврыг хэн ч тооцдоггүй нь харамсалтай.

Сүүлийн үед уламжлалт зан заншил, үнэлэмж эмэгтэйчүүдэд хамгийн таагүй хэлбэрээр сэргэж буюу “сэргээгдэж” байгаа нь нийгэм соёлын шилжилтийн сөрөг үр дагавар гэж дүгнэж болохоор байна. Хэдэн мянган

жилээр байгаль орчинтойгоо зохицон, төр улсаа байгуулан хөгжиж ирсэн монголын уламжлалт соёлд хүндлэн дагах, өвлүүлэн үлдээх үнэт зүйлс асар их бий боловч тэдгээрийн зарим нь мартагдан орхигдож, зарим нь мушгин гуйвуулагдаж, эрх мэдлийг бататгах хэрэгсэл болон ашиглагдаж байгаа нь харамсалтай. Сүүлийн үед олон эмэгтэйчүүд уул овоо тахих ёс сэргэж, түүнтэй хамт эмэгтэй хүн гишгэж болохгүй газрын тоо олширч байгаа тухай ярих болсон нь үүнийг гэрчилж байна. Уул овоо тахих нь байгаль дэлхийгээ шүтэх бөө мөргөлөөс үүдэлтэй монголын эртний ёс бөгөөд зарим тохиолдолд улай гаргаж малын цусаар тахилга үйлдэх хатуу үйл оролцдогтоос эмэгтэй хүнийг, нэн ялангуяа хөл хүндтэй хүнийг хол байлган хатуугаас хамгаалах заншилтай байсан гэж учир мэдэх хүмүүс ярьдаг. Түүнээс биш эмэгтэй хүн бузар, дорд учраас тахилгад оролцвол уул ус хилэгнэнэ гэсэн санаа анхандаа байгаагүй бололтой. Гэтэл сүүлийн үед чухам ийм утгаар сурталчилж, эмэгтэйчүүдийг ялгаварлах хэрэгсэл болон ашиглаж байгаа нь ямар ч ёс заншлын утга санааг мушгин гуйвуулж, ашиг сонирхлын зэвсэг болгож болдгийг харуулж байна.

Иймэрхүү үзэгдэл нь нийгэм дэх үзлийн туйлшралыг хөөрөгдөж, түүнээс үүдэх ялгаварлан гадуурхал, хүний, түүний дундаас эмэгтэйчүүдийн хүний эрх зөрчигдөх хөрс суурийг бэлдэж байна. үүнд улс төрийн тогтворгүй байдал, түүний дотор ардчиллыг жинхэнэ утгаар нь биш, “формал” байдлаар хөгжүүлж буй байдал, эдийн засгийн хөгжил дорой, ядуурал их байгаа зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байгаа бөгөөд эдгээрийг тооцож, шийдвэрлэхэд чиглэсэн бодлого бүх түвшинд дутагдаж байгаа нь хамгийн түгшүүртэй байна.

Эмэгтэйчүүдийг дорд үзэж, эмэгтэйчүүдийн хүний эрхийг хязгаарласан зан заншил ялангуяа зах хязгаар нутгаар сэргэж байна гэж дүгнэж болох байна. Жишээлбэл Дарьганга нутагт өндгөн сүй тавьж гэр бүл болох заншил тодорхой хэмжээгээр хадгалагдан үлдсэн байснаа сүүлийн жилүүдэд хүчтэй сэргэж байгаа тухай 9-р сарын 13-ны зөвлөлдөх уулзалтад оролцсон эмэгтэй ярьж байлаа. Хадмын гэрт бэр болж амьдрахаар очсон эмэгтэйг гэр орны бүх ажлыг хийх, сүү цаган идээгээ боловсруулах, түүний дээр уранаар оёж хатгах, нөхрөө хүндлэн дээдэлж түрүүлэн босч сүүлдэж унтах, сэрэнгүүт өмнө нь ширээ тавьж цай аягалах гэх зэргээр нилээд хүнд шалгуур угтдаг ажээ. Хэрэв шалгуурыг даваагүй эмэгтэйг нөхөр болон хадмууд нь төрсөн гэрт нь буцаан хүргэх эрхтэй бөгөөд авч ирсэн эд хөрөнгө, малыг нь буцааж өгдөггүй ажээ.

Уламжлалт зан заншлын таагүй илрэлүүдээс гадна даяаршлын үр дагавар болох барууны соёлын зарим элемент, тухайлбал хүчирхийлэл, харгислал, садар самууныг сурталчилсан кино, клипүүд, хэрэглээний сэтгэхүйг төлөвшүүлэгч телевизийн зар рекламууд нь мөн эмэгтэйчүүдийн хүний эрхийг зөрчих, хүчирхийллийг нэмэгдүүлэх нэгэн хүчин зүйл болж байна.

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, жендэрийн тэгш бус байдлыг соёлын нөхцөл байдалтай холбон үзэх хандлага, эрмэлзэл нийгэмд төлөвшөөгүй байгаа нь энэ бүх асуудлыг хөндөж ярихад ч түвэгтэй байдлыг үүсгэж байгаа юм. Энэхүү нөхцөл байдлын үр дүн нь өнөөдөр хувь хүмүүсийн амьдралдаа сэтгэл ханамжгүй байдал даамжирч, гэр бүлийн харьцаа муудаж, хүчирхийлэл ихэсч байгаагаар илэрч байна. Энэ байдал хэвээр үргэлжилбэл ирээдүйд нийгэмд хүчирхийлэл улам ихэсч, жендэрийн тэгш бус байдал улам ужгиран гүнзгийрч нийгмийн хөгжил удаашрах үр дагавартай.

Эмэгтэйчүүд соёлыг бүтээхэд өөрсдөө идэвхтэй оролцох замаар л өөрсдөдөө ээлтэй, дэвшилтэт шинэ үнэлэмж бүхий соёлыг бий болгож чадах нь эргэлзээгүй. Гэтэл манайд эмэгтэйчүүдийн соёлыг бүтээхэд оруулж буй хувь нэмэр, түүнийг үнэлж буй байдал нь бүрхэг, судлагдаагүй асуудлын нэг хэвээр байна. Жишээлбэл, монголын утга зохиолд эмэгтэйчүүдийг хэрхэн дүрсэлсэн, ялангуяа эмэгтэй зохиолчид ямар дүр бүтээснийг судалж үзвэл өсвөр үеийнхэн, залуучуудын сэтгэхүйд монгол эмэгтэйн тухайд бүрэлдэн тогтсон дүр төрхийн нэгэн тайлбар болох нь эргэлзээгүй. Уран зураг, баримал, кино, дуу, хөгжим гээд урлагийн бүх л салбарыг энэ мэтчилэн нэрлэж болох билээ.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал: Хүн бүр нийгмийн гишүүний хувьд нийгмээс хангамж авах эрхтэй бөгөөд нэр төрөө хамгаалах, биеэ боловсруулж хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засаг, нийгэм, соёлын талын эрх дархаа тухайн орны хүчин чармайлт хийгээд олон улсын хамтын ажиллагааны нөөц бололцоонд нийцүүлэн эдлэх эрхтэй. Хүн бүр нийгмийнхээ соёлын амьдралд бүтээлчээр оролцох, урлагийг бахдах, шинжлэх ухааны дэвшилд оролцож үр шимийг нь хүртэх эрхтэй гэжээ.

Манай улсын соёл, урлагийн салбарт амжилт гаргасан эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдийн тоог харьцуулан үзвэл гарах дүгнэлт илт боловч эмэгтэйчүүдийн гэр бүлийнхээ хүрээнд соёлын ертөнцийг бий болгож буй хувь нэмрийг дүгнэж тооцож байгаагүйг бас анхаарах хэрэгтэй юм. Эрэгтэйчүүд давамгайлсан нийгмийн хэвшмэл сэтгэлгээ нь соёлын салбарт ч эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарлах нийгмийн байгууламжийг тогтоодог ажээ.

Эмэгтэйчүүдийн соёлыг бүтээхэд оруулсан хувь нэмэрт феминист онолчид, зохиолчид хүндтэй байр суурь эзэлнэ. Анх европт үүсч хөгжсөн феминист сэтгэлгээ нь эмэгтэйчүүд эрчүүдтэй адил тэгш эрхтэй байх ёстой гэсэн санааг хөгжүүлэхдээ жендэрийн үзэл баримтлалын төлөвшил, жендэр судлалд чухал түлхэц өгч, нэгэн чухал суурь нь болж өгсөн юм. “Феминизм нь нэг ёсондоо эпистемологийн* хурдасгуурын үүрэг гүйцэтгэсэн бөгөөд “шинжлэх ухааны үндэслэл”, ашиг тустай байх зэрэг түүхэн хөгжлийн зарчмуудын сүүдэрт түүхийн танин мэдэхүйн доторх элдэв чиг

урсгалуудыг үгүйсгэж, дарж, саармагжуулж байсан эрх мэдлийн механизмыг танихад хувь нэмэр оруулсан юм” гэж жендэр судлаачид үзсэн байдаг. /А.Усманова. “Визуальный поворот и гендерная история”, 2004/ *-Эпистемологи нь мэдлэгийн үнэ цэнэ, мөн чанарын тухай судалдаг метафизикийн ухааны салбар юм./

СОЁЛ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХАД

Уламжлалт соёлынхоо орчин үеийн нийгмийн хөгжлийн шаардлагыг хангахуйц жинхэнэ бахархууштай, эерэг зүйлсийг хөгжүүлэн дэлгэрүүлэх, манай улс дах нийгэм соёлын шилжилтийн болон даяарчлалын үр дагавар болж буй барууны соёлын нөлөөнөөс нийт хүн төрөлхтний хөгжлийн чиг баримжааг тогтоож буй эерэг зүйлсийг нэвтрүүлэх, дэмжих замаар нийгэмд шинэлэг, дэвшилттэй үнэлэмжийг буй болгоход чиглэсэн бодлого төр засгийн болон төрийн бус байгууллагуудын түвшинд шаардагдаж байна. үүнийг эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал, хүчин зүйлийг харгалзан үзэж уялдуулалгүйгээр хийх боломжгүй бөгөөд, үүнд олон улсын түвшинд хийсэн судалгаа шинжилгээ, туршлагыг ашиглах нь зүйтэй байна.

Гэр бүлийн амьдралын хүрээнд уламжлалт соёлыг хадгалах, өвлүүлэх, гэр бүлийн гишүүдийн үнэлэмж, итгэл үнэмшлийг төлөвшүүлэхэд эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүргийг ойлгож хүлээн зөвшөөрөх, улмаар соёл, боловсролын бодлогод тусгах сэтгэлгээний соёлыг бид аажмаар төлөвшүүлэх ёстой. Жишээлбэл, боловсролын салбар дах жендэрийн гажуудал хэмээх нэрээр их дээд сургуульд охид илүү суралцаж байгааг буруутгаж шүүмжилсэн өнгө аясыг гаргах биш, харин үүнийг нийгмийн хөгжилд хийж буй хөрөнгө оруулалт, гэр бүлийн хүрээнд авч үзвэл ирээдүйн эхчүүдэд, тэднээс төрөх үр хүүхдүүдэд хийж буй оюуны хөрөнгө оруулалт хэмээн үнэлж, боловсролыг улам чанартай болгоход чиглэсэн сэтгэхүйг нийгэмд бий болгоход чиглэсэн судалгаа шинжилгээний ажил, сургалтын хөтөлбөр, соёл, боловсролын салбарт ажиллагсад, бодлого боловсруулагчдыг хамруулсан уулзалт хэлэлцүүлэг эн тэргүүнд шаардагдаж байна.

Өнөөдөр нийгмийн оюун санааг эрүүлжүүлэх, цэвэршүүлэх, ёс суртахууны төлөвшлийн тухай асуудлыг тавих нь зайлшгүй бөгөөд энэ нь эмэгтэй хүний зүгээс нийгэмд гүйцэтгэх үүргийн гол хэсэг нь байх ёстой болов уу. Монгол эрэгтэй, монгол эмэгтэй гэж хэн бэ, эдний нийгмийн сэтгэхүйд хэвшсэн дүр төрх хэрхэн өөрчлөгдөж байна вэ гэдгийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлох нь түүнд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тооцож бодлого арга хэмжээнд тусгахад зайлшгүй шаардагдаж байна.

Эмэгтэйчүүдийн бодлого тодорхойлоход оролцох оролцоо нь өөрсдийгөө ямар түвшинд ухамсарлаж, мэдэрч байгаагаас шалтгаалдаг гэдэг

/Орлофф 1993.138/

Нийгмийн үзэл бодол, үнэлэмжийг өөрчлөх өөрчлөлтийг эмэгтэйчүүд өөрсдийн үзэл бодлоос, үнэлэмжээс эхлэх хэрэгтэй байгааг дараах хоёр жишээгээр үзье.

Нэгдүгээрт, монголын эмэгтэйчүүд бусад орны эмэгтэйчүүдийг бодвол илүү эрх чөлөөтэй, дарлагдаж боолчлогдсон зүйлгүй, ийм учраас энэ тухай яриад байх гойд асуудалгүй, ер нь л бараг тэгш эрхтэй, харин ч бүр дарж байхгүй бол болохгүй гэх үзэл баримтлал манай нийгэмд, ялангуяа эрчүүдийн дунд нилээд түгсэн байдаг. Эмэгтэйчүүд өөрсдөө ч “монгол эмэгтэй хүчтэй, чадалтай” гэх үзэлтэй байдаг. Үүнийгээ морь унадаг, гэр бүлийн доторх зарим асуудлаар шийдвэр гаргадаг гэх зэргээр тайлбарладаг. Гэвч үүнд жендэрийн дүн шинжилгээ хийж үзвэл энэ нь нүүдлийн мал аж ахуйн ажил хөдөлмөрийн хуваарилалтаас шалтгаалсан онцлогоос, тухайлбал морь унаж нүүдэллэх, малаа маллахаас өөр аргагүй, нөхрөө аян жин, ан гөрөө, оторт явсан хойгуур өрхийн аж ахуйн түвшинд зарим шийдвэр гаргахаас өөр аргагүй зэрэг байдлаас шалтгаалсан зүйл байдаг. Харин эдийн засгийн хувьд бие даасан, жинхэнэ ёсоор тэгш эрхтэй байсан зүйл үгүй гэдгийг ойлгоход хэцүү биш. Монгол эмэгтэйчүүдийн хүч чадал нь нийгэмд тэгш бус байдал, ялгаварлал, хүчирхийлэл үгүй байгаад биш, түүнийг дааж үүрч, сөрөн зүтгэж, тэмцэж байгаад л оршиж байна гэдгийг хүлээн зөвшөөрөх нь бодит байдлыг үнэн зөвөөр ойлгох нэг алхам байх.

Хоёрдугаарт, гэр бүлийн хүчирхийлэл нуугдмал байдалтай байгаа нь түүнтэй тэмцэх ажилд саад учруулж байна. Хүчирхийллийг арилгахын тулд юуны өмнө түүний оршин байгааг хүлээн зөвшөөрч, ил гаргах хэрэгтэй.

Уламжлалт соёлын нөлөө хүчтэй, эдийн засгийн хөгжил буурай нийгэмд хувь хүмүүс өөрийгөө чөлөөтэй нээн илэрхийлэх биш, амьд гарах, амиа хоохойлох амьдралын стратеги баримталдаг бөгөөд нийгэмд хэвшсэн үнэлэмжид захирагдаж, түүнийг дагахаас өөр аргагүй байдгийг олон улсын хэмжээний томоохон судалгаанууд харуулж байна. Монголын тохиолдолд дээрх хүчин зүйлүүдээс гадна социализмын үеийн үзэл суртал нь хүчирхийллийг нуун дарагдуулах сэтгэлгээг бэхжүүлсэн. Социалист системд өнгөрүүлсэн 70 жил манай эмэгтэйчүүдийн соёл боловсрол, эрүүл мэнд болон хүний эрхээ ухамсарлахад үнэлж баршгүй нөлөө үзүүлсэн. Гэвч нөгөө талаас манай нийгэмд ялгаварлал, хүчирхийлэл байхгүй гэсэн тунхагалд нийцүүлэн, нөгөө талаас хаалттай нийгэмд олны нүдэнд чичлэгдэж дорд үзэгдэж нийгэм дэх байр сууриа алдахаас эмээн “жүжиглэж” амьдрахыг олон эмэгтэйд тулгаж байснаараа асуудлыг нуун дарагдуулах сэтгэхүйг гүнзгийрүүлэн төлөвшүүлснийг тооцолгүй орхиж болохгүй.

Уламжлалт соёлын эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан, дорд үзэж хүний эрхийг нь зөрчсөн илрэлүүдэд мэдрэмжтэй хандаж дуу хоолойгоо гаргахдаа туйлширч хавтгайруулахаас сэрэмжилж эрүүл ухаан, нарийн

мэдрэмжээр хандахгүй бол хойч үеэ монголын, уламжлалт гэх бүхнээс нүүр буруулан жигшдэг болгох аюултай. Уламжлалт зан заншил хэмээн тооцож байгаа тэр зүйл маань үнэхээр монгол уламжлал мөн эсэх, хэдий үед ямар утгаар хэрэглэгдэж хэвшсэн зэргийг сайтар судалж харгалзан үзэх, мушгин гуйвуулагдсан зан заншлын жинхэнэ утга учрыг сэргээн тайлбарлах нь нийгэм хойч үеийнхээ өмнө бидний хүлээх нэгэн үүрэг билээ. Мөн нийгмийнхээ тухайн үеийн хөгжлийн түвшинд нийцэн хэрэглэгдэж байсан зан үйл, итгэл үнэмшил өнөө үед тохирохгүй болсныг тунгаахдаа өнгөрсөн үеийг шүүмжлэх, үгүйсгэх хандлага гаргах нь асуудлыг шийдэх арга биш гэж санагдана.

Гэр бүлийн асуудал, ажил эрхлэлтийн нөхцөл, нийгмийн халамж, татвар ногдуулалт, боловсролын салбарын адил тэгш бололцоо, эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах арга хэмжээ хийгээд тэрчлэн тэгш байдлыг хөхүүлэн дэмждэг харьцаа ба соёлын тухай төсөөлөлтэй холбогдуулан хууль тогтоомжийн шинэчлэл явуулах арга хэмжээ авахыг Бээжингийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хүрээнд үндэсний механизмаас авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээнд заасан байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр тарж буй мэдээлэлд мэдрэмжтэй хандаж, түүнд нөлөөлөх, сургуулийн хөтөлбөрийн агуулга, багш нарын ажилдаа хандах хандлагыг өөрчлөх хандлагыг агуулсан соёл, урлагийн бүтээлүүдийг дэмжих, хөгжүүлэх, түүнийг насны, нийгмийн тодорхой бүлгүүдэд чиглүүлэх олон нийтэд түгээх бодлого хэрэгтэй байна. Эмэгтэйчүүдийн утга зохиолыг жинхэнэ ёсоор хөгжүүлэх нь нийгмийн төдийгүй монгол эмэгтэйчүүдийн сэтгэлгээний соёл, боловсролд асар их түлхэц болох юм.

Залуус, хүүхдүүдэд зөв үнэлэмж төлөвшүүлэх ажлыг гэр бүл, сургууль, их дээд сургууль болон хүүхэд залуустай ажилладаг бусад байгууллагаар дамжуулан хэрэгжүүлж болох юм. Үүний тулд хүмүүстэй ажилладаг бүх л ажил мэргэжлийн хүмүүсийн дунд сургалт, курс, уулзалт, ярилцлага зэргийг явуулах замаар дэмжиж, өдөөж болох юм. Энэ бүхнийг олон нийттэй ажиллах бүх л чиглэлийн ажилтай хослуулан агуулгад нь оруулж болох төдийгүй шаардлагатай байна.

Хүн амын тодорхой хэсгүүдэд, жишээлбэл хөдөөгийн, ялангуяа зах хязгаар нутгийн эмэгтэйчүүдэд, эмзэг бүлгийнхэнд, түүний дотор хөдөөнөөс шилжин ирэгсдэд чиглэсэн, нийгэм соёлын шилжилтэд дасан зохицоход нь тусалж дэмжих, мэдээлэл хүргэх бодлогыг эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагууд санаачлан боловсруулж хэрэгжүүлэх, үүндээ төр засгийн болон, донор байгууллагуудын оролцоог хангах нь тэгш бус байдал, ялгаварлан гадуурхал, хүчирхийллийг багасгах нэг алхам байж болох юм.

ЖЕНДЭРИЙН ТЭГШ ЭРХИЙН ОНОЛЫН АСУУДАЛ БА, МОНГОЛЫН СОЁЛ УЛАМЖЛАЛ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БОДЛОГОД НӨЛӨӨЛЖ БАЙГАА НЬ

*Б.Тогтохбаяр,
МУИС-ийн сэтгүүл зүйн
докторант, жендэр судлаач*

НЭГ АЛХАМ УРАГШ , ХОЁР АЛХАМ ХОЙШ

Манай өнөөгийн тогтмол хэвлэлүүдийн нийтлэлийн бодлогод жендэрийн тэгш байдал зохистой хэмжээгээр хангагдаж чадахгүй байгаа нь бидний сэтгэлгээний хөгжил нэг алхам урагш, хоёр алхам хойш ухарч байна гэсэн дүгнэлт хийхэд хүргэлээ. Нийт өдөр тутмын болон 7, 10 хоног тутмын сонинуудын мэдээ, мэдээллийн баатруудыг хүйснийх нь хувьд судлан үзэхэд дунджаар эрэгтэйчүүд 80%, эмэгтэйчүүд 20%-ийг эзэлж байна.

Хэвлэл мэдээлэл дэх эмэгтэйчүүдийн дүр төрх. Олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн дундаас хамгийн олон захиалагч уншигчтай 7, 10 хоног тутмын “Сэрүүлэг”, “Хүмүүс” зэрэг томоохон сонинуудыг судалгаандаа сонгон авсан юм. Учир нь Монголын хэвлэлийн хүрээлэнгийн жил бүрийн мониторингын судалгаанаас үзэхэд:

Өдөр тутмын сонин	7 -10 хоног тутмын сонин
1999 онд 37500-41160	68000-81000
2000 онд 36435-44800	88000-105000

гэх мэтчилэн хэвлэгддэг хувь ширхгээрээ асар их зөрүүтэй байгаа нь өдөр тутмын сонинуудаас захиалга, борлуулалтын тоо, уншигч, олон нийтэд үзүүлэх нөлөөгөөрөө илүү хүчтэй байхад нөлөөлдөг.

Манай томоохон 7, 10 хоног тутмын сонины нийтлэлийн бодлогод дүн шинжилгээ хийж үзэхэд нийт мэдээ, мэдээллийн баатрууд нь хүйсийн хувьд дээр дурдсанаар эрэгтэй 80, эмэгтэй 20 орчим хувийг эзэлж, байгаагийн дотор 62% нь улстөрч эрэгтэйчүүд, 12.6 орчим% нь дуучин, бөх, тамирчин зэрэг урлаг спортын эрэгтэй одод, 5.1% нь бусад ажил мэргэжлийн эрэгтэйчүүд байна. Сонины нийтлэлийн бодлогод арай ядан тусгагдаж буй эмэгтэйчүүдийн дөнгөж 0.3% нь улстөрч, удирдагч эмэгтэйчүүд, 4.3% нь мисс, загвар өмсөгчид, 6% нь дуучин, жүжигчин,

гоо сайханч зэрэг урлаг соёлын хүрээнийхэн, 2.5% нь хэн нэгэн алдартны гэргий, 2.1% бусад салбарын эмэгтэйчүүд, 4.8% алдартай болон жирийн эмэгтэйчүүдийн талаарх сөрөг буюу, хүйснийх нь хувьд ямар нэгэн хэлбэрээр ялгаварлан гадуурхсан агуулгатай мэдээ, мэдээлэл байлаа.

Азидаа өндөр боловсролтой, нийгмийн идэвхтэй гэгддэг манай эмэгтэйчүүдийн хэвлэл мэдээллийн толинд тусч буй дүр төрх нийгмийн амьдралд идэвх муутай, голдуу мисс, загвар өмсөгч, дуучин, жүжигчин гэх мэтийн урлаг соёлын цөөхөн мэргэжлийг хамарсан, шийдвэр гаргах эрх мэдэл багатай, нийгмийн хөгжилд шууд хувь нэмэр оруулагч, баялгийг бүтээгч бус бүлэг давхаргынхан мэт үзэгдэхээр байгаа нь дэндүү өрөөсгөл, шударга бус байдал юм.

Харин хэвлэлийн баатар эрэгтэйчүүд нь улстөрчид, удирдагчид, эрдэмтэн, зохиолч, бизнесмен, бөхчүүд зэрэг нийгэмд хамгийн их идэвх, нөлөөтэй, баялаг бүтээгч, эзэмшигч бүлгийнхэн байна. Мөн хэвлэлд эмэгтэйчүүдийн талаар нийтлэгдэж байгаа мэдээллийн 30 гаруй хувьд нь тэднийг зөвхөн хүйснийх нь хувьд ялгаварлан гадуурхсан өнгө аястай үг хэллэг, санааг хэрэглэж хүний эрхийг бүдүүлгээр зөрчсөөр байна. Ялангуяа эмэгтэйчүүдийн дундаас нийгмийн амьдралд хамгийн идэвхтэй оролцдог хэсэг буюу улстөрч эмэгтэйчүүдийн талаарх мэдээллийн 70 гаруй хувийг сөрөг мэдээ эзэлдэг.

Тухайлбал “Сэрүүлэг” сонины 2006 оны №19-р дугаарт ганцхан эмэгтэй улстөрчийн тухай мэдээ нийтэлсэн нь “УИХ-ын гишүүн Б.Мөнхтуяа. Түүний талаар “Гологдсон хүүхэн Мөнхтуяа” гэсэн гарчигтайгаар “...Ам нээнгүүт жендэрийн асуудлаа ярьж, юун Отгонсайханыг дэмжих манатай, ИЗН-ийн Базар хүүхнийг дэмжсэн хэрэг болно. Тэр Мөнхтуяагаар яахав. Эсгий хийх газар юу хэрэггүй гэгч болно” гэж ад үзээд орхижээ” гэж илт хүйснийх нь хувьд ялгаварлан гадуурхсан өнгөөр бичжээ.

Мөн тус сонины дараагийн дугаарт “Эмэгтэй хүний үндсэн байрлал” гэсэн гарчигтайгаар УИХ-ын гишүүн Д.Арвиныг цэргийн албанд байхдаа “хэвтээд” командыг буруу ойлгоод эмэгтэй хүний үндсэн байрлалаар дээшээ хараад хэвтчихдэг байсан гэх мэтээр сексийн талаас нь эмэгтэй хүнийг дайрч доромжилсон мэдээ нийтэлсэн байна.

ЭНЭ БҮХНИЙ УЧИР ШАЛТГААН ЮУ ВЭ?

Юуны өмнө онолын уг сурвалжаас учир шалтгааныг эрэх нь зүйтэй юм.

Феминист философичид эмэгтэй хүний шоовдорлогдмол байдлыг тайлбарлахдаа эрэгтэйчүүдийн үзэмжээр хэдэн мянган жилийн туршид бүтээгдсэн нийгэм соёлын тогтолцоонд эмэгтэй хүн өөрөө “ондоон” байдаг.

Ялангуяа төрөх үүрэг гүйцэтгэдэггүй тийм хүйстэн буюу эрэгтэйчүүдэд л байдаг “хүчирхэг, эр бярттай, бие даасан, хараат бус” чанаруудыг

жинхэнэ хүний дээд чанар гэсэн үнэлэмж нийгэмд тогтсон байдаг. Гэтэл эмэгтэй хүний эмзэг, мэдрэмтгий, хараат, өрөвч, энэрэнгүй чанарыг хүний чанар гэж үнэлдэггүй. Энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр эмэгтэй хүний дүр төрхийг сөрөг талаас нь тусгах үзэл баримтлалын үндэс суурь болдог нь манай хэвлэл мэдээллийн нийтлэлийн бодлогод нөлөөлсөөр байна.

Нөгөө талаас бидний урьд амьдарч байсан социалист нийгмийн үнэт зүйлс сүйрэн унахад үндэсний үзэл, уламжлалт зан заншил, шашны зан үйл зэрэг хуучин нийгмийн үнэт зүйлс багагүй хэмжээгээр байрыг нь эзлэн сэргэж байна. Аль ч үндэсний уламжлал патриархал шинжтэй байдаг. Ийнхүү ардчиллын үнэт зүйлс болсон үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй зэрэгцэн нийгмийн сэтгэл зүйд уламжлалт патриархал үзэл сэргэсэн нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийтлэлийн бодлогод тодорхой хэмжээгээр нөлөөлж буйг “нэг алхам урагш, хоёр алхам хойш” гэж нэрлэхэд хүрээд байгаа юм. Байдал ийм байхад зөвхөн өнгөрсөн хоёр жилийн хугацаанд эрс нэмэгдэж буй эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах үзлийн эсрэг “Ардын эрх” сонины тоймч А.Алтантуяагийн бичсэнээс өөр нийтлэл бараг гарсангүй. Өөрөөр хэлбэл эмэгтэйчүүд дийлэнх болсон сэтгүүлчид эмэгтэйчүүдийн эрхийн төлөө үзгээ хөдөлгөсөнгүй. Ядаж нийгмийн сөрөг үзэгдлийг илрүүлэх, шүүмжлэх жам ёсны үүрэг нь ч сэтгүүлчдийг энэ сэдвээр дуугаргасангүй.

Монголын хувьд Азийн орнууд дотор соёл уламжлалын хувьд эмэгтэйчүүдэд харьцангуй ээлтэй гэж өөрсдөө үзсээр ирсэн. Гэвч өнөөг хүртэл хадгалагдаж ирсэн соёл уламжлалын бүхий л хүрээнд эмэгтэйчүүдийг төрөл бүрээр ялгаварласан хандлагуудын нэлээд хувь нь одоо хүртэл хүмүүсийн ухамсар сэтгэхүйд хадгалагдсаар байна.

Тухайлбал:

- **Гэр бүлийн харилцаанд** /Хог асгах, гэрийн ажил хийвэл эр хүний хийморь гутдаг. Эрэгтэй хүүхэд гал голомтоо залгамжилдаг, Эмэгтэй хүн цагаан зээр хоёр нутаггүй, Адгийн тэнэг авгайгаа магтдаг, Аваагүй байхад авгай сайхан, алаагүй байхад үнэг сайхан/
- **Төрийг үзэх үзэл** /Төрийн хар хүн гэх мэтээр төрийн талаарх үзэл хандлага эр хүйстэнд хамаардаг/
- **Шашны зан үйлд** /Эмэгтэй хүн гарахыг хориглодог уул, овоо, эм хүн шулмын язгууртай гэхчлэн уламжлалт ойлголтууд/
- **Соёлын уламжлалд** /Эрийн гурван наадамд дан эрэгтэйчүүд оролцдог байсан, үндэсний бөхийн дэвжээнд эмэгтэй хүн гарахыг хориглодог/
- Ардын аман зохиол, зүйр цэцэн үгэнд /Эм хүний үс урт ухаан богино
Янтгар хатан зарга шүүдэггүй
Ямаан толгой ямбанд ордоггүй
Тэмээн толгой ямбанд ордоггүй
Тэнтгэр хатан зарга шүүдэггүй

Эр муу ч эмийн дээр
Эмээл муу ч морин дээр /

Энэ үзэл хандлага нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийтлэлийн бодлогод нөлөөлсөөр байгаа нь эмэгтэйчүүдийн талаарх хэвшмэл ойлголт /стереотип/ олон нийтийн сэтгэхүйд амь бөхтэй хадгалагдахад нөлөөлж байна.

Өнөөдрийн манай хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийтлэлийн бодлогод жендерийн талаас нь ажиглалт хийж үзэхэд дараах чиглэлээр эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан агуулгатай мэдээ, мэдээлэл илүү давамгайлж байна.

Тухайлбал:

1. Үндэсний уламжлалт үнэлэмж
2. Шашны зан үйл
3. Ёс заншил
4. Сексийн зугаацуулагч/объект/

Жишээ татъя.

1. Үндэсний уламжлалт үнэлэмж

Эртнээс нүүдэлчин ахуйн хэлбэрээр амьдарч ирсэн монголчуудын уламжлалт үнэлэмж ёсоор үндэсний бөхийг дээдэлдэг сэтгэлгээ. Энэ хандлагад суурилан үндэсний бөхийн сэдэвт мэдээ, мэдээлэлд эмэгтэйчүүдийг хүйснийх нь хувьд ялгаварлан гадуурхсан өнгө аяс, хандлага багагүй агуулж байна.

Тухайлбал Бөхчүүд үндэсний хувцас сурталчилсан шоуг сурвалжлахдаа “Монгол бөхийн ариун дагшин дэвжээн дээгүүр эмс, охид гүйлгэж бузарлав”, Сумогийн нэгэн башёд Асашёорюү Дагвадорж амжилт муутай барилдсан нэгэн удаагийн тохиолдлыг тайлбарлахдаа “Их аварга уртын дуучин С.Цогтсайханд дэмбээдэж хожигдсоноос хийморь лундаа нь гутжээ” гэхчлэн бичсэн нь үндэсний уламжлалт үзэл хандлагын илрэл юм.

2. Шашны зан үйл

Сүүлийн жилүүдэд уламжлалт буддын шашин, болон хязгаарлагдмал хүрээнд бөө мөргөл сэргэж, бусад шашин ч эрчимтэйгээр дэлгэрч байна. Ялангуяа манай уламжлалт шашны зарим зан үйл, сургаалд эмэгтэй хүнийг ялгаварлан гадуурхсан элемент байдаг нь сэргэж, түүнийг нь ОНМХ шүүрч аван сурталчлах боллоо.

Жишээлбэл: 2001 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр АН-аас нэр дэвшигч Р.Гончигдоржийн сурталчилгааны штабаас тараасан мэдээлэлд тэргүүн хатагтай “О.Оюунбилэгийг эмэгтэй хүн гардаггүй Отгонтэнгэр уулын овооны тахилгад оролцсоноос болж лус догшрон улс орон даяар зуд нүүрлэлээ” гэсэн утгатай суртал ухуулгын мэдээллийг удаа дараа тарааж хүний эрхийн ноцтой зөрчил гаргаж байв.

Мөн “Хүмүүс” сонины өнгөрсөн оны нэгэн дугаарт хийлч Дэлгэцэцэгийн бурхны ном судар дээр нүшгэн сууж клип хийлгэсэн нүглийг цайруулах гэж Гандантэгчилэн хийдийн лам нар 2 шөнө дараалан ном хурав” гэсэн мэдээ нийтлэгджээ.

Энэ мэтээр томоохон сонинууд, улс төрийн нам хүчин хүртэл санаатай болон санамсаргүй байдлаар шашны зан үйлийн зарим элементийг ашиглан эмэгтэйчүүдийг хүйснийх нь хувьд дорд үзсэн гадуурхсан өнгө аястай, шууд утгатай мэдээ, мэдээлэл түгээсээр байна.

3. Ёс заншил

Эрэгтэй хүүхэд голомт залгадаг, охин хүүхэд хүний хүн болдог, эмэгтэй хүн нөхрөө даган хүний хүн болдог, эр муу ч эмийн дээр, эмээл муу ч морин дээр гэх мэт монголын уламжлалт зан заншилд үндэслэн эмэгтэйчүүд, охидыг ялгаварласан, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэгт хохирогч эмэгтэйг буруутгасан агуулгатай мэдээ цөөнгүй цацагддаг.

Үндэсний уламжлал сэргэж эхэлснээр шашны зан үйл дэх эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан заншлууд хүчтэй сэргэж, төр үүнийг зохицуулах бус харин ч Бурхан халдун уулыг төрийн тахилгатай болгох шийдвэр гаргаж, улмаар энэхүү тахилгыг сурвалжлах эрэгтэй сэтгүүлч томилохыг хүссэн албан бичиг ОНМХ-үүдэд явуулах зэргээр төр өөрөө эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан зан үйлд оролцох боллоо.

Мөн тухайн сэтгүүлч ярилцлагын үеэр тавьсан асуулт, эх бичвэртээ “Адгийн тэнэг авгайгаа магтдаг”, “Эмэгтэй хүн цагаан зээр хоёр нутаггүй” гэх мэтийн хэвшмэл ойлголтуудыг дэвэргэн хэрэглэх нь багасахгүй байна.

Энэ онд гарсан гэр бүлийн хүчирхийллийн нэгэн гэмт хэргийг 7 хоног тутмын нэг сонинд хэрхэн мэдээлсэн талаар жишээ татъя. “Агармоош” компанийн захирал салсан эхнэрээ хамт байсан хүнтэй нь гэрээс нь авч яваад хээр аваачиж зодож хөнөөгөөд машинтайгаа шатаасан гэр бүлийн хүчирхийллийн ноцтой гэмт хэрэг гарсан. Энэ хэргийн талаар манай нэгэн 7 хоног тутмын томоохон сонин мэдээлэхдээ эхлээд хохирогч бүсгүйг нууц амрагтайгаа байхыг нь хараад нөхөр нь зодож алсан. Хохирогч олон хүнтэй бэлгийн харилцаанд ордог, хөнгөмсөг, хоёр хүүхдээ эргэдэггүй муу эх байсан. Харин сэжигтэн /нөхөр нь/ уур уцааргүй, маш сайн хүн, эхнэртэйгээ эргэж гэрлэх хүсэлтэй байсан мэтээр мэдээлсэн.

Гэтэл хэргийн талаарх олон мэдээлэл илэрхий болж бүсгүй урьд нь нөхөртөө удаа дараа хэвтэрт ортлоо зодуулж, түүний дарамтнаас болж ажлаасаа гарсан, хоёр хүүхдийг нь хадмууд нь авсан байсан зэрэг нь өөр сонинд гармагц нөгөө сониныхон хохирогчийг буруутгасан тактикаа засварлан “тэр залуу /сэжигтэн нөхөр нь/ эхнэрээ салсан ч гэсэн өөр хүнтэй хамт байхыг нь хараад тэвчээгүй. Ер нь би ч эхнэрээ өөр хүнтэй хамт байж байхыг харах юм бол яг тийм юм хийх байсан гэж ярих эрчүүд олон

байна” хэмээн гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг илт буруутган хүчирхийлэгчийг зөвтгөн дөвийлгөсөн байр суурь баримталсаар байсан нь эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан нийтлэлийн ноцтой жишээ юм.

4. Сексийн зугаацуулагч.

Ер нь долоо, 10 хоног тутмын сонинуудын нийтлэлийн бодлогыг ажиглахад тэнд эмэгтэй хүнийг баялгийг бүтээгч, бодлого боловсруулах чадвартай хүн гэсэн талаас сурталчлахаас нь илүү эрэгтэйчүүдийн сексийн зугаацуулагч гэсэн 2-дагч талаас нь дүрслэн мэдээлж байна. Ийм төрлийн сонинууд нэгдүгээр нүүртээ загвар өмсөгч, мисс, жүжигчин, дуучин бүсгүйчүүдийн хувийн амьдралыг сексийн талаас нь хөндсөн мэдээг фото зурагтай нь, сүржин гарчигтайгаар нийтлэх, томоохон бизнесмен, улс төрчид, бөхчүүд сайхан хүүхнээр гоёдог гэхчлэн бичих нь хэмээс хэтэрлээ. Жендэр судлалд “Гоо сайхны домог” гэсэн нэг ойлголт байдаг. Эртнээс эмэгтэй хүн бодож сэтгэгч амьтан биш зөвхөн гоо сайхан байх ёстой, харин эр хүн тэр гоо сайхан эмэгтэйг эзэмдэх ёстой гэсэн энэ домог хүн төрөлхтний сэтгэлгээнд оршсоор ирснийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өөгшүүлэн эмэгтэй хүнийг сексийн зугаацуулагч мэтээр бичих нь хүйсээр ялгаварлан гадуурхалтын хортой хэлбэр юм.

Өнөөгийн энэ ОНМХ дэх эмэгтэйчүүдийг янз бүрээр ялгаварлан гадуурхаж буй илрэлүүдийг ардчиллын эхэн үетэй харьцуулахад 2 дахин нэмэгдсэн нь ажиглагддаг. Энэ шалтгаанаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр эмэгтэйчүүдийг дорд үзэх, ялгаварлах хандлага 1990-ээд оныхоос нэмэгдэж байгаад хүний эрхийн болон эмэгтэйчүүдийн байгууллагууд анхаарал хандуулж ямар нэгэн алхам хийх цаг болжээ.

Ер нь эмэгтэйчүүдийн тэгш бус байдал нь зан заншил, түүх, соёл, шашны үзэл номлолд гүнзгий ул мөрөө үлдээсэн байдаг.

ОНМХ ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮД

Дээр дурдсан олон шалтгаанаар манай хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийтлэлийн бодлогод жендерийн тэгш байдал зохистой хэмжээгээр хангагдахгүй байгаагаас хэвлэл мэдээллээр дүрслэгдэж буй баатар нь цэвэр патриархал шинжтэй эрэгтэйчүүд байна.

Харин эмэгтэй нь:

- Орлогыг хүртэгч, тэжээлгэгч
- Туслагч
- Дагалдагч
- Хүчирхийлэлд өртөгч
- Хүчин мөхөс

- Гоо үзэсгэлэнтэй
- Үр хүүхэд тээж, төрүүлэгч
- Өсгөн бойжуулагч

Эмэгтэйчүүдийн талаарх зарим сөрөг, ялгаварлан гадуурхсан нийтлэлүүдийн гарчгаас жишээ татъя.

“Дуучин Гэрэлмаа 15 дүү амрагтаа хаягдахгүйн тулд тураах эм ууж хоол идэхгүй байсаар бүр 20 кг түрж ухаан алддаг өвчтэй болов”

УИХ-ын гишүүн Ц.Батаа Хятадын эртний нийслэл рүү мисс Халиунаа, загвар өмсөгч Баяраа нарыг хятад дарга нарын үйлчилгээнд өндөр үнэ амлан авч явжээ

Мөнхдур/Б.Мөнхтуяа/ Арвин гишүүний өрөөсөн дугуй юм аа

Дуучин Алтаа Японд айлын найран дээр дайрч ороод нутгийн атамануудтай нийлж 50 мянгаар билетээ шахжээ

Мисс Хонгорзул озэки Даваажаргалд хайр сэтгэлээ илчлэн захидал илгээх болжээ

Дуучин Дэлгэрмаа оюутан залууг өөд татан дэр нэгтгэх гэж байна

Хэвлэл мэдээллийн нийтлэлийн бодлого дахь жендерийн тэнцвэргүй байдлын үр дагавар.

Ийнхүү хэвлэл мэдээллийн нийтлэлийн бодлогын жендерийн тэнцвэргүй байдал нь олон нийтийн ухамсарт сөрөг нөлөө үзүүлж, эмэгтэйчүүдийн талаарх хэдэн мянган жилийн уламжлалтай хэвшмэл ойлголтыг үргэлжлүүлсээр байдаг.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийгмийн үүрэг буюу олон нийтийн санаа бодлыг бүрэлдүүлэх явдал юм. АНУ-ын Висконсиний их сургуулийн доктор Жанет Хайтын тэмдэглэснээр “Эрэгтэй, эмэгтэй хүмүүс биологийн хувьд зарим ялгаатай, харин оюуны чадвараар ялгаатай эсэх нь нэг ч судалгаагаар нотлогдоогүй. Гэтэл оюун ухааны чадвараар эрэгтэй нь эмэгтэйгээсээ илүү гэсэн уламжлалт ойлголтыг дэврээсээр байгаагийн гол буруутан нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл” ажээ.

Яах вэ? Өнөөдрийн манай хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд ажиллагсдын дийлэнх хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Энэ нь эмэгтэйчүүдийг хэвлэлд төдийлөн бичихгүй эрэгтэйчүүдийг илүүд үзэх буюу “үл хайхрах”, эсвэл ядгаварлан гадуурхах шалтгаан болсоор байгаа юм. Патриарх дүр төсөөллөөр хүмүүжсэн эмэгтэйчүүд эмэгтэйчүүдийнхээ талаар сөрөг сэтгэгдэлтэй байдаг нь батлагдсан зүйл. Тиймээс сэтгүүлч бэлтгэдэг дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт жендэрийн хичээл нэмж оруулах, сэтгүүлчдийн жендэрийн мэдрэмжийг дээшлүүлэх, хүний эрхийн

сэдвээр чадавхжуулах шаардлагатай байна. Тэгэхгүй бол бид урагшаа нэг, хойшоо хоёр алхсаар байх болно.

Эмэгтэйчүүдийг баялгийг бүтээгч, бодлого тодорхойлогч байх чадваргүй, харин хүчирхэг, хөрөнгөлөг эр хүний нөмөр нөөлөг дор тэжээн тэтгүүлэгч дагавар маягаар амьдрах жамтай мэтээр мэдээлж, сурталчилж байгаа нь нийгэм дэх эрэгтэй, эмэгтэй аль ч хүйсийн хүмүүст сөрөг нөлөө үзүүлдэг. Өрх гэрээс, нийгмийн сэтгэлгээнд хүртэл нэвчсэн энэ үзэл хандлага нь залуу охидыг бие даан амьдралд хөлөө олох итгэлийг нь сулруулж, залуу эрэгтэй хүмүүсийг сэтгэл зүйн хувьд эдийн загийн хүчтэй дарамтанд оруулах зэрэг асар их сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй юм.

Америкийн жендер судлаач Антони Кортесын дүгнэж байгаагаар реклам, сурталчилгаа сэтгүүлүүд дэх эмэгтэй хүний нийтлэг дүр нь гоо үзэсгэлэн төгс, цэл залуу, секс дүр төрхтэй байдаг. Энэ нь эмэгтэйчүүдийг гадаад төрх, бие галбиртаа сэтгэл дундуур байх, өөртөө итгэх итгэл нь буурахад ноцтой нөлөө үзүүлдэг байна. Мөн хүүхдүүд бага байхаасаа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ажил үүргийн хуваарийн талаар эмэгтэй нь гэр орны ажил хийж, эрэгтэй хүнд туслах, эрэгтэй нь бүхнийг манлайлагч байх ёстой гэсэн ойлголтыг ном сэтгүүл, рекламаас тусгаж авдаг болохыг нь судалгаагаар тогтоосон байна.

Энэ бүхнээс үндэслэн дүгнэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийтлэлийн бодлогод жендерийн тэнцвэртэй байдал алдагдах нь нийгмийн сэтгэхүйд асар их сөрөг нөлөө үзүүлдэг байна.

АМЬДРАХ ЭРХГҮЙ ХҮМҮҮС: МОНГОЛЫН АРДЧИЛАЛ, ХӨГЖЛИЙН ЯВЦ ДАХЬ ЛЕСБИҮН, ГЕЙ, БИСЕКСУАЛ, ТРАНСЖЕНДЭР (ЛГБТ) ХҮМҮҮСИЙН ХҮНИЙ ЭРХ¹

Н.Анараа

Хуулийн магистр, Япон улсын Киушугийн Их Сургууль, Монголын Лесбиян Олон Нийт, Мэдээллийн Төвийн санаачлагч, зохицуулагч

“Бэлгийн чиг баримжаа нь хүйс болон арьсны өнгөтэй адил хүний мөн чанарын үндсэн зүйлийн нэг мөн. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын эхний өгүүлбэрт бататгасанчлан хүний эрх нь хүний төрөлхийн сүр жавхаа, хүн гэдэг зүйлийн үнэт байдлыг хүндэтгэх үзэлд суурилсан байдаг. ...Бэлгийн чиг баримжаа нь зүрх сэтгэлийн нэн нарийн асуудал, оюун ухааны хамгийн нандин хүсэл эрмэлзэл, бие махбодийн дээд зэргийн илэрхийлэлтэй холбоотой байдаг учир хүний бие махбодь, сэтгэхүйн мөн чанарын хувьд эдлэх ёстой салшгүй эрх юм. Энэ эрх нь айдас хүйдэс, ялгаварлан гадуурхалтад өртөхгүйгээр эрх тэгш байдлын зарчим дээр өөрийн бэлгийн чиг баримжааг тодорхойлох, түүнийгээ илэрхийлэх эрхийг дотроо агуулна.”

Amnesty International, Crimes of Hate, Conspiracy of Silence (2001), хуудас 7.

“Юун түрүүнд миний анд найз, миний эгч, өөртөө болон бусдадаа харахыг хүсдэг өөрчлөлтийн толь болсон Вебдайкадаа баярлаж явдгаа хэлмээр байна. Сэтгэлийн халуун дэмжлэгт чинь би баярладаг. Бүх дэлхийн ЛГБТ ахан дүүстээ болон тэдний гэр бүлийнхэн, найз нөхдөд баярлалаа. Нэгэн өдөр ийм том боломж надад олдоно хэмээн би бодож ч байсангүй. Би ээжийнхээ хамгийн энхрий үр, багш нарынхаа хамгийн онцгой сайн шавь, багийнхаа шилдэг менежер ч хэрэв тэд намайг мэдэх л юм бол энэ болгон өөрчлөгдөнө. Ээж минь л намайг мэдсэн ч намайг үгүйсгэж, надаас хөндийрөөгүй. Жаахан байхдаа би охидтой тоглодог байхад

¹ Зохиогч 2006 оны 7 сарын 26-29-ний өдрүүдэд Канад улсын Монтреаль хотод болсон Олон Улсын ЛГБТ Хүний Эрхийн Хуралд энэ нийтлэлийнхээ англи хэл дээрх хувилбараар илтгэл тавьсан ба англи хэл дээрх хувилбар Австраль Улсын Цагаачлалын Асуудал Шийдэх Трибуналын (Australian Refugee Review Tribunal) номын санд 2006 оны 8 сараас хадгалагдаж байгаа.

Зохиогчийн цахим шуудан: anaraanyamdorj@hotmail.com

сэтгэлийг минь шархлуулсан анхны зүйл буюу хүмүүс намайг охидтой тоглодог охин ч биш, хүү ч биш, манин гэж дооглож эхэлснийг би сонссон. Одоо эхний минь цөхрөл бага багаар арилсан ч түүнээс илүү өөрийнхөө амьдралын төлөө, өөртэй минь адил хүмүүс Монголд байгаа эсэх талаар, цаашлаад бэлгийнхээ чиг баримжаанаас үүдэн шударга бус зүйлийн золиос болбол намайг болон ЛГБТ хүмүүсийг хууль хамгаалахгүй талаар шаналдаг болж. Бидний амьдарч [иргэнийхээ үүргийг биелүүлж], энэ орны иргэн болж төрснийхөө эрхийг эдлэх ёстой энэ л нийгэм, үзэн ядалт биш хайраар амьдрах ёстой энэ л хүмүүс биднийг бага багаар алж байна. Энэ л нийгэмд бидний дунд ямар олон хүн чимээгүйгээр уйлан хайлж байгаа билээ, эрх чөлөөт хүн болж төрснөөрөө хүн шиг л амьдрахыг хүссэн биднийг хэрхэн зодож хүчирхийлэн, хүн бусаар харгислаж байгаа билээ, ямар олон хүүхэд үзэн ядалтаар тэжээгдэн өсч байгаа билээ, тэдний хэд нь үзэн ядалтаа шингэн дахин үзэн ядалтыг бий болгох билээ, энэ л нийгэмд амьдарч буй бидний хэд нь өөрсдийнхөө амийг егүүтгэсэн билээ, хэд нь хүмүүсийн гарт алуулсан билээ, хэд нь архичин болсон билээ? Дэндүү олон, хэлэхэд хэцүү. Монголын ижил хүйстэн хүмүүст та бүгдийн дэмжлэг, сэтгэл зүрх чинь хэрэгтэй байна. Бид өөрсдийнхөө орон зайны төлөө тэмцсээр, бид уйлсаар, бид итгэж найдаж, залбирсаар. Үүнийг унших эрхэм та ахан дүүсээ ийм байдлаар амьдарсан хэвээр байгаасай гэж хүсээгүй л бол, хэрэв бидэнтэй л адил мөрөөдөж, сайн сайханд итгэж найддаг л бол биднийг байгаагаараа амьдрах эрхэд маань нэмэрлэж дуу хоолойгоо өргөөрэй. Бурхан биднийг өршөөг."

П., 2006 оны 6 сарын 13-ны өдөр

www.mongoldyke.org.mn дээр

(П. бэлгийн чиг баримжаанаасаа үүдэн олон удаа ижил хүйстнийг үзэн ядагч хүмүүст зодуулсны улмаас эх нутгаасаа дайжин 2004 оны 9 сард Монголоос гарсан ба түүнийг хамгийн сүүлд зодсон хүн нь түүний нагац ах байсан юм. Одоо тэрээр партнёртойгоо Тайландад амьдардаг)

НИЙГМИЙН ХӨГЖИЛ ДЭХ ЛГБТ ХҮМҮҮСИЙН ХҮНИЙ ЭРХИЙН ХАМААРАЛ

Нийгмийн хөгжлийг авч үзэхэд Лесбиян, Гей, Бисексуал, Трансжендэр (ЛГБТ) хүмүүсийн хүний эрхийн асуудал ямар хамааралтай вэ, энэ сэдэвт хамаатуулах ямар эрх зүйн үндэслэл байна вэ? Хөгжлийн асуудалд нийгмийн гадуурхагдсан нэгэн бүлгийн хүний эрх ямар байдлаар багтах вэ? Миний дэвшүүлж буй санаа нь ЛГБТ хүний эрх бол нийгмийн хөгжлийн

нэгэн салшгүй хэсэг мөн ба нийгмийн хөрөнгө (social capital)-ийг тэр орны бүх иргэд бий болгодог учир түүхэн, эсвэл шашин номлолын, эсвэл нийгмийн хандлагын, эсвэл үзэл суртлын үндэслэлээр, эсвэл эдгээр дурьдсан бүх үндэслэлийн хослолоос үүдэн нийгмийн нэг бүлгийн нийгмийн хөрөнгөд эерэгээр нэмэрлэх эрх нь хаагдмал байвал иргэний нийгмийн нэгдмэл байдал ба иргэний нийгмийн хамтын үйл явцаас үүсдэг нийгмийн хөрөнгийг бий болгох бүхэл явцад сөргөөр, цаашлаад нийгмийн хөгжилд сөргөөр нөлөөлнө гэсэн санаа юм. Нийгмийн хөрөнгийн олныг хамрах байдал болон түүнээс ангид байхад үүсэх сөрөг үр дүнгийн талаар олон судлаачид бичсэн тұл² энд нурших хэрэггүй болов уу.

Түүнчлэн ЛГБТ хүмүүсийн хүний эрхийн хамаарлыг дүгнэн шинжлэхэд хүний эрхэд суурилсан хөгжлийн онол онц хамааралтай. Нийгмийн хөгжлийн судалгаанд жендэрийг нэгэн том судлагдахуун болгосонтой адил ЛГБТ хүмүүсийн нийгмийн хөгжилд оруулсан ба оруулах хувь нэмэр, ЛГБТ хүмүүс нийгмийн хөрөнгийг бий болгох явцад бүрэн хамрагдаагүйгээс үүсэх сөрөг үр дүнгийн талаар нийгмийн хөгжлийн судалгаанд авч үзэх цаг Монголд иржээ.

Барууны орнуудад ЛГБТ хүмүүс иргэний эрх, эрх чөлөөний хөдөлгөөнүүдийн хөгжил цэцэглэлтэд эерэгээр хувь нэмрээ оруулсан баримт олон бий³ ч бусад оронд нөхцөл байдал өөр байна. ЛГБТ хүмүүсийг ад чөтгөр, хүн бүс мэт үзэж, хууль ёсны орон зайг нь үгүйсгэсэн хэтэронорматив буюу албадмал эсрэг хүйсийн бэлгийн чиг баримжааны үзэл суртлын хэмжээнд ноёрхмол байдлыг Барууны ЛГБТ эрхийн хөдөлгөөн өөрчилсөн шиг дэлхийн ЛГБТ хүмүүсийн 80 орчим хувь нь оршин суудаг хөгжиж буй орнуудад байдал өөрчлөгдөөгүй хэвээр⁴. Хөгжиж буй орнуудын хувьд ЛГБТ эрхийн асуудал нэн хамааралтайг өөр нэгэн үзлээр баталгаажуулья гэвэл өөрөө өөрийгөө бүрэн нээж амьдрах эрх нь либерал хөгжингүй нийгмийн бүтэцтэй салшгүй шууд хамааралтай хэмээсэн Ж.С.Милзын онолыг санах хэрэгтэй.

² McGhee, Derek (2005) "Hidden Targets, Hidden Harms: Community Safety and Sexual Minority Communities" *Crime Prevention and Community Safety: An International Journal*, vol. 5, no.4; Scott, Susan D., Pringle, Alistair ба Lumsdaine, Colin (2004) *Sexual Exclusion – Homophobia and Health Inequalities: A Review*, A UK Gay Men's Health Network: London, дараахь хаягаар бий www.gaymenshealthnetwork.org.uk

³ 1960-аад онд феминист үзэл санаа хөгжихөд, хүйсийн эрх тэгш байдлыг бий болгоход эмэгтэйчүүдийн эрхийн хөдөлгөөнд ижил хүйстэн эмэгтэйчүүд маш том хувь нэмэр оруулсан нь албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Бусад бэлгийн чиг баримжааны цөөнхийн нийгмийн хөдөлгөөнд оруулсан хувь нэмрийн талаар дараахь нийтлэлүүдээс олж үзнэ үү: Sweeney, Sean (2004) "The Case for Global Justice Unionism" *New Labour Forum*, vol. 13, no. 3; Jenness, Valerie ба Broad, Kendall (1994) "Anti-violence Activism and the (In)visibility of Gender in the Gay/Lesbian and Women's Movement" *Gender and Society*, vol. 8, no. 3; Landman, Todd (1999) "Organisation and Impact: The Green Movement in Comparative Perspective", <http://www.essex.ac.uk/ECPR/events/jointsessions/paperarchive/mannheim/w21/landman.pdf>, Anzaldúa, Gloria (1981) *Borderlands/La Frontera, Spinster/Aunt Lute*: San Francisco.

⁴ Жон Скаглиотигийн *Dangerous Living: Coming Out in the Developing World* (2003) баримтат кино хөгжиж буй орнууд дахь ЛГБТ хүмүүсийн эрх хэрхэн зөрчигдсөөр байгаа талаар өгүүлсэн кино юм.

Мөн орчин үеийн Нобелийн шагналт эдийн засагч Амартья Сэн ядуурлыг чадвар дутуу, чадвар боогдмол байдал хэмээн шинэчлэн томъёолсны дагуу⁵ ЛГБТ хүмүүсийн нийгэмд бүрэн дүүрэн оролцоо оролцоо хуулиар хамгаалагдаагүй, иргэний эрхээ бүрэн эдлэх байдал нь боогдмол байгааг нэгэн төрлийн ядуурал мөн гэж тодорхойлж болохуйц байна.

Энэхүү нийтлэлд ЛГБТ хүний эрх нь дараах үндэслэлээр зарчмын хувьд, ялангуяа нийгмийн хөгжлийн хувьд хамааралтай хэмээн би баталж байна. Үүнд: нэгдүгээрт, бэлгийн чиг баримжаа нь хүний салшгүй үндсэн эрх тул хамаарал нь *норматив* юм. Хоёрдугаарт, бүх хүний эрх нь "...түгээмэл, хуваашгүй, хоорондоо салшгүй уялдаатай ба харилцан хамааралтай"⁶ учир нэг хүний эсвэл бүлэг хүмүүсийн хүний эрхийн нэг тал нь зөрчигдөж байвал тэр хүн эсвэл бүлэг хүмүүсийн бүхий л хүний эрх зөрчигдөж байна гэж үзэх тул хамаарал нь *эрх зүйн үндэслэлтэй* юм. Гуравдугаарт, ардчилал болоод сайн засаглал⁷ нь хөгжлийн явц дахь томоохон хөдөлгүүр хэмээн олон улсын олон талт хөгжлийн байгууллагууд үздэгийг харгалзан, ардчиллын зарчмын дагуу иргэн бүр үг хэлэх эрх, үзэл бодолтой байх эрх, нэгдэн нийлэх эрх болоод хамгийн чухал нь харгислалд өртөхгүй байх эрхтэйг саная. Хэрэв нийгмийн нэг бүлэг эдгээр эрхээ эдлэж чадахгүй байвал ардчилал байгаа эсэх нь эргэлзээтэй болно. Тиймээс гуравдугаар хамаарал нь *ардчилалтай холбоотой*. Дөрөвдүгээрт, нийгмийн хэтэронорматив байдлаас үүссэн албадмал үл үзэгдэх, чимээгүй байдал нь нийгмийн гадуурхагдсан бүлгийн оршиж буйг үгүйсгэж, улам чимээгүй болгох аргачлал болдог учир ЛГБТ хүмүүсийн хувьд улам бүр гадуурхалтад өртөх нөхцөл байдлыг үүсгэдэг. Энэхүү хэтэронорматив үзэлд суурилсан үгүйсгэл нь гадуурхагдсан бүлгийн нийгмийн хөрөнгөд нэмэрлэх үйл явцыг хаадаг тул ЛГБТ эрх нь *нийгмийн хөрөнгийг үүсгэх, нийгмийн хөрөнгийг хуримтлуулахад* хамааралтай.

Эдгээр зарчимд үндэслэн Монголын ардчилал ба хөгжлийн явц дахь ЛГБТ хүмүүсийн эрх болон Монголд ЛГБТ эрх хүлээн зөвшөөрөгдөөгүй байдал болон ЛГБТ эрх хүлээн зөвшөөрөгдөөгүйгээс үүсч буй сөрөг үр дүнгийн талаар энэ нийтлэлд авч үзье.

1. ЯАГААД МОНГОЛД ЛГБТ ХҮНИЙ ЭРХИЙН ОЙЛГОЛТ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Социализмыг халж гадаад ертөнцөд хилээ нээснээс хойш Монгол Улс арван зургаан жилийн нүүрийг үзэж байна. Төвлөрсөн эдийн засагт,

⁵ Sen, Amartya (1999) *Development as Freedom*, Oxford University Press: Oxford, 3-4-р бүлгүүд.

⁶ 5-р зүйл, Vienna Declaration and Programme of Action, 1993.

⁷ Олон эрдэм шинжилгээ, онолын нийтлэлүүдэд ардчилал нь бусад зүйлийн дунд түгээмэл үнэт зүйл ба бодлогын зорилт мөн гэж батласан байдаг. Gershman, Carl (2005) "Democracy as Policy Goal and Universal Value" *The Whitehead Journal of Diplomacy and International Relations*, Winter-Spring.

авторитар засаглалт социалист бүтцээс шилжих үеэс⁸ эхлэн улс оронд явагдаж эхэлсэн улс төрийн өөрчлөлт болоод улс төрийн бүтцийг ардчиллах үйл явцын⁹ хажуугаар хүний эрхийн тухай ойлголт ба хүний эрхийн талаар нухацтай ярьж эхэлсэн цаг шилжилтийн үетэй давхцдаг. Эдгээр үйл явц өрнөснөөс хойш өнөөдрийн Монгол Улс Freedom House байгууллагаас гаргадаг улс төрийн эрх, эрх чөлөө болон иргэний эрхийн индексийн аль аль үзүүлэлтээрээ 2 гэсэн үнэлгээ авч, эрх чөлөөт ардчилсан орон мөн хэмээн дүгнэгджээ¹⁰. Гэвч ЛГБТ хүмүүсийн бодит амьдралыг харвал Монгол хэр зэрэг эрх чөлөөтэй орон бэ гэх эргэлзээ, бүх иргэний эрх, эрх чөлөөг хамруулж чадсан үнэлгээ мөн үү гэсэн асуултауд гарна.

Монгол Улсын Засгийн Газар газар нутаг дээрээ монгол ЛГБТ иргэд оршин тогтнодгийг хүлээн зөвшөөрөөгүй байна. ЛГБТ хүмүүсийн талаар эрх зүйн таг чимээгүй байдал нь Монгол Улсын ямарваа хуульд ижил хүйстэн¹¹, лесбиян, гей, трансжендэр, транссексуал гэх мэт үг ороогүй байгаагаар батлагдана. 1992 он буюу Барууны ихэнх орнуудад ЛГБТ эрхийг хүлээн зөвшөөрч, ижил хүйсийн гэрлэлтийг ч хүлээн зөвшөөрч эхэлсэн үед Монголын шинээр тунхагласан үндсэн Хуульд ЛГБТ хүмүүсийн тухай болон бэлгийн чиг баримжааны улмаас ялгаварлан гадуурхахгүй хэмээх заалт оруулаагүй нь ЛГБТ хүмүүсийн иргэн бус статусыг, эсвэл ЛГБТ хүмүүсийн хоёрдогч зэргийн иргэдийн статусыг харуулж байж мэдэх. Ямартай ч төрийн чимээгүй байдал албадмал хэтэрнорматив үзлийг нийгэм ба хуульзүйн хүрээнд институтчилсан ба энэ институтчилсан хэтэрнорматив байдал нь ЛГБТ хүмүүсийн дараах цөхрөлийг үгүйсгэж байна. Үүнд:

⁸ 1990-ээд оны эхэн үеийн Монголын шилжилтийн үйл явцын талаар дараах нийтлэлүүдийг олж үзнэ үү: Nordby, Judith (1994) "Mongolia: A Centrally Planned Economy in Transition" *The China Quarterly*, no.139; Cheung, Tai Min (1991) "Mongolia: The Cure Hurts" *Far Eastern Economic Review*, vol.153, no. 38, September 19; Batbayar, Tsedendamba (2003) "Foreign Policy and Domestic Reform in Mongolia" *Central Asian Survey*, vol. 22, no.1.

⁹ Ардчилалтай холбоотой шинэчлэлийн талаар дараах нийтлэлийг үзнэ үү: Sabloff, Paula (2002) "Why Mongolia? The Political Culture of an Emerging Democracy" *Central Asian Review*, vol. 21, no.1.

¹⁰ www.freedomhouse.org-ын индексийг үзнэ үү.

¹¹ ЛГБТ хүмүүст хамааралтай монгол хэлэн дэх хэд хэдэн үг, ойлголт байдгаас хоолсон гэж түүхэн үг байдаг ба үгийн орчин үеийн хэрэглээ нь сөрөг утгыг агуулдаг. Социалист үзэл суртал Монголд орж ирснээс хойш эрүүл мэнд, сэтгэхүйн эрүүл мэндийн мэргэжлийнхэн орос хэлнээс гомосексуалист үгийг аван шууд орчуулж хэрэглэж байсан нь ижил хүйстэн болжээ. Хүмүүс ихэнхдээ ижил хүйстэнүүдийг гомосексуалистын богино хэлбэр болох гоомоо гэж үгээр дууддаг ба энэ нь бас л сөрөг утга бүхий үг юм. Лесбияны богино хэлбэр болох лесби болон гей гэдэг үгнүүд нь 1990-ээд оны эхээс Монголд Барууны телевиз хэвлэл орж ирснээс хойш нэлээн түгээмэл болсон үгс. Трансжендер байдлын тухай ойлголт Монголд ЗХУ-ын нөлөө түгэхээс өмнө байсаар ирсэн ойлголт юм. Үүний том жишээ нь жирэмсэн эмэгтэйчүүд Цагаан Сараар хоорондоо золговол ургийн хүйс солигдоно гэж үздэг байсан уламжлал одоо хүртэл хүмүүсийн сэтгэхүйд хүчтэй байдаг баримт юм. Ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг Монголчууд нэлээн сайн мэддэг байсан нь бөө мөргөйлтэй холбоотой. Бөө болохоор сурч буй хүн хүний ертөнцөөс халин онгодын ертөнцөд орохын тулд өөрийн төрлийн жендерийн хил хязгаарыг давах ёстой гэсэн ойлголт бөө мөргөлд байдаг байжээ. Энэ нь ижил хүйстэн хүмүүсийг хүлээн зөвшөөрөх, нийгэмд тусгай байр суурийг тэдэнд өгөх шалтгаан болдог байжээ.

- Ижил хүйстнүүдийг үзэн ядсан үзэн ядалтаас үүдсэн гэмт хэргүүд байнга гарч байгаа байдал¹²;
- ЛГБТ хүмүүсийн дунд амиа егүүтгэх, амиа егүүтгэхийг завдах тохиолдол, сэтгэлзүйн ужиг гуниг гутрал маш түгээмэл байгаа байдал¹³;
- ЛГБТ хүмүүсийн талаар эрх зүйн ба нийгмийн үл үзэгдэх, үл ойлгох байдал байгаагаас үүдэн ЛГБТ хүмүүсийн эсрэг маш түгээмэл ялгаварлан гадуурхалт;
- Хүний үндсэн эрх болох бэлгийн чиг баримжаагаа тодорхойлох, илэрхийлэх эрх үгүйсгэгдсэн байдал;
- ЛГБТ хүмүүсийг үл хүлээн зөвшөөрсөн, бүх талаар үгүйсгэсэн байдал;
- ЛГБТ хүмүүсийн иргэн бус/хоёрдогч иргэний статус;
- Хууль сахиулах, тагнуулын болон бусад холбогдох төрийн агентлагууд ЛГБТ хүмүүсийг давхар дарамтлаж буй байдал;
- Ижил хүйстэн хүмүүсийг бэлгийн чиг баримжаанаас нь үүдэн эцэг эх, ах дүү нарын зүгээс бие сэтгэлээр хүчирхийлдэг байдал, цаашлаад ижил хүйсийн гэр бүлийн хүчирхийллийн¹⁴ талаар ЛГБТ олон нийт болоод гэр бүлийн хүчирхийллээр дагнан ажиллаж буй төрийн бус байгууллагуудад ойлголт дутмаг байдал.

Институтчилсэн хэтэронорматив үзэл нь цаашлаад “ижил хүйстэн хүмүүс Монголын үндэсний аюулгүй байдалд заналхийлж байна” гэсэн ёс зүйн хувьд маш доголдолтой¹⁵, сэтгэл сэртхийлгэсэн мэдлэг мэдээлэлгүй хандлагыг төрийн хэмжээнд үүсгэснийг үгүйсгэшгүй¹⁶.

¹² Манай оронд үзэн ядалтаас үүдсэн гэмт хэрэг (hate inspired crime буюу hate crime)-ийн тухай ойголт байдаггүйгээс гомофобия (гомофобия нь ижил хүйстэн хүмүүсийг үзэн ядах, тэднээс айх сэтгэлзүйн эмгэг)-гаас үүдэлтэй хүчирхийлэлд өртсөн ЛГБТ хүмүүс энэ тухайгаа цагдаад мэдэгдэх, хүчирхийлсэн хүмүүсийн эсрэг албан ёсны хэрэг үүсгэх боломжгүй байдаг. Цаашлаад ийм үзэн ядалтаас үүдсэн гэмт хэргийг гэмт хэрэг мөн гэж тогтоож, статистикаар гаргаагүй байгаа учир хэр их түгээмлийг тогтоох бэрх ч, миний мэдэх бүх ЛГБТ хүмүүсийн 80 хувь нь бэлгийн чиг баримжаанаасаа болон ямар нэг байдлаар бие сэтгэлээрээ хохирсон, зодуулсан, хүчиндүүлсэн, үг хэлээр доромжлуулсан, сүрдүүлэг сэтгэлзүйн дарамтыг амссан байдаг.

¹³ Энэ талаар Монголд хийсэн статистик судалгаа байхгүй ч нийгмийн хэтэронорматив дарангуйлал, түүнээс үүсэх өөрөө өөрийгөө үзэн ядах (internalised homophobia) байдлаас болж ЛГБТ хүмүүс сэтгэхүйн эрүүл мэндийн асуудал болох амиа егүүтгэх, ужиг гуниг гутралын байдалд байх, архичин болох гэх мэт асуудалтай байх нь цөөнгүй байдгийг Барууны судалгаануудад тогтоосон байдаг.

¹⁴ Ижил хүйсийн харьцаан дахь дотны партнёраа хүчирхийлэх буюу ижил хүйсийн гэр бүлийн хүчирхийллийг өөрийн бэлгийн чиг баримжааг үзэн ядах (internalised homophobia)-аас үүсдэг үзэгдэл хэмээн сэтгэхүйн эрүүл мэндийн мэргэжилтнүүд батлажээ. Энэ талаар Ristock, Janice (2003) “Exploring Dynamics of Abusive Lesbian Relationships: Preliminary Analysis of Multisite, Qualitative Study” American Journal of Community Psychology, vol. 31, no.3-4 нийтлэлийг уншина уу.

¹⁵ ХДХВ/ДОХ-ыг үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн хэмээн олон орнууд ярьж бичсэнээр ёс зүйн хэр хэмжээ алдагдаж байгаа талаар Coyle, Jennifer (2004/2005) “The Arc of Justice: The Ethical Implications of Framing HIV/AIDS Pandemic As a National Security Threat: An Annotated Bibliography” International Quarterly of Community Health Education, vol. 23, no.1; болон Бразил Өмнөд Африкийн Засгийн Газруудын бодлогын талаар Gauri, Varun ба Lieberman, Evan (2004) “AIDS and the State: The Politics of Government Responses to the Epidemic in Brazil and South Africa” нийтлэлийг дараахь холбоосоос олж уншина уу. <http://media-cyber.law.harvard.edu/blogs/gems/politicshiv/liebermanpaper.pdf>

¹⁶ 2006 оны 2-р улиралд Өдрийн Сонины мэдээлсэнээр Монголын Засгийн Газар Үндэсний Аюулгүйн Байдалын Хуралдаанаараа ХДХВ/ДОХ-ын талаар авч хэлэлцсэн ба эрэгтэй ижил хүйстэн хүмүүсийг нэн эмзэг бүлэг утгаар нь авч хэлэлцжээ. Энэхүү хуралдаанд холбогдох тагнуул болон хүчний байгууллагаас болон холбогдох эрүүл мэндийн байгууллагуудаас оролцжээ.

“Үндэсний аюулгүй байдалд бэлгийн чиг баримжааны цөөнх заналхийлж байна” гэсэн уриаг төр тэргүүлж, төрийн энэ үзлийг тууштайгаар нийгмийн сэтгэхүйд шар сонин, телевиз радио гэх мэт аргаар хэвшүүлж байгаа нь Монголын ЛГБТ хүмүүсийн хүний болон иргэний эрхэд шууд халдаж байгаагаар зогсохгүй нийгмийн бусад чимээгүй цөөнхүүдийн хүний эрхэд халдаж байгааг, халдаж болохыг бидэнд сануулсан зүйл юм¹⁷. Монголын Засгийн Газар дотоодын хуулиндаа хүний эрхийг дээдлэн тусгаж, хүний эрхийн олон улсын гэрээ конвенцид нэгдэн орсноороо хүний эрхийг дээд зэрэгт баталгаажуулсан мэт боловч хүний эрхийн тухай ойлголтыг өдийг хүртэл хэтэронорматив үзэлд тулгуурласан, явцуу хүрээтэй, ЛГБТ хүмүүсийн хүний эрхийг үл ойшоосон байдлаар тодорхойлсоор ирсэн ба цөөнхийн үндсэн эрх, эрх чөлөөг төр анхааралдаа аваагүй хэвээр байна. “Олон нийтийн аюулгүй байдал, нийгмийн тогтвортой байдлыг”¹⁸ хангах нэрийдлээр хүний үндсэн эрх, эрх чөлөөнд төр халдсаар ирснийг Монголын Засгийн Газар зөвхөн аман дээрээ хүний эрхийг дээдэлдэг гэсэн дүгнэлтэд хүргэж болохуйц байна.

АНУ-ын Төрийн Департаментаас 2003 онд гаргасан Монгол Улс дахь Хүний Эрхийн Байдал тайланд бичсэнчлэн Монголын Засгийн Газар хүний эрхийг хүлээн зөвшөөрдөг ч, хүний эрхийг хангах, хамгаалах талаар дулимаг байгааг дараах жишээгээр анхааруулжээ¹⁹:

- Шоронгийн хоригдол болон албадан саатуулагдсан хүмүүсийг зодож, сэтгэлзүйгээр дарамтлах хүний эрхэд нь ноцтойгоор халдсан үзэгдлүүд;
- Бие эрүүл мэндийн байдлаас шалтгаалсан гэх боловч хэд хэдэн шоронгийн хоригдлууд шоронд нас барсан үзэгдэл;
- Хууль бусаар албадан саатуулах үзэгдэл;
- Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг төрөөс цензурдэх²⁰ гэх мэт Засгийн Газрын зүгээс хүний эрх зөрчсөн олон тохиолдол байгааг тэрхүү тайланд тусгажээ.

Цаашлаад Монголын Засгийн Газар хүний эрхийг хүлээн зөвшөөрдөг ч хүний эрхийг хамгаалах, баталгаажуулах, дээдлэх тал дээр төрийн арга хэмжээ, механизм дутууг нэгэн хөтөлбөрийн жишээн дээр харж болно. 2000 оны Мянганы Хөгжлийн Тунхаглал, 2005 оны Парисын Зээл Тусламжийн Зохицуулалтын Тунхаглалын дагуу зээл тусламжийг үр

¹⁷ ХДХВ/ДОХ-ын асуудлаар хэн хэнийг илүү голчилж байгаа нь сонирхолтой болов уу. USAID-ын санхүүжилттэй Pact Mongolia олон улсын ТББ-ын ХДХВ/ДОХ-ын мэдээллийг 2006 оны 3-р сараас эхлэн телевизийн мини-сериалаар хүргэхдээ зөвхөн биеэ үнэлэгч хүмүүсийг голлон анхаарсан байхад Монголын ЗГ нь ижил хүйтэн хүмүүсийг голлон анхаарч байна.

¹⁸ http://en.wikipedia.org/wiki/Human_rights_in_Mongolia хуудсыг үзнэ үү.

¹⁹ АНУ-ын Төрийн Департаментаас 2003 онд гаргасан Монгол Улс дахь Хүний Эрхийн Байдалын тайланг дараахь холбоосоос олж үзнэ үү. <http://www.state.gov/g/drl/rls/hrrpt/2003/27781.htm>

²⁰ Монголын хэвлэл мэдээллийн эрх чөлөөний талаар анх удаа Хэвлэлийн Хүрээлэнгээс гаргасан Press Institute of Mongolia (2005) State of Press Freedom in Mongolia, Press Institute Publication: Ulaanbaatar номыг олж үзнэ үү.

ашигтай зарцуулах, зээл тусламжийг зохицуулах асуудал олон улсын хөгжлийн байгууллага болоод үндэсний засгийн газруудын мөрийн хөтөлбөрт шинээр тусгагдаж, нэн чухал салбаруудын зээл тусламжийг үр ашигтай болгох зорилгоор эн тэргүүний чухал салбаруудыг тодорхойлох үүрэг бүх талуудад ноогдсон билээ. Энэ зорилтын дагуу 2005 онд Монголын Засгийн Газар НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага болон НҮБ-ын Хүүхдийн Сантай хамтран Зээл Тусламжийг үр Ашигтай Болгох, Зохицуулах Хөтөлбөрийг үүсгэсэн ба энэ хөтөлбөртөө дараах салбаруудыг эн тэргүүнийхэд тодорхойлжээ. Үүнд:

- ХДХВ/ДОХ;
- Ус, цэвэр бохир усны сүлжээ, ариун цэвэр;
- Хүний эрхийн боловсрол;
- Статистик, статистиктай холбоотой чадварыг бэхжүүлэх²¹.

ЛГБТ хүмүүсийн хүний үндсэн эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрөөгүй нөгөө л Засгийн Газар зээл тусламжийг зохицуулах хөтөлбөртөө нийтлэг хүний эрхийн боловсролыг сайжруулах хэрэгцээг багтаасан нь егөөтэй. үүнийг гагцхүү Монголын Засгийн Газар нь ЛГБТ хүмүүст хүний эрх байдаггүй мэт үзэж, ЛГБТ хүмүүс бусадтай адил эрхтэйг үл ойшоосноос үүсч буй асуудал гэж ойлгож болох. Арьсны өнгөөр Ялгаварлан Гадуурхах, Ксенофоби болон Адил Төрлийн үл Тэвчих Байдлыг Зогсоох НҮБ-ын Дэлхийн Конференцид Олон Улсын Лесбиян Гей Нийгэмлэг (ILGA) итгэмжлэгдэх асуудлыг хэлэлцэх үеэр Монгол болон Хятад, Энэтхэг, Шри-Ланк, Сингапур, Вьетнамын төлөөлөгчид эрс эсэргүүцсэн²² нь ЛГБТ хүмүүсийн талаар Монголын төрийн албан ёсоор баримталдаг үзлийн тод жишээ гэлтэй. Оршил хэсэгт хэлснээ дахин цохон тэмдэглэхэд Монголын ЛГБТ хүмүүс эрх зүй, нийгэм болоод хүний эрхийн ойлголт хүрээнд багтаагүйгээсээ үл харагдах, үл сонсогдох саарал нийгмийн орон зайд шахагдан, амьд үхсэний хооронд оршсоор байгаа нь нэн харамсалтай.

2. МОНГОЛЫН ЛГБТ ХҮМҮҮСИЙН АМЬДРАЛ ТҮҮХИЙН ҮҮДНЭЭС АРДЧИЛЛААС өМНӨ

19-р зууны сүүл, 20-р зууны эхээр Оросын болон Францын угсаатан зүйчдийн одоогийн Монгол Улс болон хиллэх Хаант Оросын нутаг дэвсгэр

²¹ Зээл тусламжийг зохицуулах хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг дараахь холбоосоос олж үзнэ үү. <http://unctdatabse.undg.org/index.cfm?module=AnnualReport&page=Workplan&CountryID=MON&Year=2005&LanguageID=en>

²² Энэ талаар Sanders, Douglas (2005) "Human Rights and Sexual Orientation in International Law" ILGA World News дараахь холбоос дээр бий http://ilga.org/news_results.asp?LanguageID=1&FileCategoryID=44&FileID=577&ZoneID=7

дээрх Монгол туургатны дунд хийсэн судалгаа²³, мөн Монголын угсаатан зүйчдийн социализмын үед хийсэн судалгаануудын дагуу 17-р зууны сүүл хүртэл Монголын нийгэм нь түүх уламжлалаараа ижил хүйсийн бэлгийн чиг баримжаа болон жендэр солбилцлыг²⁴ энгийн хэмээн хүлээн зөвшөөрч, түүгээр барахгүй ижил хүйсийн бэлгийн чиг баримжаа болон жендэр солбилцлыг өндөр дээд заяа хэмээн хүндэтгэж ирсэн бөө мөргөлийн шүтлэгтэй нийгэм байжээ. Ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг энгийн хэмээн хүлээн зөвшөөрдөг байсан нь байгаль дэлхий болон онгодын ертөнцийг хүний ертөнцтэй холбож өгдгөөрөө хүмүүст туслаж, нийгэмдээ маш хүндлэгдсэн бөө удгадын статустай холбоотой байсан бололтой. Дээр дурьдсан угсаатан зүйн судалгаануудад бөө удгадын жендэр үүрэг роль ихэнхдээ солбилцсон байдалтай байсныг өгүүлсэн байна. Жишээ нь, удгад эхнэр авч, эрэгтэй хувцас өмсөн, ан гөрөө хийн, бусад эрчүүдтэй архи ууж эрэгтэй хүн мэт амьдардаг байсан бол бөө нар нөхөрт гарч, эмэгтэй хувцас өмсөн, ахуйн ажлыг омгийн бусад эмэгтэйчүүдтэй хамтран хийн, хувцас урлаж эмэгтэй хүн мэт амьдрах нь ховор биш байжээ. Яагаад жендэр солбилцол чухал байв гэсэн асуултын хариулт нь бөө болохын тулд олон жил бөөгийн эрдэм сурахаас гадна зөвхөн төрлийнхөө жендэрээс хальж гарч чадсан хүмүүс жинхэнэ ёсоор бөөгийн зиндаанд хүрдэг гэсэн бөө мөргөлийн ойлголттой шууд холбоотой²⁵. Үүнтэй адил үзэл баримтлал дэлхийн өөр өөр соёл иргэншилд байдгийг Хойд ба өмнөд Америкийн уугуул омгуудын “хос сүнст”²⁶ хэмээн нэрлэгддэг омгуудын бөө, удган, эмч бариач нарын талаар хийгдсэн олон судалгаанууд гэрчилнэ.

17-р зууны дундаас сүүл үеэр Монголын нийгэмд улс төрийн учир шалтгаанаар шарын шашныг дэлгэрүүлснээс хойш албан ёсны институтчлэгдсэн шашныг уламжлалт мөргөлтэй хоршуулж эхэлсэн үед ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг хүлээн зөвшөөрөх асуудал дуусгавар болоогүйгээр барахгүй Буддын шашны үйлийн үрийн номлолын дагуу нийгэмд улам бүр батжсан байна. Буддын шашны үйлийн үрийн хуулиар сүнс гэгээрч, нирваан дүрийг олох замдаа амьдралаас амьдрал, төрөл арилжихаас төрөл олох хүртэл энэ ертөнцийн олон зүйлийг амсах ёстой байдаг ба төрөл олох болгондоо хүйс нь солигдох жамтай гэнэ. Үйлийн үрийнхээ дагуу эмэгтэй биеийг олж төрөх ёстой атал эрэгтэй биед төрвөл тэр сүнс нь үйлийн үрээрээ эмэгтэй л хүнд ноогдох амьдралыг туулдаг гэнэ. Харин үйлийнхээ үрээр эрэгтэй бие олж төрөх байсан атал эмэгтэй

²³ Энэхүү 20-р зууны эхээр нийтлэгдсэн бөө мөргөлтэй холбоотой материал судалгаануудыг Улсын Төв Номын Сангаас олж үзэж болно.

²⁴ Gender queerness – жендер солбилцол.

²⁵ Ирээдүйн бөө удганыг илрүүлэх цаг нь ерөнхийдөө тэдний өсвөр насны үетэй давхцдаг байсан нь сонирхолтой юм. Магад бөө удган өөрийн залгамжлагчийг сонгохдоо тэрхүү өсвөр насны хүүхдийн ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг мэдсэний Үндсэн дээр сонгодог байсан ч байж болох юм.

²⁶ Two spirited – хос сүнст.

биед төрөл олсон сүнс үйлийн үрээрээ эрэгтэй хүний л амьдралаар амьдардаг гэнэ. Тантрын буюу тарнийн шидийн Буддын сургаалд ч ижил хүйсийн бэлгийн үйлдэл нь бүтээгч энерги кундалинийг хөөргөж, гэгээрлийг олох нэгэн зам болдог гэж сургадаг байна. Үнэхээр одоог хүртэл шинжлэх ухаан хүний бэлгийн чиг баримжаа хэрхэн яаж бүрдээгийг ойлгож тайлбарлаж чадаагүй байхад Буддын шашин, бөө мөргөлд үүнийг аль эрт тайлбарлажээ. Монголд ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг Буддын шашнаар энгийнчилж, хүлээн зөвшөөрдөг байсны нэгэн томоохон соёл урлагийн баталгаа болох бэлгийн үйлдлийн суудлаар сууж буй хоёр нүцгэн толгойтой эрэгтэйн баримлыг Улаанбаатар хот дахь Чойжин ламын музейд олж үзэж болно.

Социализмын үед Монголын Засгийн Газар ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг биш харин “ёс суртахуунгүй байдлаар бэлгийн хүслээ хангах” үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцон Эрүүгийн Хуулийн 113-р заалтад оруулсан байсан ба хуучин ЗХУ буюу одоогийн Орос болон ТТУХ-ны гишүүн орнууд ардчилал, өөрчлөн байгуулалттай хамт ижил заалтуудаа эрүүгийн хуулиасаа үтэр түргэн хасахад Монгол Улс ч бусдын жишгийг даган 1986 онд ижил хүйсийн бэлгийн чиг баримжаа болон ижил хүйстнүүдийг гэмт хэрэгтэнд үзэхээ байн, эрүүгийн хуулиас энэ заалтыг хассан байна. Түүх болон уламжлалын үүднээс авч үзвэл ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг ёс суртахуунгүй ба гэмт хэргийн шинж чанартай зүйл хэмээх үзлийг хиймлээр бий болгож нийгэмд албадан хэвшүүлсэн нь социализмын үзэл сурталтай салшгүй холбоотой. Ёс заншил, бөө мөргөлд үндэслэсэн түүхэн хүлээн зөвшөөрлийг хиймлээр үгүйсгэсэн байдал нь тэр үед амьдарч байсан ЛГБТ хүмүүсийн хувьд нэг талаас аюулгүй, нөгөө талаас маш аюултай орчныг бүрдүүлжээ. Засгийн Газар ЛГБТ хүмүүсийн эсрэг системчилсэн суртал ухуулга хийдэггүй байсан учир²⁷ нийгэмд ижил хүйстэн хүмүүс амьдардаг талаар ойлголт байдаггүй байв. Харин ижил хүйстэн гэдгийг мэдвэл ижил хүйстэн хүнийг шоронд хийн нийгмээс тусгаарлаж, хүн бусаар харьцдаг байсан нь гарцаагүй.

²⁷ Социалист төрөөс ижил хүйстэнүүдийн талаар ийм энэрэнгүй хандлага баримталсан нь социализмыг Монголд авчирч, социалист төрийг босголсон Сүхбаатар, Чойбалсан, Данзан гэх мэт хүмүүс өөрсдөө ижил хүйстэн байсантай холбоотой байж болох. Тэдний ижил хүйсийн бэлгийн чиг баримжааны талаар Монгол Улсын Архивт нууц хэмээн кодлогдсон материалууд байдаг талаар олон хүн шуурсаар ирсэн. Нөгөө талаас ЗХУ-ын нөлөө маш их байсан тэр үед ЗХУ-д ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг сэтгэл мэдрэлийн эмгэг, гэмт хэрэг гэж тодорхойлдог байсан ба ардчиллын дараа энэ үзэл сурталыг хүний эрхийг дээдлэснээрээ халсан. Нөгөө хөрш Хятад Улсад сэтгэлзүйн эмгэгийн жагсаалтаас ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг 2000 онд албан ёсоор хассан маш дэвшингүй ба энэрэнгүй үйл явдал болсон ба 2006 оны 7 сарын Монреальд болсон Олон Улсын ЛГБТ Хүний Эрхийн Хурал дээр Хятадын сэтгэлзүйч, ЛГБТ төрийн бус байгууллагын төлөөлөгч болон хуулийн профессор 3 төлөөлөгч хүн амын бодлогын хувьд ижил хүйсийн гэрлэлтийг Хятадад албан ёсоор батлах нь зүйтэй гэсэн илтгэл тавьсан ба одоо хүртэл коммунист үзэл сурталыг зах зээлтэй амжилттай хослуулсан урд хөрш маань энэ байдлаараа магад Монголоос эрт ЛГБТ хүмүүсийн эрхийг хүлээн зөвшөөрч, ижил хүйсийн гэрлэлтийг ч хүлээн зөвшөөрөх бололтой.

Социализмын үеийн хэт үзэл сурталжсан нийгэм соёлын бүтэц нь олон зуун, магад хэдэн мянган жилийн Монголчуудын ижил хүйстэн хүмүүсийг хуульчлэн зөвшөөрдөг байсан явдлыг далан жилийн харьцангуй богино хугацаанд “социализмын эсрэг ёс суртахуунгүй байдал”²⁸ хэмээн томъёолж гэмт хэрэг болгосон тул ЛГБТ хүмүүсийн дунд гүн айдас, чимээгүй байдал үүссэн ба эцэстээ 1990-ээд оны эхээр ардчилал өрнөхөд ч ЛГБТ хүмүүс ЛГБТ эрх нь хүний үндсэн эрх мөн гэсэн шаардлагаа дэвшүүлж чадаагүй байдлыг бий болгожээ.

АРДЧИЛЛААС ХОЙШ

Монгол Улс шинэ үндсэн Хууль болон бусад хууль тогтоомжоороо хүний эрх болоод иргэний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан ч өмнөд Африкийн Улсын үндсэн Хуульд албан ёсоор тусгасантай адил бэлгийн чиг баримжааны тухай болон бэлгийн чиг баримжааны улмаас ялгаварлан гадуурхахгүй гэсэн заалтыг ямар ч хуулиндаа оруулсангүй.

1991-1992 оноос гадаадын кино, хөгжим болоод кабелийн телевизийн олон сувгууд Монголд нэвтэрснээр нийгмийн хандлага өөрчлөгдөх үүд нээгджээ. Хэтэрнорматив нийгмийн үзэл сурталд ижил хүйсийн эротик байдал болон ижил хүйстнүүдийн зураг, дүр төрх нэвтрэн орж, 20-р зууны Монголд анх удаа ЛГБТ хүмүүсийн талаар нээлттэй ярих орон зай бүрдэж эхлэв. Олон нийтийн хэтэрнорматив хүрээг тэлэхэд түлхэц үзүүлсэн өөр нэг зүйл нь олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслэлийн шинээр олж авсан ч одоо хүртэл бүрэн эдэлж чадахгүй байгаа хэвлэлийн эрх чөлөө болон өөрийгөө илэрхийлэх эрх чөлөө байсан ба Монголын нийгэмд маань ч ижил хүйстэн хүмүүс байдаг гэдгийг Гамбууш, Нараа нарын тухай бичсэн сонины нийтлэлүүд, тэдэнтэй хийсэн ярилцлагаар харуулжээ. Гэвч нөгөө талаас олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслэлийн ижил хүйсийн бэлгийн чиг баримжааны талаар зөв зүйтэй ойлголтууд байдал нь хүмүүсийн мэдээлэлгүй байдалтай дүйцэн, ЛГБТ хүмүүсийг зөвхөн Гамбууш Нараа нараар төсөөлөхөд хүргэж, цаашлаад ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг монгол бус, гадны үзэгдэл хэмээн шуугиан дэгдээсэн нь социализмын үеийн ёс суртахууны үзэл сурталжсан баримтлалтай нийлж, ёс зүйн хэмжүүргүй мэдээллийн хэрэгслүүдийн тусламжтайгаар ЛГБТ хүмүүсийн Монгол дахь орон зай нээгдэхээсээ өмнө хаагдах шалтгаан болжээ.

Хавчигдан гадуурхагдсан олон нийтийн хувьд харагдах мэдэгдэх байдал нь анх ихсэхэд үл харагдах үетэй харьцуулбал илүү эмзэг болдог. Монголын нийгэмд ЛГБТ хүмүүс оршдог гэдгийг эсрэг хүйстэн хүмүүс

²⁸ Социализмын эсрэг ёс суртахуунгүй байдал хэмээх ойлголтыг социализмын үед шашнаас эхлүүлэн уламжлалт болон түүхэн бүх зүйлийг үгүйсгэж, буруушаадаг байсантай холбож тайлбарлах хэрэгтэй. Хуучин үеийн үнэт зүйлс, нийгмийн үзэл бодол бүх талаараа үгүйсгэгдсэн тэр үед төрд ашиггүй бүх зүйл социализмын эсрэг ёс суртахуунгүй байдал болж хувирдаг байсан нь гарцаагүй.

мэдэж, ЛГБТ хүмүүсийг хараад гадарлах болсон учир ЛГБТ хүмүүст хандах хандлага социализмын үетэй харьцуулбал илүү үл тэвчсэн, үл хүлээн зөвшөөрсөн байдлаар солигдон системчилсэн ялгаварлан гадуурхалт, гомофобийн үндэстэй харгислал, ЛГБТ хүмүүсийг үзэн ядсанаас үүдсэн гэмт хэрэг түгээмэл гарах болж, ЛГБТ хүмүүсийн эсрэг өдөөн турхирсан телевизийн нэвтрүүлэг²⁹ олширч, олон нийтийн урлагт ч³⁰ ЛГБТ хүмүүсийг үзэн ядсан байдал тусгалаа олж эхлээд байна.

ЛГБТ хүмүүсийн дунд ч бэлгийн чиг баримжаагаа тодорхойлох³¹ ба илэрхийлэх эрх нь хүний үндсэн эрх мөн гэсэн ойлголт түгсээр байгаа учир ЛГБТ хүмүүс хүний эрхээ хамгаалах, эрхээ шаардах, зөв зүйтэй мэдээлэл нийгэмд түгээх, өөрсөдтэйгөө адил ижил хүйстэн хүмүүстээ сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, хүний эрхийн талаас ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг тодорхойлж нийгэмд ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг сенсацладаг байдлыг өөрчлөх зорилгоор хэд хэдэн иргэний нийгмийн байгууллага төвүүдийг үүсгэж, үйл ажиллагаа явуулж байсныг дараагийн хэсэгт авч үзье.

Монголд ардчилал өрнөснөөс хойш хамгийн их сэтгэл зовоосон, ЛГБТ хүмүүсийн эрхэд шууд халдсан үйл явдал 2004 оноос эхлэн хурдацтай өрнөж байгааг энэ талаар мэдээлэлтэй хүн бүр хүлээн зөвшөөрөх биз. Төрийн хэмжээнд ХДХВ/ДОХ-ыг нийгэмд заналхийлсэн өвчин хэмээн тодорхойлсон ба ижил хүйстэн эрэгтэйчүүдийг хамгийн эмзэг бүлэг утгаар нь нийгмийн аюулгүй байдалд заналхийлж буй хүмүүс хэмээн ярьж, бичиж эхэлсэн нь 2004 оноос эхлэлтэй. Олон ижил хүйстэн эрчүүдийг цугладаг газруудаас нь хомроглож, сэтгэлзүйгээр нээнтэглэн зарим тохиолдолд хүч хэрэглэн ХДХВ-ын шинжилгээ албадан өгүүлж байгаа нь ЛГБТ хүмүүсийн дунд нууц биш болоод хэдэн жил болов. Монголын ХДХ вирус авсан хүний тоо 2006 оны 7-р сарын байдлаар 23-т хүрсэн одоо үед төрийн энэхүү харанхуй суртал ухуулга хүчээ авсаар байх хандлагатай байна.

²⁹ Анх удаа нээлттэй асуулт хариултын нэвтрүүлэгт ЛГБТ хүмүүсийн тухай ЛГБТ төлөөлөл орсон нэвтрүүлгийг UBS телевизийн 2005 оны 7 сарын 17-ны *Yah-uu Talk Show* хийсэн ба нэвтрүүлгийн хөтөлгчийн хүний эрхийн талаар ойлголтгүй байдал ямар сөрөг үр дүнд хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн талаар зохиогчийн шүүмжийг дараах холбоосоос олж үзнэ үү. O.N.A. (2005) “*Yah-uu Talk Show*” http://www.mongoldyke.org.mn/up_around_eng.htm

³⁰ Б. Батрэгзэдмаагийн бичиж найруулсан, 2004 оны 1, 2-р саруудад 8 удаа тавигдсан жүжиг нь ижил хүйстэн хүмүүсийг үзэн ядсан, ЛГБТ хүмүүсийн эсрэг үзэн ядалтын гэмт хэрэгт турхирсан, нийтлэг хүний эрхэд санаатайгаар ноцтой халдсан жүжиг болсон талаарх шүүмжийг дараахь холбоосоос олж үзнэ үү. O.N.A. (2004) “*Stripper Boys and the Grey Street Review*” http://www.mongoldyke.org.mn/up_around_eng.htm

³¹ Монголчуудын дунд нэгэн үлгэр мэт яриа буюу “ЛГБТ хүмүүс ижил хүйсийн бэлгийн чиг баримжаагаа сонгосон, завхай зайдандаа л ингэж байгаа юм” гэх мэт яриа их түгээмэл байдаг. Гэтэл хүн бэлгийн чиг баримжаагаа сонгох битгий хэл өөрчилж ч болшгүй зүйл гэдгийг олон орны шинжлэх ухааны салбаруудад олон арван жилийн судалгаагаар тогтоосон байдаг. Тиймээс бэлгийн чиг баримжаагаа тодорхойлоно гэдэг нь сонгоно гэсэн үг биш, харин өөрийгөө ЛГБТ хэмээн өөртөө хүлээн зөвшөөрөх, бусдад өөрийгөө ижил хүйстэн хэмээн тодорхойлох гэж ойлговал зохино.

3. өНГӨРСӨН БА ОДООД ЯВАГДСАН ЛГБТ ЭРХИЙН ТАЛААРХИ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЛГБТ хүмүүсийн асуудлаар ба ЛГБТ эрхийн талаар гурван төрийн бус байгууллага Монголд үйл ажиллагаа явуулж байсан ба Монголын ТББ-аас гадна АНУ-ын Элчин Сайдын Яамнаас ЛГБТ хүмүүсийн эсрэг гардаг хүчирхийлэл, харгислалын талаар нэг судалгаа явуулах төлөвлөгөөтэй байжээ. Он цагийн дарааллаар хамгийн эхний байгууллага нь Тавилан юм.

Тавилан

Тавиланг 1999 оны 3 сард хэдэн гей монгол болон тэр үед Монголд амьдарч байсан гей гадаадын иргэд үүсгэн байгуулжээ. Санхүүжилт нь хувь хүмүүсийн хандив байв. Тавилан нь албан ёсоор Хуульзүй Дотоод Явдлын Яаманд бүртгэлтэй төрийн бус байгууллага байсан ба 1999 оноос 2000 оны эх хүртэл албан ёсоор үйл ажиллагаагаа явуулсан ч төрийн бус байгууллагын гэрчилгээний хугацаа дууссанаас хойш үйл ажиллагаагаа албан бус маягаар үргэлжлүүлсэн. ЛГБТ олон нийт дотор зорилтот бүлэг нь Улаанбаатар хотын гей эрчүүд байсан ба тэдэнд бэлгийн эрүүл мэнд, аюулгүй бэлгийн харьцаа, сэтгэлзүйн зөвлөгөө болон хүний эрхийн талаар мэдээлэл өгч ажиллаж байсан. 2000 оны сүүлээс 2001 оны эх хүртэл зөвхөн гей эрчүүдээр зогсохгүй, Улаанбаатарын бүх ЛГБТ хүмүүст зориулсан итгэлтэй утас ажиллуулж байсан. Энэхүү байгууллагын ЛГБТ асуудалд гол нэмэрлэсэн зүйл нь Монголд гей хүмүүс байдаг ба гей хүмүүс зөвхөн Барууны үзэгдэл биш гэдгийг ямар нэгэн хэмжээнд нийгэмд ойлгуулсан явдал юм.

Залуус Эрүүл Мэнд Төв

2001 оны эхээр үндэсний ДОХ-ын Сангийн төсөл хэрэгжүүлэгч бүлэг хэлбэрээр байгуулагдсан ба санхүүжилт нь AIDS Alliance олон улсын ТББ-аас иржээ. Ажлын хүрээ нь гей эрчүүд болон эрчүүдтэй хавьталд ордог эрчүүдэд зориулсан аюулгүй бэлгийн харьцааны талаар сургалт явуулах, тэгснээрээ бэлгийн замын халдварт өвчин (БЗХӨ) болон ХДХВ/ДОХ-ын халдвараас тэднийг урьдчилан сэргийлэх ажил байв. 2003 оны сүүлээр үндэсний ДОХ-ын Сангаас салж, бие даасан ТББ байгууллагын статустай болсон ба үйл ажиллагаа нь өмнө дурьдсан чиглэлээр үргэлжилжээ. Залуус Эрүүл Мэнд Төв нь БЗХө/ХДХВ-ээс урьдчилан сэргийлэх сургалтын ажлаа голчлон Улаанбаатарт явуулдаг ч мөн Эрдэнэт, Дарханд хааяа хийдэг ба Улаанбаатар хотод гей эрчүүдийн үдэшлэг зохиодог.

Монголын Лесбиян Олон Нийт, Мэдээллийн Төв (МИАК)

2004 оны 1-р сард Монголын Эмэгтэйчүүдийн Сангийн төсөл хэрэгжүүлэх бүлэг хэлбэрээр үүссэн ба санхүүжилтийг АНУ-ын Шударга Ёсны Төлөө Астрэя Лесбиян Сангаас ирүүлсэн. 2004 оны 1 сараас 10 сар хүртэл богино хугацаанд оршин тогтносон ч үр бүтээл ихтэй байсан Төв

юм. 2004 оны 10 сараас одоог хүртэл ЛГБТ мэдээллийн вэбсайтаараа³² дамжуулан интернэт дэх Монголын ЛГБТ хүмүүсийн олон нийтийн төв хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулсаар байна. Астрэя сангийн санхүүжилт дууссанаас хойш вэбсайтын төлбөрийг хоёр лесбиян эмэгтэй хувийн хандиваараа санхүүжүүлж байна. ЛГБТ олон нийтийн дотор МИЛК Төвийн зорилтот бүлэг нь Улаанбаатарын лесбиян, бисексуал эмэгтэйчүүд байсан ба Монголын бүх ЛГБТ хүмүүст бүх талын мэдээлэл түгээх зорилготой байсан. Монгол дахь ЛГБТ хүний эрхийн асуудлаар НҮБ-ын байгууллагуудад хандах, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд МИЛК-ийн тухай мэдээлэл болон ЛГБТ хүмүүсийн тухай үнэн зөв мэдээлэл өгч нийтлүүлэх, ЛГБТ хүний эрхийн талаар олон нийт дундаа тодорхой зөв ойлголт хэвшүүлэхийн тулд хүний эрхийн ярилцлага хийх, кино үдэшлэгүүд зохион байгуулах, бэлгийн чиг баримжаа болон холбоотой сэдвүүдээр www.mongoldyke.org.mn вэбсайтаараа дамжуулан мэдээлэл түгээх, Монголын ЛГБТ хүмүүсийн аман түүхийг архивлах, куир судлал, жендэр судлал болон феминист судлалын үндсийг тавих, итгэлтэй утас ажиллуулах гэх мэт үйл ажиллагааг энэ хугацаанд явуулсан. Энэхүү Төвийг гардан босгож, ЛГБТ хүмүүсийн хувьсгал хувийн амьдралд нэлээдгүй том алхам хийсэн хүний хувьд энэ Төв буюу Монгол дахь ЛГБТ эрхийн том эхлэл нуран унасанд би маш их харамсдаг. Төвийн үйл ажиллагаа интернэт рүү шилжих болсон шалтгаануудаас нэрлэвэл: *нэгдүгээрт*, гадагш сурахаар явахад миний эхэлсэн ажлыг үргэлжлүүлж хийх зүрх зоригтой ижил хүйстэн эмэгтэй олдоогүйгээс хүн хүч байгаагүй. *Хоёрдугаарт*, Тагнуулын ерөнхий газар, цагдаагийн байгууллагаас Төвийн итгэлтэй утас руу залгаж Төвийг ажиллуулж байсан бид болон Төвд хандаг эмэгтэйчүүдийг садар самуун сурталчилсан явдлаар эрүүгийн хэрэгт татна хэмээн хэд хэдэн удаа сүрдүүлж, дарамталсан явдал³³. *Гуравдугаарт*, төслийг хэрэгжүүлж байсан байгууллага буюу Монголын Эмэгтэйчүүдийн Сан нь лесбиян эрх, ЛГБТ асуудлаар төсөл хэрэгжүүлж байгааг Монголын ивээн тэтгэгч, донорууд нь мэдэх юм бол ивээн тэтгэгчдээ алдана гэсэн сэрэмжлэл, цаашлаад үйл ажиллагааныхаа жилийн тайланд Монголын Лесбиян Олон Нийт, Мэдээллийн Төвийн талаар бичихдээ энэ нэрээр биш харин Феминист Судлалын Төв гэж оруулсан байдал, Монголын Эмэгтэйчүүдийн Сан цөөнх эмэгтэйчүүдийн эрхийн талаар хийж байсан ажлаасаа няцан, хойш ухарсан явдал зэрэг нь Төвийг үгүй болоход нэн том шалтгаан болсон юм. Хэчнээн эхний удаагийн санхүүжилт найман сарын хугацаатай байсан ч Астрэя Сан болоод бусад эмэгтэйчүүдийн асуудлаар ажилладаг хэд хэдэн

³² www.mongoldyke.org.mn вебсайт нь 2004 оны 2 сараас үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Залуус Эрүүл Мэнд Төвөөс гей эрчүүдэд зориулсан www.gay.mn вэбсайтыг 2006 оны 1 сараас ажиллуулж эхэлжээ.

³³ Энэ үл үндэслэлгүй айлган сүрдүүлгийн хариуд Монголын Лесбиян Олон Нийт, Мэдээллийн Төвөөс гаргасан мэдэгдлийг http://www.mongoldyke.org.mn/announcements_eng.htm хуудаснаас олж уншина уу.

гадаадын сан Төвийг цаашид санхүүжүүлнэ гэдгээ амласан байсан ч дээр дурьдсан асуудлаас үүдэн Төв хаагдахаас өөр аргагүй байсан юм.

МИЛК-ийн ЛГБТ асуудал, ЛГБТ эрхийн талаар нийгмийг нээлттэй болгох үйл явцад оруулсан хувь нэмэр нь өөрсдийн бэлгийн чиг баримжаагаа нээж мэдэж буй олон ижил хүйстэн, бисексуал эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдэд вэбсайт болон цахилгаан шуудангаар мэдээлэл өгч дэмжсэнээр тэдний амьдралд эерэг өөрчлөлт хийж, тэд өөрсдийгөө хүлээн зөвшөөрснөөр гэр орныхонтойгоо нээлттэй ярьж ойлголцож чадах түвшинд хүрсэнд оршино.

Гадны Орлоо

2005 оны 5 сард Улаанбаатар дахь АНУ-ын Элчин Сайдын Яам Монголын ижил хүйстэн хүмүүсээс бэлгийн чиг баримжаанаас үүдэлтэй ялгаварлан гадуурхалтын үндэслэлээр улс төрийн орогнол хүссэн олон баримт авдгийн дагуу Монголын ЛГБТ хүмүүсийн амьдрал болон Монголд ЛГБТ хүмүүсийг хүчирхийлж харгисладаг талаар албан ёсны судалгаа хийхийг дотоод захирамжаараа баталжээ. Энэхүү судалгаа хийгдэж эхэлсэн эсэх талаар баттай мэдээлэл одоогоор алга байна. Судалгаа хийхийг баталсан захиандаа АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин Сайд, “Монголын Засгийн Газар хүний эрхийн талаар АНУ-аас суралцах цаг нь ирсэн” гэж бичсэн хэдий ч, “ижил хүйстэн хүмүүс үндэсний аюулгүй байдалд заналхийлж байна” хэмээн ярьсаар бичсээр байгаа Монголын Засгийн Газрын хувьд Монголд ЛГБТ хүмүүсийн хүний эрх ноцтойгоор зөрчигдөж, ЛГБТ хүмүүс аргаа баран гадаад руу гарч байна гэдгийг хүлээн зөвшөөрөх боломжгүй биз. Тэгээд ч Монголын Засгийн Газар үндэсний аюулгүй байдал бол төрийн тусгаар тогтнолын асуудалтай шууд холбоотой гэсэн нэрийдлээр АНУ-ын Төрийн Департамент болон Элчин Сайдын Яамны зөвлөгөөг үл хэрэгсэх нь ухаалаг биш ч, магадлал өндөр зүйл юм.

МОНГОЛД ЛГБТ ЭРХИЙН ТАЛААР ОЛОН НИЙТИЙН ХҮРЭЭГ БИЙ БОЛГОХЫН Төлөө

Монголын Лесбиян Олон Нийт, Мэдээллийн Төвийг үүсгэн байгуулах үед үйл ажиллагааны гурван гол чиглэлийг тодорхойлсон байсан нь өнгөрсөн хоёр жилийн дотор хийгдэх ёстой зүйл гэдэг нь тод томруунаар илэрхий болсон юм. Энэ гурван чиглэлээр цаашид тууштай ажилласнаар Монгол дахь ЛГБТ хүний эрхийн талаар олон нийтийн хүрээ (ямарваа нэг асуудалд дээр хүмүүсийн нээлттэйгээр хэлэлцэхийг хангадаг, нээлттэйгээр хэлэлцэхийг эрх зүйн үндэслэлээр баталгаажуулдаг хэрэгсэл)-г бий болгох, хөгжүүлэх ажил эхлэх нь гарцаагүй юм.

Хууль сахиулах болон холбогдох бусад байгууллагуудад сургалт явуулах, тэдэнд зөв зүйтэй мэдээлэл түгээх: үзэн ядалтаас үүдсэн гэмт

хэргийн ойлголтын талаар цагдаагийн болон холбогдох байгууллагуудад сургалт хийх, ЛГБТ хүмүүсийг цагдаа болон холбогдох бусад байгууллагаас давхар дарамталдаг талаар хүний эрхийн сургалт семинар, ярилцлага явуулах, мөн ХДХВ/ДОХ-ын талаар ярилцлага сургалт хийх. Дашрамд хэлэхэд одоогоор ижил хүйстэн эрчүүдтэй ажиллаж буй ганц байгууллага болох Залуус Эрүүл Мэнд Төв нь ижил хүйстэн эрчүүдийн нэр, утас, хаягийг хамгаалах ёстой атал холбогдох цагдаа болон эрүүл мэндийн төрийн байгууллагад өгч, ижил хүйстэн эрчүүдээ илчилж, тэднийг хомроглоход туслаж байгаа нь нэн харамсалтай.

Нийгэмд зөв ойлголт хэвшүүлэх кампанит ажлууд: дотоодын болон олон улсын хүний эрхийн асуудлаар ажиллаж буй ТББ-уудтай хамтран ажиллах, ЛГБТ хүмүүсийг Барууны үзэгдэл хэмээн сенсацилдаг хэвлэл мэдээллийн хэрэгслэлүүдтэй хамтран ажиллаж тэдэнд зөв зүйтэй ойлголт бүрдүүлэх, ЛГБТ эрхийн үндсэн, норматив, эрх зүйн үндэслэлийг гаргасан олон улсын хүний эрхийн хурал Улаанбаатарт зохион байгуулах, үндэсний Хүний Эрхийн Комисс болон бусад хүний эрхийн дагнасан байгууллагуудтай хамтарч ЛГБТ хүмүүсийг эсрэг гарч буй харгислал, үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэргийг зогсоох кампанит олон нийтийг гэгээрүүлэх ажил явуулах, нийт Улаанбаатарын хүн амд нээлттэй ЛГБТ кино фестиваль зохион байгуулах.

Засгийн Газар болон Их Хуралд асуудал дэвшүүлэх: ЛГБТ хүмүүсийн эсрэг маш түгээмлээр гарч буй гэмт хэргүүдийг үзэн ядалтын үүднээс гарсан гэмт хэрэг мөн хэмээн хуульд тодорхойлуулах, бэлгийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхахгүй заалтыг үндсэн Хуульд нэмж оруулах, бэлгийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхахгүй гэсэн үндсэн Хуулийн заалтын дагуу холбогдох бүх хуульд өөрчлөлт оруулах. Хэчнээн Монгол улс нь ялгаварлан гадуурхахыг хориглосон үндсэн Хуулийн заалттай орон ч, бэлгийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхахгүй гэсэн заалтгүйн улмаас хамгийн хэргийн харгислал буюу ЛГБТ хүний амь насанд хүрэхээс эхлэн ЛГБТ хүмүүсийн амьдралын бүх салбарт³⁴ сөрөг үйл явдлууд гарсаар байгаа нь үндсэн Хуулиар Монголын бүх иргэдэд олгогдсон хуулийн эрх тэгш хамгаалал биш байлтай.

Дүгнэж хэлэхэд 2.7 сая хүн амтай Монгол Улсад 300 мянга шахам ЛГБТ хүмүүс амьдарч байна³⁵. Энэ яаж ч бодсон бага тоо биш. Төвлөрсөн эдийн засагт бүтцээс зах зээлд шилжих, нээлттэй ардчилсан нийгэм байгуулах үйл явцын дунд ЛГБТ хүмүүсийн эрхийн асуудал замхран хаягдсан нь Монголын Засгийн Газар хүний эрхийг биш, улс орны хөгжлийг

³⁴ ЛГБТ хүмүүсийн эрүүл мэндийн асуудал дээр эрүүл мэндийн байгууллагууд ЛГБТ хүмүүсийг ялгаварлан гадуурхдаг байдал, ижил хүйстэн хүмүүс Монголд хууль ёсоор гэрлэх боломжгүй байдал, ижил хүйстэн хосууд гэр бүл утгаар өмч хамтран эзэмших эрхгүй байгаа байдал, монгол иргэдийн гадаадад хууль ёсоор гэрлэсэн ижил хүйсийн гадаад партнёрт нь Монголд байнга оршин суух зөвшөөрөл олгодоггүй гэх мэт маш олон амьдралын асуудал хуулиас гадна оршиж, маш олон хүмүүсийн амьдралд өдөр бүр сөргөөр нөлөөлсөөр байна.

³⁵ Доод тал нь хүн амын 10 хувь заавал ЛГБТ байдаг гэсэн баримжаа шинжлэх ухаанд байдаг.

нэн чухалд үздэгээс шалтгаалсан биз. Улам бүр гүнзгийрч буй нийгмийн бүлгүүдийн хоорондох тэгш бус байдал, газар авсаар буй ядууралтай тэмцэж байгаа Монголын Засгийн Газар эдийн засгийн хөгжлийн төлөө хүний эрхийг хязгаарлан боодог хөгжлийн загвар буюу “Азийн Зам”³⁶-ыг сонгож байна уу даа гэлтэй. Гэвч жаахан хэлбэр дүрс өөр ч, үндсэндээ Монгол орны яс махандаа шингэтэл мэдэрсэн социализмын үеийн оюун ухааны дарангуйлал, иргэний болон улс төрийн эрх хавчигдмал байдлыг буцааж авчрах тэр Азийн Зам нь Монголын хувьд хөгжил бус, ухралт болно. Монголын Засгийн Газар ХДХВ/ДОХ-той холбоотой нийгэмд үүссэн сандралыг далимдуулан ЛГБТ хүмүүсийг улам бүр дарамтлах, айлган сүрдүүлэх, аюулгүй байдалд заналхийлж байна хэмээн сенсаци дэгдээх тактикийг баримтлаж эхэлсэн өнөө үед төрөөс ЛГБТ хүмүүсийн эсрэг ямар арга хэмжээ авч эхлэхийг гадарлая гэвэл жаахан дүвийлгэхэд л маш удахгүй ЛГБТ хүмүүсийг бэлгийн чиг баримжаанд нь дулдуйдан шоронд хийж, цаазаар авах дүр зураг бууна. Харин тийм байдалд хүрвэл Монгол Улс ардчилсан нийгэм төр гэдэг нэрээ хаях шаардлагатай. Төгсгөлд хэлэхэд, ардчилал бэхжих үедээ хамгийн эмзэг байдгийг санаад өнөөдөр Монголын хүн амын арван хувийн амьдрах эсэхийг шийдэх ЛГБТ хүний эрхийг төрөөс зөвшөөрүүлэх нь Монгол үнэхээр ардчилсан төр нийгэм болсны шалгуур юм гэдгийг эрхэм уншигч танд дахин сануулья.

Ашигласан ном, материал:

Aid Coordination Programme in Mongolia, дараах хаягаар олж үзнэ үү <http://unctdatabase.undg.org/index.cfm?module=AnnualReport&page=Workplan&CountryID=MON&Year=2005&LanguageID=en>

Amnesty International (2001) *Crimes of Hate, Conspiracy of Silence*, Alden: London.

Anzaldua, Gloria (1981) *Borderlands/La Frontera*, Spinsters/Aunt Lute: San Francisco.

Coyle, Jennifer (2004/2005) “The Arc of Justice: The Ethical Implications of Framing HIV/AIDS Pandemic As a National Security Threat: An Annotated Bibliography” *International Quarterly of Community Health Education*, vol. 23, no.1.

Dangerous Living: Coming Out in the Developing World (2003), John Scagliotti.

Freedom House Index дараах хаягаар олж үзнэ үү www.freedomhouse.org

Gauri, Varun ба Lieberman, Evan (2004) “AIDS and the State: The Politics of Government Responses to the Epidemic in Brazil and South Africa”, дараах хаягаар олж үзнэ үү <http://media-cyber.law.harvard.edu/blogs/gems/politicshiv/liebermanpaper.pdf>

³⁶ Энэ талаар Sen, Amartya (1997) Human Rights and Asian Values нийтлэлийг олж үзнэ үү, дараахь холбоосоор бий http://carnegiecouncil.org/media/254_sen.pdf

Gershman, Carl (2005) "Democracy as Policy Goal and Universal Value" *The Whitehead Journal of Diplomacy and International Relations*, Winter-Spring.

Jeness, Valerie ба Broad, Kendall (1994) "Anti-violence Activism and the (In)Visibility of Gender in the Gay/Lesbian and Women's Movement" *Gender and Society*, vol. 8, no. 3.

Landman, Todd (1999) "Organisation and Impact: The Green Movement in Comparative Perspective", дараах хаягаар олж үзнэ үү www.essex.ac.uk/ECPR/events/jointsessions/paperarchive/mannheim/w21/landman.pdf

McGhee, Derek (2005) "Hidden Targets, Hidden Harms: Community Safety and Sexual Minority Communities" in *Crime Prevention and Community Safety: An International Journal*, vol. 5, no.4.

O.N.A. (2004) "Stripper Boys and the Grey Street Review" дараах хаягаар олж үзнэ үү. http://www.mongoldyke.org.mn/up_around_eng.htm

O.N.A. (2005) "Yah-uu Talk Show" дараах хаягаар олж үзнэ үү. http://www.mongoldyke.org.mn/up_around_eng.htm

Press Institute of Mongolia (2005) *State of Press Freedom in Mongolia*, Press Institute Publication: Ulaanbaatar.

Rich, Adrienne (1981) "Compulsory Heterosexuality and Lesbian Existence" *Signs*, vol. 5, no.4.

Sanders, Douglas (2005) "Human Rights and Sexual Orientation in International Law" *ILGA World News*, дараах хаягаар олж үзнэ үү http://ilga.org/news_results.asp?LanguageID=1&FileCategoryID=44&FileID=577&ZoneID=7

Sen, Amartya (1999) *Development as Freedom*, Oxford University Press: Oxford.

Sen, Amartya (1997) *Human Rights and Asian Values*, дараах хаягаар олж үзнэ үү http://carnegiecouncil.org/media/254_sen.pdf

Scott, Susan D., Pringle, Alistair ба Lumsdaine, Colin (2004) *Sexual Exclusion – Homophobia and Health Inequalities: A Review*, A UK Gay Men's Health Network: London, дараах хаягаар олж үзнэ үү www.gaymenshealthnetwork.org.uk

Sweeney, Sean (2004) "The Case for Global Justice Unionism" *New Labour Forum*, vol. 13, no. 3.

US Department of State (2003) "Mongolia Country Report of 2003" *The Country Reports on Human Rights Practices*, дараах хаягаар олж үзнэ үү www.state.gov/g/drl/rls/hrrpt/2003/27781.htm

Vienna Declaration and Programme of Action, 1993.

ХҮНИЙ ЭРХ - ХҮНЛЭГ ЭНЭРЭНГҮЙ НИЙГМИЙН ҮНДЭС¹

Шарлот Банч

*Эмэгтэйчүүдийн Глобал Манлайлын Төвийн гүйцэтгэх захирал,
Ратгерзын Их Сургуулийн Блауштайны Нэрэмжит Төлөвлөлт,
Нийгмийн Бодлогын Сургуулийн профессор*

Хүнлэг энэрэнгүй сэтгэл гэж бид юуг ярьж ойлгодог вэ? Энэрэх сэтгэл болоод шударга ёсны хооронд ямар холбоо байна вэ? Хүнлэг энэрэнгүй нийгмийг бүтээхийн төлөө ажиллана гэдэг нь гайхалтай сайхан тэмүүлэл ч үүгээрээ эмэгтэйчүүд энэрэнгүй байж, бусдын төлөө өөрсдийгөө золиослодог байсан хуучин үүрэг ролийг сэргээх эрмэлзэлгүйгээ бид тодруулах ёстой. Жинхэнэ хүнлэг энэрэнгүй нийгмийн үндэс эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн аль аль нь илүү анхаарал халамжтай болохоос, цаашлаад нийгэм нь эдгээр үнэт зүйлс, үйлдлийг шагнаан урамшуулахаас эхэлнэ. Хүнлэг энэрэнгүй нийгэмд хүрэх ганц зам бол эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, хүүхэд, хөгшид, арьсны өнгө, үндэстэн ястан, соёл шашны бүлгүүд, мөн ямар ч бэлгийн чиг баримжааны хүмүүс болон ямарваа ч бие бялдрын эмгэгтэй хүмүүсийн хүний эрхийг хүндэтгэхэд оршино. Хүн бүр адил тэгш үнэ цэнэтэйг үнэлэн хүндэтгэх тодорхой ёс зүй үгүй бол хүнлэг энэрэнгүй сэтгэл нь хувь заяа дутуу хүмүүсийг дорд үзэж, тэднийг нигүүлсэх төдий хэлбэр болж хувирна. Хүн бүрийн үндсэн хүний эрх болох эх дэлхийн нөөц баялгаас хүртэх, эх дэлхийн хувь заяаг удирдан чиглүүлэх үйл явцад оролцох эрхийг хүлээн зөвшөөрөх нь хамгаас чухал юм. Шударга ёсыг тогтоох, хүний эрхийг хэрэгжүүлэхийн төлөө хийгдэж буй үйл явц нь хүнлэг энэрэнгүй нийгмийг бүтээхэд маш чухал ач холбогдолтой.

Хүний эрхийн ирээдүй юу вэ? Хүйтэн Дайн дууссан 1980, 1990-ээд оноос хүний эрх гэдэг ойлголт улам бүр чухалчлагдсаар ирсэн ба Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын (ХЭТТ) тавин жилийн ойг тэмдэглэсэн 1998 онд энэ ойлголт дээд цэгтээ хүрч, өнөөдөр ч чухал хэвээр байна. Гэвч дэлхийн олон хүмүүс, засгийн газрууд эдгээр эрх юу болох талаар маш хязгаарлагдмал ойлголттой хэвээр явна. Үүний нэг жишээ бол өнгөрсөн тавин жилийн туршид хүний эрхийн олон улсын хөдөлгөөн иргэний болон улс төрийн эрх, эрх чөлөөний асуудлыг хэт анхаарснаас нийгэм эдийн засгийн эрх, бүлэг хүмүүсийн эрхийн асуудал замхарч, эдгээр “шоовдорлогдсон” эрх, эрх чөлөө нь ХЭТТ-д багтсан байдгийг ч олон

¹ Bunch, Charlotte (2002) “Human Rights as The Foundation For A Compassionate Society”, ed. Afkhami, Mahnaz (2002) Toward A Compassionate Society, Women’s Learning Partnership: Bethesda, pp. 16-20.

хүмүүс санахаа больсон явдал юм. Тунхаглал нь хүний эрхийг хэрэгжүүлж буй хэлбэрээс илүү өргөн хүрээтэй. Энэхүү Тунхаглал нь засгийн газруудын нийгэм эдийн засгийн, иргэний болоод улс төрийн эрх, эрх чөлөөг хангах үүргийг тод тусгасан байдаг. Ажиллах болоод адил ажлын төлөө ижил хэмжээний цалин хөлс авах эрх, хоол хүнс, орон байраар хангагдах эрх, эрүүл мэндийн үйлчилгээ авах эрх, өөрийгөө илэрхийлэх эрх, эвлэлдэн нэгдэх эрх, шашин шүтэх эрхийн талаар мөн тусгасан байдаг. Хүнлэг энэрэнгүй нийгмийн үндэс бол хүний эрх гэж хэлснээрээ бид ХЭТТ-д тусгасан хүний эрхийн тухай ойлголтуудыг бүрэн утгаар нь дахин сэргээх тухай ярьж байна гэсэн үг юм. Хүний эрхийн ойлголтыг гажуудуулдаг өөр нэгэн зүйл нь эрх үүрэг хоёрыг сөргөлдүүлж ойлгодог явдал мөн. Гэтэл Түгээмэл Тунхаглалд хүний үүрэг хариуцлага нь хүний эрх дотроо агуулагдана хэмээн тусгасан байдаг. Хүний эрх хэмээх ухагдахуун нь хэн нэгэн (хувь хүн эсвэл төр) эдгээр эрхийг хүндэтгэн биелүүлэх үүрэгтэй гэсэн санаанд тулгуурладаг. Тиймээс ч Түгээмэл Тунхаглал нь “хүн бүр, нийгмийн нэгж байгууллага бүхэн эл Тунхаглалыг байнга бодолцон гэгээрч боловсрох замаар хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн сахихад дөхөм үзүүлэхийг эрмэлзэх ёстойг, түүнчлэн үндэсний болон олон улсын хэмжээний дэвшилтэт арга хэмжээ авах замаар эдгээр эрх, эрх чөлөөг дагаж мөрдөх явдлыг хангахад тус дөхөм үзүүлэхийг эрмэлзэх ёстой” гэсэн үүрэг хариуцлагын заалтаар эхэлдэг. Бид хангалттай эрхтэй боллоо, хариуцлагын тухай ярьж хэлдэг хүмүүст хүний эрхийг хүндэтгэх зарчимд багтсан үүрэг хариуцлагыг баталгаажуулах нь үүрэг хариуцлагын тухай шинэ тунхаглал баталсанаас илүү өгөөжтэй гэж би хариулах байна. Цаашлаад энэхүү үүрэг хариуцлагын талаарх яриа эмэгтэйчүүд болон бусад гадуурхагдан дарамтлагдсан бүлгүүд идэвхтэйгээр өөрсдийн эрхээ шаардаж буй үетэй давхцаж байгаа мэт харагддаг. Хэний эрхээр дургин, хэний үүрэг хариуцлагыг хэн ярьж байна ч гэх эргэлзээ төрдөг. Дэлхийн ихэнх эмэгтэйчүүд эрхээ эдлэхээсээ илүү үүрэг хариуцлагад дарагдан амьдарч байна. Магад эрэгтэйчүүдийн үүрэг хариуцлага, тэр дундаа гэр орон дахь тэдний үүрэг хариуцлагын талаар ярих шаардлагатай байгаа ч ихэнх эмэгтэйчүүд, цаашлаад эрэгтэйчүүдийн ч хувьд хүний эрхээ эдлэх, хүний эрхээ шаардах явдал дөнгөж эхлэл төдий байна. Хүний эрх нь үүрэг хариуцлагатай уялдаатай ч, хариуцлагаар эрхийг орлуулшгүй.

1998 онд АНУ-ын эмэгтэйчүүд энэ орны эмэгтэйчүүдийн эрхийн анхны цуглааны үр дүн болсон Сенекэ Хүрхрээний үзэл Бодлын Тунхаглалын 150 жилийн ойг тэмдэглэсэн билээ. Энэ үйл явдал нь эмэгтэйчүүдийн эрх ба хүний эрх хэрхэн нэгдсэн тухай, эмэгтэйчүүдийн эрхийг биелүүлэхэд юу шаардагдах талаар нэгдмэл ойлголт бий болгох, хувийн орон зай болоод нийгмийн орон зай дахь эрхүүдийг оролцуулан хүний эрх ойлголтыг өргөжүүлэн тэлэх тухай ярилцах боломжийг олгосон юм. Эмэгтэйчүүдийн Хүний Эрхийн Глобал Кампанит Ажил ч энэ тунхаглалыг 1998 онд

тэмдэглэхдээ хүний эрхийг хүндэтгэх соёлыг үүсгэх нь эмэгтэйчүүдийн эрхийг дотоодод ба гадаадад хүндэтгэхээс ихээхэн шалтгаална гэдгийг цохон тэмдэглэсэн.

Өнгөрсөн арван жилийн турш эмэгтэйчүүдийн эрхийн хөдөлгөөний өмнө тулгарсаар ирсэн бэрхшээл бол хүний эрхийн талаар тунгаахын гол учир юунд вэ гэдэг асуултын хариуг олоход байв. Хүний эрхийн тодорхойлт, хэрэгжүүлэлтэд олон учир дутагдал байдаг нь өнөөдрийн бидний мэддэг хүний эрхийн ойлголт нь тодорхой түүхэн цаг үеэс үүдэлтэй ба тэр үеийн нөхцөл байдалд өмч эзэмшигч, цагаан арьстан эрэгтэйчүүдийн амьдрал, ашиг сонирхол үзэл бодол маш их нөлөөлснийг сонгодог жишээ болох франц хэлнээс олж харж болно. Франц хэлэнд хүний эрхийг одоог хүртэл эрэгтэйчүүдийн эрх хэмээн томъёолж нэрлэдэг. Энэхүү томъёололд эмэгтэйчүүдийг хамруулах шаардлага олон удаа тавигдаж байснаас хамгийн эхнийх нь Францын Хувьсгалын үеийн Олимп Дэгүүжийн тэмцэл байсан ба Амнести Интернэшнл ба эмэгтэйчүүдийн хүний эрхийн бүлгүүд шаардлагыг дахин 1998 онд тавьжээ. Хүний эрхийг анхлан шаардаж эхэлсэн гүн ухаантнууд, төрийн зүтгэлтнүүд сүм, төрөөс тэдний хүний эрхэд халдаж байна гэж үзсэнээс хувь хүний үг хэлэх эрх, нэгдэн нийлэх эрх, шашин шүтэх эс шүтэх эрх гэх мэт улс төрийн болон иргэний эрх, эрх чөлөөг голчлон анхаарч ирсэн түүх бий. Тэд институтчлэгдсэн хүйсээр ялгаварлан гадуурхалтын хохирогч байгаагүйгээс энэхүү ялгаварлан гадуурхалтыг хүний эрхийн үндсэн асуудал гэдгийг олж хараагүй. Ихэнхдээ тэд эмэгтэйчүүд болон зарим тодорхой хүмүүсийг хуулийн өмнө ижил тэгш хэмээн үзээгүйгээс шалтгаалан өөрсдийнхөө эдлэх ёстой гэж үзсэн эрхийг тэдэнд хамаатуулаагүй юм.

20-р зууны хүний эрхийн төлөөх тэмцлийг эргэн харахад энэ томъёо нь анхныхаа ойлголтоос халин дэлхийн хүн амын ихэнх, цаашлаад бүхэл хүн төрөлхтний тэмцлийн үг хэл болсныг харж болно. Эрх тэгш байдлыг шаардах, хүний эрхийн тодорхойлолтыг тэлэн хүний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлаж буй байдлыг зогсоож, хүний эрхийг дээдлэх нь 20-р зууны олон нийгмийн хөдөлгөөний гол цөм асуудал байв. Газар бүр өөрсдийн хүний эрхээ шаардаж, хүний эрхийн ойлголтыг тэлэх зорилготой хүмүүс болон бүлгүүдийн явуулсан тэмцэл нь хүний эрх гэдэг ойлголт өнөөдөр ч утгаа алдаагүй өргөжсөөр байгаагийн гол шалтгаан юм. 20-р зууны эхэн хагаст өрнөсөн колоничлолын эсрэг хөдөлгөөнүүд, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах болон апартаидын эсрэг тэмцэж байсан бүлгүүд, уугуул хүн ам болон Латин Америкт үгүй болсон хүн амын төлөөх хөдөлгөөнүүд, эмэгтэйчүүдийн эрхийн хөдөлгөөнүүд бүгд л ардчилал, хүний эрхийг багтаасан нийгмийн гэрээнээс гадна үлдсэн хүмүүсийн хүний эрхийн төлөө хөдөлгөөнд байсан билээ.

Өнгөрсөн арван жилд хүний эрх гэдэг ойлголт яагаад ийм чухал ухагдахуун болж ирэв? Яагаад олон эмэгтэйчүүд яг энэ цаг үед хүний

эрхийн тухай яриаг өрнүүлэх нь нэн чухал гэж үзэв? Ялангуяа Хүйтэн Дайны дараах үед хүн төрөлхтний нийтлэг зүйлсийн тухай ярилцах шаардлага үүссэн. Жишээ нь, 1990-ээд онд НҮБ-ын бага хуралд оролцогчид энэ олон хуваагдал, өөр өөр үзэл баримтлал бүхий дэлхийд амьдрагч биднийг юу нэгтгэж байна гэдгийг тодруулахдаа хүний эрхийн үг хэлийг ашиглаж байв. 1993 онд Веннын Дэлхийн Хүний Эрхийн бага хуралд НҮБ-ын Ерөнхий Нарийн Бичгийн Дарга асан Бутрос Бутрос-Галигийн хэлсэнчлэн “хүний эрх нь шууд хэлбэрээр бид ялгаатай ч бас адил гэдгийг бидэнд зааж буй хүн төрөлхтний нийтлэг хэл юм” гэсэн байдаг. Эдгээр үгс үндэстэн ястны, үзэл суртлын, шашны фундаменталист үзлүүд болон арьсны өнгө, шашин, соёл, итгэл үнэмшил олон хүмүүсийг хагалан хувааж, олон хүний аминд хүрсэн тэр үед гарцаагүй хэрэгтэй байсан юм. Эдгээр хагарал эцэстээ өөртэйгөө адил биш хүнийг өөр буюу бүрэн дүүрэн хүн биш гэж үзэх үзлийг дэвэргэсэн. Эрчүүдийн ноёрхол олон зуунаар давамгайлсаар ирсэн ертөнцөд эмэгтэйчүүдэд өөр гэдэг ухагдахуунаар хандсаар ирсэн учир бүлэг хүмүүсийг хуваан хагалах үзэл, түүнээс үүдэн хүмүүс бие биеэ ад чөтгөр мэт үздэг аюулын талаар эмэгтэйчүүд сайн мэдэж байв. Хүний эрх нь хуваагдмал байдлын эсрэг зогсох нэгдмэл хүн төрөлхтний зөн ба бид бие биедээ хэрхэн хандах ёстой, төр иргэдэд хэрхэн хандах ёстойг илэрхийлсэн наад захын жишиг юм. Энэхүү зөнг амьдрал хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй, учир нь хэрэв зээ л хүний эрхэд тулгуурласан нийтлэг глобал үнэт зүйлсийг бий болгохыг хүсвэл эдгээрийг үүсгэх, тодорхойлох үйл явцад бүх хүмүүсийн оролцох боломжийг хангах ёстой. Соёл, шашин бүр хүнлэг байхыг, хүний мөн чанарыг өөр өөрөөр тайлбарладаг ба эдгээр тайлбар тодорхойлолт нь цагийн аясаар өөрчлөгдөн хөгжсөн билээ. Тэгэхээр бид хүний эрхийг авч үзэхдээ орчин үеийн нийгмийн Барууны эрэгтэйчүүдээс үүдсэн гарлаас нь өргөжүүлж, янз бүрийн соёл уламжлалд хүнлэг байдлыг хэрхэн ойлгосоор ирсэн, биднийг холбох нийтлэг зүйл юу вэ, хүн гэдэг зүйлийн үнэт мөн чанар нь юу вэ гэдгийг дахин тодорхойлон үзэх шаардлагатай болж байна. Хүний эрхийн ойлголтын өмнө тавигдсан нэгэн асуудал нь энэхүү харилцан яриаг аль болох өргөнөөр дэвшүүлэн тавьж, Түгээмэл Тунхаглалд заасан хүний эрхийн хуваагдашгүй нийтлэг хэмээх үндсэн зарчмуудыг алдагдуулахгүйгээр урьд нь сонсогддоггүй байсан хүмүүсийн дуу хоолойг хамруулах асуудал юм. ХЭТТ нь энэхүү харилцан ярианы эхлэх цэг нь мөн, учир нь эдгээр зарчмууд нь хэчнээн цаг үетэйгээ холбоотой ч арьсны өнгө, жендерийн ойлголтод өнгөрсөн хагас зуун жилийн дэвшил, онолыг хамруулж, тунхаглалд заасан хүний эрхийн олон талыг одоо л биетжүүлж ярих цаг болсон. Хүний эрхийн ойлголтын талаарх өөр нэг онцлог нь хүний эрхийг биелүүлэхэд төрөөс болон олон нийтээс хариуцлага шаарддаг тогтолцоо юм. Жишээ нь, ХЭТТ-ын 28-р зүйл “Хүн бүр энэхүү Тунхаглалд заасан эрх, эрх чөлөөг бүрэн эдлэж болохуйц нийгмийн ба олон улсын дэг журамд амьдрах эрхтэй” гэжээ. Тунхаглалд цааш хүн бүр хүний эрхээ

бүрэн хэмжээгээр эдлэх нөхцөлийг засгийн газрууд болон хувь хүмүүс бүрдүүлэх үүрэгтэйг заажээ. Эдгээр эрх бол хийсвэр зүйл биш. Эдгээр эрх нь засгийн газар бүр, олон нийт бүр хамгаалан дэмжих хариуцлага хүлээсэн эрх ба хувь хүн бүр эдгээрийг дээдлэх ёстой юм. Хүний эрхийн хэл нь хүнлэг энэрэнгүй нийгмийг бүтээх үндэс болсон үүрэг хариуцлагын талаар ярилцах хэл. Хүн бүр хүний эрхээ бүрэн дүүрэн эдлэх, хүний мөн чанараа бүрэн дүүрнээр эдлэхийн төлөө үйл явцад бид бүгд хариуцлага үүрч, эдгээрийг хэрэгжүүлэх нөхцөл байдлыг хамтдаа үүсгэх ёстой гэсэн хүнлэг итгэл эрмэлзэл юм.

Эмэгтэйчүүдийн хувьд хүний эрхийн зарчмуудыг өөрсдийн туршлага амьдралын үүднээс тайлбарлан тодорхойлж, тэгснээр хүний эрхийн тухай ухагдахууныг тэлэх нь олон талт зүйлсийг хамруулсан хүний эрхийн ойлголтыг цогцлоход түлхэц үзүүлэх нэн чухал үйл явц мөн. ХЭТТ-д тусгасанчлан “Энэхүү Тунхаглалд заасан эрх, эрх чөлөөг арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төр болон өөр үзэл бодол, үндэс, яс, нийгмийн гарал үүсэл, өмч, төрөлхийн болон бусад статусаас үл хамааран ямарваа ялгаварлалгүй хүн бүр эдлэх ёстой.” Тунхаглалын анхны төслүүдэд хүйсээр ялгаварлан гадуурхахгүй гэсэн заалтыг оруулаагүй байсан ба тунхаглалын төслийг боловсруулах үед эмэгтэйчүүдийн тууштай оролцооны ачаар тунхаглалд хүйсээр үл ялгаварлан гадуурхах заалт багтсаныг энд дурьдах нь чухал юм. Үл ялгаварлан гадуурхах нийтлэг зарчим энэхүү тунхаглалд багтсан хэдий ч энэхүү тунхаглалын үг хэл болон тунхаглалд багтсан жишээнүүд тэр үеийн эрэгтэйчүүдийн үзэл бодол, ашиг сонирхлыг тусгасан байдаг. Эдгээр эрхийг өнөөдөр хэрхэн тайлбарлан тодорхойлж байгаа, хэрхэн эдгээрийг хамгаалж байгааг тэлэх нь бидний оролцууштай асуудал болоод байна. Олон улсын хүний эрхийн тогтолцоонууд болон засгийн газрууд, олон нийт ямар хүний эрхийг хэрэгжүүлж байгаагаар одоогийн хүний эрх тодорхойлогдож байна. Хүний эрхийн ойлголт хэрхэн хөгжсөөр ирснийг ойлгох нь хүний эрх гэдэг зүйл зогсонги зүйл биш, харин ч байнга хөгжиж өөрчлөгдөж, хөдөлгөөнд оршдог зүйл гэдгийг ойлгоход нэмэр болох ач холбогдолтой. Хүний эрх нь нэг мөсөн бүх хүмүүсийн хувьд үүрдийн үүрд тодорхойлогдон зурагдсан зүйл биш, хүн гэдэг үнэт зүйлийн мөн чанарт юуг голчлох ёстойг тодорхойлоход нийгмийн оролцоо, харилцан яриа байнга шаардагддаг үргэлжийн үйл явц мөн. Хүний эрх нь иргэний болон шашны бүлгүүд нэгдэн цуглаж, бид хамтдаа амьдарч ажиллахад бие биенийхээ өөр байдлыг хүндлэхийн зэрэгцээ өөр байдлыг нь далимдуулан эрхийг нь хязгаарлалгүй ямар нийтлэг ёс суртахуун, ёс зүйг дээдлэх ёстойг ярилцах ёс суртахуун, ёс зүйн үндэс, орон зай байх ёстой юм.

Эмэгтэйчүүдийн амьдралын үүднээс хүний эрхийг тайлбарлах нь жендерийн үндэслэлтэй хувийн болон олон нийтийн орон зайд явагддаг харгислалыг хүний эрхийн үүднээс хэрхэн авч үзэх ёстойг харуулдаг. 1990-ээд онд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл болон өөрсдийн бие организмын

нөхөн үржихүйг хянах эрхгүй байсныг эмэгтэйчүүдийн үндсэн хүний эрхэд халдсан явдал хэмээн баримтжуулалт хийхэд ихээхэн анхаарсан. Түүнчлэн эмэгтэйчүүдийн хэмээн нэрийддэг асуудлууд болон хөгжил, энх тайван, хүний эрх болон бусад нийгмийн үндсэн асуудлын хоорондын уялдаа холбоог олон судлаачид жендэрийн тухай феминист онол, дүн шинжилгээг ашиглан гаргаж ирсэн. Төрөл бүрийн нийгмийн асуудлыг жендертэй холбоод үзэхэд хэрэв хүн амын тэн хагасын дуу хоолой оролцоогүй бол хүний аюулгүй байдал, энх тайван, хүнлэг энэрэнгүй нийгэм, байгаль орчинд хөнөөлгүй хөгжил, шударга ёс гэх мэтийг бий болгох боломжгүй нь харагдана. Цаашлаад харгис бус нийгмийг бүтээхийн төлөө явж буй хүмүүс, милитаризмыг зогсоох, ястан үндэстэн хоорондын зөрчил мөргөлдөөнийг дуусгавар болгохыг хүсэгчдийн хувьд гэр оронд нь явагдаж буй хүчирхийлэл эдгээр зорилгыг нь дарагдуулдаг. Тодорхой нийгэмд хүчирхийллийн соёл бий болсон байвал нийгмийн цөм болох гэр орон дахь хүчирхийллийг тэвчих байдал үүсдэг гэсэн холбоог цаашид ч судлуштай томоохон сэдэв мөн. Гэр орондоо хүчирхийлэлд өртдөг эмэгтэйчүүд ийм айдас, харгислалаас ангид амьдрах эрхтэйг тунхаглалын 3-зүйлд “Хүн бүр амьдрах, чөлөөтэй байх, бие сэтгэлийн аюулд өртөхгүй байх эрхтэй” хэмээн эргэлт буцалтгүй заасныг саная. Мөн 5-р зүйлд “Хэн ч эрүүдэн шүүх, хүнлэг бус, хүний мөн чанарыг доромжлон гутаасан байдал, цээрлүүлэлтэд өртөх ёсгүй” гэснийг саная. Дэлхийн эмэгтэйчүүдийн 40-өөс 60 хувь нь гэр орондоо иймэрхүү хүчирхийлэлд өртөж байдгийг харвал энэ нь дэлхийн орон бүрт явагдаж байгаа хүний эрхийн томоохон зөрчлийн нэг хэлбэр болж байна. Ийм түвшинд байгаа хүний эрхийн зөрчил нь хүний эрх дээдлэгддэг гэсэн ойлголтыг бүхлээр нь үгүйсгэнэ.

Цаашлаад гэр орон дахь хүчирхийлэл харгислал болон хүйсээр ялгаварлан гадуурхах нөхцөл нь өөр салбарууд дахь эрх тэгш бус байдал, хүний эрхийн зөрчлийг хүлээн зөвшөөрөх үндэс суурь болдог. Ийм харгислал ба хэн нэгэн хүнийг доорд үзэх байдал хүүхдүүдэд энгийн, байх ёстой зүйл хэмээх ойлголтыг төрүүлдэг анхны хүний эрхийн зөрчлийн жишээ болдог. Хэн нэгнийг дарамтлан ноёрхох, охид хөвгүүдэд ялгаатай хандах гэх мэт бусдыг ялгаварлан гадуурхах нь хэн нь эрх мэдэлтэй, хэн нь эрх мэдэлгүй талаар хүүхдэд анхны том сургамжийг өгдөг. Ихэнх хүүхдүүдийн хувьд алив зөрчил болоод хүмүүсийн үзэл бодлын ялгааг хүчирхийллээр зохицуулдаг гэсэн анхны хичээл ч болдог. Хүний эрх, дэлхийд энх тайвныг цогцлоохын төлөө ажиллаж буй бүх хүн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл харгислалыг зогсоож гэмээн хүнлэг энэрэнгүй нийгмийг бүтээх үйл явцад дэвшил гарна гэдгийг ойлгох шаардлагатай. Бид дотоодын болон олон улсын зэвсэглэлийг зогсоохыг шаардах ёстой. Чилийн эмэгтэйчүүд улс төрийн дарангуйллын эсрэг тэмцлийнхээ үеэр хэлсэнчлэн “*Democracia in el pais y en la casa*” (гэр орондоо ч, улс орондоо ч ардчилал).

Хүний эрхийг феминист үзлээр тайлбарласныг хүнлэг энэрэнгүй нийгэмтэй уялдуулан авч үзэхийг гэр бүл хэмээх асуудал дээр тодорхой харж болно. Эмэгтэйчүүдийн хүний эрхийн идэвхтнүүд гэр бүлийн эсрэг үзэлтэй хүмүүс биш. Гагцхүү гэр бүл нь тэр бүтэц дэх бүх хүмүүсийн хүний эрхийг хүндэтгэн хүлээн зөвшөөрсөн сонголт хийж болохуйц орон зай байгаасай гэдгийг бид шаарддаг. Хэрэв зээ бид ардчилсан, энх тунх ертөнцийг бүтээхийг хүсч байгаа бол гэр бүл нь ноёрхол, хүчирхийлэл бус, харин ардчилал, энх тунхын гол байршил болох ёстой. Гэр бүл эмэгтэйчүүдийг дарлах үзэлд үндэслэх ёсгүй. Гэр бүлийн гишүүдийн хувь хүнийх нь хүний эрхийг бүлгийн эрхтэй тэнцвэржүүлэхийг голчлон эмэгтэйчүүдийн эрхийг золиослосноор хийх ёсгүй. Эмэгтэйчүүд хүүхдүүдийн эрх болон гэр бүл дэх эрэгтэйчүүдийн эрхийг хүндэтгэсэн, эрхийг бүрдүүлсэн нийгмийн бодлого бидэнд хэрэгтэй байна. Ихэнх орнуудын нийгмийн бодлогыг авч үзвэл гэр бүл дэх хүмүүс хүний эрхээ эдэлдэг загвар дээр суурилаггүй байдаг. “Гэр бүлийн үнэт зүйлс”-ийг хадгалан хамгаалах яриа их байдаг ч тэдгээр үнэт зүйлс нь юу вэ гэдгийг шүүмжлэлтэйгээр тунгаах шаардлагатай. Хүнлэг энэрэнгүй нийгэм дэх гэр бүлийн ирээдүй нь харгис бус, эрх тэгш, олон ургальч боломжуудыг цогцлоож чадахаас хамаарна. АНУ-ын нийгмийн бодлого нь гэр бүл болох, гэр бүлээр амьдрах явдлыг хэрхэн хязгаарладаг талаар нэгэн жишээ авч үзье. ДОХ-ын аюулын хариуд лесбиан, гей олон нийт бүс нутаг, үүсэл гарал, амьдралын хэв маягийг үл хайхран нэгэн зэрэг, нэгдмэл олон нийтээр хөдлөн өвдөж, үхэж буй хүмүүсийг халамжлах, нийгэмд болон олон нийтдээ энэхүү өвчний аюулын талаар ойлголт бүрдүүлж эхэлсэн билээ. Энэ хариу нь төгс төгөлдөр байгаагүй ч анги, арьсны өнгө, жендерийн ялгааг үл хайхран бие биеэ хайрлах халамжлахад олон хүмүүс оролцсон. Мах цусны гэр бүлүүд нь татгалзсан ижил хүйстэн хүмүүс хүнлэг энэрэнгүйн зарчим дээр ижил хүйсийн гэр бүлүүдийг бий болгосон тэр үед гэр бүлийн төлөө хэмээн шуугьдаг энэ оронд эдгээр гэр бүлүүдийг хүлээн зөвшөөрөлгүй, тэдэнд саад тотгор болсон. Хүмүүс үхэж байхад бодлого боловсруулагчид ижил хүйсийн гэрлэлтийг ямарваа нэгэн аргаар хорихыг хүсч, урт хугацаагаар үнэнчээр хамтдаа амьдарсан ижил хүйсийн гэр бүлүүдэд эрүүл мэндийн хамтын даатгал гэх мэт зүйлсийг өгөхгүй байсаар байна. Бие биедээ хайртай насанд хүрсэн хүмүүсийн хоорондын хайрыг үгүйсгэж, шинэ төрлийн гэр бүлийг нураах гэсэн засгийн газрын оролдлого ямар үнэт зүйлс дээр тогтож байгааг хэн ч өөрөөсөө асуух ёстой, учир нь засгийн газрын энэ бодлого хүнлэг энэрэнгүй бус зүйл. Олон нийгмийн бодлогын дотор агуулагддаг хүний эрхийн асуудлыг шүүмжлэлтэйгээр авч үзэх цаг иржээ. Хүний эрх бол хийсвэр ухагдахуун биш. Хүний эрх нь бид ямар дэлхийд амьдрахыг хүсч байна, хүмүүсийн хооронд ямар харилцаа байх ёстой тухай эрмэлзэл, хүн бүрт олгогдох ёстой хүндэтгэл, олон нийт бүрт дэмжин хөхүүлэх ёстой нийгмийн харилцааны

үндэс юм. Даяарчлалын эрин үед хүний эрхийн жишиг нь Дэлхийн Банк, Олон Улсын Валютын Сан, Нэгдсэн үндэстний Байгууллага болон транснационал корпорациуд гэх мэт глобал байгууллагуудаас бид хүн, олон нийт утгаараа юу шаардах ёстой гэсэн асуудал ч жишиг болох ёстой. Хүний эрх нь корпораци, засгийн газар болон засгийн газар хоорондын байгууллагуудын бодлого, үйл ажиллагаанд гол жишиг байх ёстой. Энэ нь цаашлаад яагаад хэрхэн эдгээр тогтолцоонуудын бодлого, үйл ажиллагаа хүний амьдралын наад захын үнэт зүйлст халдаж байгааг, эдгээрийн хариуцлагыг тэдэнтэй хэрхэн тооцох талаар ярилцах үндсийг бүрдүүлнэ.

Эцэст нь түгээмэл нийтлэг ба салшгүй хуваагдашгүй хэмээх ухагдахууныг эмэгтэйчүүдийн амьдралын үүднээс авч үзье. Түгээмэл нийтлэг хэмээх ухагдахуун нь тодорхой соёл, шашнаас шалтгаалан эрхээ эдлэж чаддаггүй эмэгтэйчүүдэд нэн ялангуяа хамаатай. Түгээмэл нийтлэг гэдэг нь бүгд ижил байх байдал, эсвэл өөр өөр зүйлийг хүндэтгэхгүй гэсэн үг биш. Хүн бүрт байдаг үндсэн үнэт зүйлийг өөр өөр хэлбэр маягаар илэрхийлж болох ба бие биеийнхээ нийтлэг хүн мөн чанарыг хүлээн зөвшөөрч, хэнд ч дарлагдалгүйгээр бүрэн дүүрэн хүн шиг амьдрах хэрэгцээнд үндэслэснийг түгээмэл нийтлэг зарчим гэнэ. Хуваагдашгүй хэмээх ухагдахуун нь ч мөн олон нийтийн амьдрал нь хувийн болоод нийгэм эдийн засгийн хүчин зүйлээр тодорхойлогддог эмэгтэйчүүдэд маш их хамааралтай. Хуваагдашгүй гэсэн зарчим нь бүх эрхийн хоорондох уялдаа холбоог тэмдэглэдэг зарчим. Нийгэм эдийн засгийн эрхүүд, иргэний болон улс төрийн эрхтэй уялдаатай байдагчлан аль нэгэн эрх нь нөгөөгөөс давуу байр суурьтай байдаггүй. Тэр утгаар эмэгтэйчүүдийн ч эрх хоорондоо уялдаа холбоотой. Эмэгтэйчүүдийн хүний эрх нь бусад хүний эрхтэй нягт уялдаатай, тэднээс салшгүй, хуваагдашгүй байдаг тул хүний эрхийг бүхлээр нь үгүйсгэх гээгүй л бол эмэгтэйчүүдийн эрх нь хоёрдогч эсвэл чухал биш гэсэн томъёололд багтах ёсгүй. Хүний эрхийг хүндэтгэсэн соёлыг эмэгтэйчүүдийн хүний эрхгүйгээр цогцлоох боломжгүй, учир нь хичнээн цөөн ч хэрэв нэгэн бүлэг хүмүүсийн хүний эрх зөрчигдөж байвал бүх хүмүүсийн хүний эрх зөрчигдөж, багасч байдаг. Хүний эрх нь хорин нэгдүгээр зууны хүнлэг энэрэнгүй нийгмийг цогцлоохын төлөө яриаг эхлүүлэх гүүр болох боломж байна. Гагцхүү энэ гүүр нь бүгдийн эрхийг хамруулсан тохиолдолд л, бүх хүмүүст тэр гүүрээр алхах боложийг олгосон тохиолдолд л жинхэнэ гүүр болж чадна.

Шарлот Банч нь “Дүрэлзсэн Улс Төр: Феминист Онол Амьдрал”, “Хариуцлагыг Шаардах нь: Глобал Кампани болон Эмэгтэйчүүдийн Хүний Эрхийн Веннын Трибунал” зэрэг бусад олон ном зохиолоороо олонд танил болжээ.

Шарлот Банчийн дээрхи өгүүллийг 2002 онд Эмэгтэйчүүдийн сургалтын түншлэл байгууллагаас гаргасан Афками Маназын эмхэтгэсэн “Хүнлэг энэрэнгүй нийгмийн зүг” номноос хэвлэв.



НҮ ХХ нь илүү өндөр амьдрал, нөөцийн хангамж, улс орнуудын өмнөх ач холбогцлыг олон нийтийн хамтын ажиллагаагаар замаар илүү сайн амьдралыг амьдралын доголлон байгуулахад хамт туслах зорилго бүхий НҮ -ын дэлхий нийтийн хөгжлийн сэлжээ юм.

Эрхэм Уншигчид аа!

Та бүхэн манай сэтгүүлийн талаарх санал, үзэл бодлоо доор хаягаар ирүүлнэ үү.

Хүний Эрхийн Үндэсний Комисс

Хаяг: Улаанбаатар хот, Эрх чөлөөний талбай, Засгийн газрын XI байр, 5 дугаар давхар

Утас: 318082, 262971

Факс: 262971, 320284

Цахим шуудан: contact@nhrc-mn.org

Цахим хуудас: <http://www.mn-nhrc.org>